

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# ХҮНИЙ ЭРХ

---

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр,  
эрхийнхээ хувьд адил тэгш байна...”

---

(12 дахь жилдээ)

2013/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2013/01(41)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
12 дахь жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор /ХЭҮК-ын гишүүн/  
Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах референт/

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн  
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн  
зохиогчийн үзэл бодол болно.

## АГУУЛГА

**ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ***П.Оюунчимэг (PhD)*

Хүний эрхийн үндэсний байгууллага нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизм болох нь..... 4

*Dr Matthew Pringle*

The Implementation of the OPCAT in Mongolia.....

*Мэтью Прингл (ScD)*

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах буюу шийтгэхийн эсрэг Конвенцийн Нэмэлт протоколыг Монгол Улсад хэрэгжүүлэх нь ..... 7

*Р.Оюунбадам (докторант)*

Шорон дахь эрүү шүүлт..... 28

*Г.Агар-Эрдэнэ (докторант)*

НҮБ-ын эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд дэлхийн улсууд нэгдэн орсон нь..... 36

*Б.Алтантуяа*

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээг хэрэгжүүлэхэд гарч буй нийтлэг алдаа, холбогдох зөвлөмж, тухайлан Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуурыг сайжруулах талаар зөвлөх нь ..... 42

*Г.Оюунболд*

Хууль сахиулах үйл ажиллагаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нь..... 51

*Б.Батаа*

Эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгана ..... 55

**МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА***Никола Жайгерс*

Эмнести интернэшнл болон үндэстэн дамнасан компаниуд 2061 онд орчуулсан О.Гомбожав ..... 63

**ЗОЧНЫ ЯРИА**

УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны чиглэлийн ахлах мөрдөн байцаагч М.Гэрэлбадрахтай хийсэн ярилцлага..... 79

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦ**

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоол ..... 84

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол (Албан бус орчуулга) ..... 86

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА НЬ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ МЕХАНИЗМ БОЛОХ НЬ



Хүний эрхийн Үндэсний Комиссын  
гишүүн, Хууль зүйн ухааны доктор

### П.ОЮУНЧИМЭГ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тавиндолдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг баталж, 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энд зааснаар олон улсын болон үндэсний бие даасан байгууллага эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн байгаа газарт нь тогтмол эргэж очих тогтолцоог бий болгоход энэхүү конвенцийн зорилго оршиж байхаар заасан байна. Конвенцийн 3 дугаар зүйлд зааснаар оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон

харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх /цаашид “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага” гэнэ/ зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээхээр зохицуулсан байна.

Үүний дагуу конвенцид нэгдэн орсон улс орон бүр протокол хүчин төгөлдөр болсноос, эсхүл түүнийг соёрхон баталснаас, эсхүл түүнд нэгдэж орсноос хойш нэг жилийн дотор оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг болон түүнээс дээш байгууллагыг байгуулах, томилох ёстой бөгөөд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх нөхцлөөр хангагдсан байх ёстой.

Хүний эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий Парисын зарчмын дагуу байгуулагдсан үндэсний байгууллагууд нь Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизмыг байгуулах үйл явцад дараах үүрэгтэй оролцож байна.

Үүнд:

- нээлттэй, багтаасан, оролцооны үйл явц
- зурагласан, одоо байгаа болон бий болох гэж буй механизмууд болон эдгээр механизмуудын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нийцэж буй байдал
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын Ажлын хэсэг аль эсвэл Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын бүлэгт орж ажиллах
- Хүний эрхийн үндэсний байгууллага нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нийцэх болон чадавхийн /Рабат Тунхаглал<sup>1</sup>/ асуудлаар өөрсдийгөө дүгнэх нарийвчилсан үнэлгээг явуулж болно

Хүний эрхийн байгууллагуудаас дэлхийн улс орнууд 39 төрлийн Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизмыг нэрлэсэн буюу томилсон байдаг бөгөөд эдгээрээс 28 нь одоогийн байдлаар үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. Улс орнууд өөрсдийнхөө нөхцөл байдалд тохируулан шинээр бие даасан хараат бус хөндлөнгийн байгууллага байгуулах, хүний эрхийн үндэсний байгууллага дээрээ түшиглэн хавсарсан хэлбэртэйгээр ажиллуулах, омбудсманы эрхлэх ажлын хүрээнд хавсарган гүйцэтгүүлэх, олон талт төлөөллийг

<sup>1</sup> Африкийн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Чуулга уулзалт, Rabat, 3-5 November 2009, RABAT DECLARATION. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газрын дэмжлэгтэйгээр Африкийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын сүлжээний хамтын ажиллагааны хүрээнд “Энх тайван ба Шударга ёс: Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үүрэг” сэдэвт чуулган болсон.

- Хүний эрхийн зөрчлүүдийг олж тогтооход шилжилтийн үеийн шударга ёсны механизмтай хамтран ажиллах ба хүний эрхийг хэтрүүлэн ашиглах талаар баримтжууулалт, мэдээлэл цуглуулахад оролцох,
- Аливаа шилжилтийн үеийн шударга ёсны механизмыг бий болгох болон үйл ажиллагаа явуулахдаа олон улсын хүний эрхийн стандарт, практикт нийцүүлэх, гэх мэт

оролцуулсан хэлбэртэйгээр байгуулсан байдаг. Одоогийн байдлаар Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг шинээр байгуулсан 10 улс, хүний эрхийн үндэсний байгууллага дээрээ хавсарч байгуулсан 20 улс, омбудсманы эрхлэх ажлын хүрээнд хавсарган ажиллуулж буй 5 улс, олон талт хэлбэрээр байгуулсан 4 улс байна.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг хүний эрхийн үндэсний байгууллагуудад байгуулан ажиллуулахад хэд хэдэн давуу талтай байдаг. Нэгэнт тогтмолжсон үйл ажиллагаа явуулж байгаа, үйл ажиллагааных нь гол чиглэл болсон салбар хамрагддаг учраас өөрсдийн туршлага дээрээ үндэслэн үргэлжлүүлж энэ ажлыг зохион байгуулахад тэр болгон хүндрэлүүд гардаггүй. Дотоодын хууль тогтоомжуудад нийцүүлэн ажиллаж буй үндэсний байгууллагуудад бусад хуулийг хэрэглэх хүрээ нэмэгддэг ба асуудлыг аль нэг талд ашигтай байдлаар шийдвэрлэх гарц нэмэгддэг байна.

### **Хүний Эрхийн Үндэсний Байгууллага нь цор ганц Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байх нь**

2008 оны 10 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд Кени Улсын нийслэл Найроби хотноо Хүний эрхийн үндэсний байгууллагуудын 9 дэх удаагийн чуулган болжээ. Уг чуулганыг Кени Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар, Олон Улсын Зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан болно. Уг хурлаас “Найробийн тунхаглал” хэмээх баримт бичгийг батлан гаргасан бөгөөд тунхаглалд заахдаа хүний эрхийг хязгаарладаг хорих болон бусад газруудад хоригдогчийн бүхий л эрхийг баталгаатай эдлүүлэх ёстойг онцлон тэмдэглэсэн байна.

Уг тунхаглалын 39 дүгээрт “Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц болон түүний Нэмэлт Протоколд нэгдэн ороход Засгийн газартаа нөлөөлөх, гагцхүү шаардлагатай бүрэн эрх, нөөц бололцоо байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хэлбэрээр ажиллах тухайд анхаарч үзэх нь зүйтэй.” гэж заажээ.

Мөн 41 дүгээр зүйлд “Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь Засгийн газартайгаа хамтран эрх чөлөөг хязгаарлах газарт буй хүмүүс хүний эрхийн зөрчлийн талаар, тэр дундаа хүний эрхийн үндэсний байгууллагад гомдол гаргах, хэрэв зөрчил тогтоогдсон тохиолдолд тухайн эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүний эрхийг сэргээн эдлүүлэх, хохирлыг нөхөн төлөх боломжийг бий болгоход анхаарч ажиллах нь зүйтэй.” гэжээ. Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагуудын хувьд Парисын зарчимтай үйл ажиллагаагаа нийцүүлэхээс гадна нэгдэн орж буй Эрүү шүүлтийн эсрэг конвенцийн нэмэлт протоколд заасан заалтуудтай үйл ажиллагаагаа нийцүүлэх зайлшгүй шаардлагатай.

Түүнээс гадна хуулиар тогтоосон хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндсэн үйл ажиллагаанаас гадна нэмэлт чиг үүрэг шинээр орж ирж байгаатай холбогдуулан бүтцийн шинэчлэлт хийх дадлага туршлагатай мэргэшсэн боловсон хүчин ажилтнуудыг тухайн нэгжид ажиллуулах ёстой ба тухайн улсын нутаг дэвсгэрт хаана ч үйл ажиллагаагаа саадгүй явуулах, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй тогтмол явуулахад чиглэгдсэн санхүүгийн бүрэн боломжтой байхыг шаарддаг.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хүрээнд ажиллахад тухайн

байгууллагын олон нийгэд танигдсан хүлээн зөвшөөрөгдсөн байдалд нь илт сайн нөлөө үзүүлэхээс гадна үйл ажиллагааных нь нэг чиглэл болж байсан цагдан хорих ангиуд болон төвлөрсөн хорих ангиудад шалгалт хийж байсан туршлага, хууль хяналтын, олон нийтийн мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлагдгаараа онцлогтой байдаг.

Энэ механизмийн хүрээнд үндэсний байгууллагуудын хувьд давуу тал байдгийн хэрээр бэрхшээлтэй тал байдгийг энд дурдахгүй өнгөрч болохгүй. Ихэнх хүний эрхийн үндэсний байгууллагууд өргөн мандаттай байдаг боловч хязгаарлагдмал нөөцтэй байдаг нь энэ ажлыг явуулахад зарим талын хүндрэлүүдийг бий болгодог. Мөн санхүүгийн хувьд хараат бус, хангалттай санхүүгийн чадавхитай байх нь маш их нөлөөтэй бөгөөд тухайн улс орны хүний эрхийг хязгаарладаг ямар ч байгууллага дээр цаг алдалгүй шуурхай очиж ажиллах нөхцлийг шаарддаг. Санхүү талын энэ бэрхшээлтэй асуудлаас гадна хүний нөөц ажилтнуудын мэргэжил, мэргэшсэн, тогтвортой байдал нь чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах хэрэгтэй болдог.

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан аливаа шийтгэл ногдуулах, үүрэг өгөх, шийтгэл ногдуулах эсхүл эдлүүлэхийг зөвшөөрөх ёсгүй. Тухайн хувь хүн, байгууллагыг ямар нэгэн байдлаар хавчих ёсгүйгээс гадна энэ байгууллагын цуглуулсан мэдээллийг ил тод болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүйг байнга мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байдаг.

## THE IMPLEMENTATION OF THE OPCAT IN MONGOLIA

### ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХАРГИС ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР, НЭР ТӨРИЙГ НЬ ГУТААН ДОРМЖИЛЖ ХАРЬЦАХ БУЮУ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

#### DR MATTHEW PRINGLE



*Matthew Pringle is a British national and has been working at the Geneva-based Association for the Prevention of Torture (APT) since January 2004. He is the organization's Europe and Central Asia Programme Officer, which additional responsibility for Mongolia. Before joining the APT he worked as a Researcher in the Europe and Central Asia Programme of the International Secretariat of Amnesty International in London for five years from 1999 to 2003. Prior to Amnesty International he completed a doctorate in the political sciences at Brunel University in London. He has a command to varying degrees of the English, Russian, German and French languages.*

*Мэттью Прингл нь Британи хүн бөгөөд Женев хотноо байрлах Эрүү шүүлтээс урьдчилсан сэргийлэх нийгэмлэгт 2004 оны 1 дүгээр сараас хойш ажиллаж байна. Тэрээр тус байгууллагын Европ болон Төв Азийн хөтөлбөрийн ажилтан бөгөөд Монгол Улсад хэрэгжүүлэх хөтөлбөрийг ч мөн хариуцдаг болно. Тус байгууллагад ажиллахаас өмнө тэрээр Лондон хот дахь Эмнести Интернэшнлийн Олон улсын нарийн бичгийн газрын Европ болон Төв Азийн хөтөлбөрийн судлаач мэргэжлээр 1999-2003 оны хооронд таван жил ажиллаж байсан. Эмнести Интернэшнлд ажиллахаасаа өмнө тэрээр Лондонгийн Брунел Их Сургуульд улс төрийн шинжлэх ухааны доктор зэрэг хамгаалсан. Тэрээр Англи, Орос, Герман, Франц хэлний мэдлэгтэй хүн юм.*

## Introduction

In November 2012 the author of this article was fortunate to be invited to participate in a regional Europe-wide meeting on the implementation of the Optional Protocol to the UN Convention against Torture or OPCAT in the Black Sea city of Odessa, Ukraine.<sup>2</sup> During the morning of day one of this two-day gathering the Deputy Ombudsman of Serbia, Miloš Janković, who is also Head of the country's National Preventive Mechanism (NPM) under the OPCAT, spoke about the operation of his mechanism.<sup>3</sup> While the Deputy Ombudsman's presentation was highly interesting, it was only when he projected a few photographs onto a screen, depicting the human rights violations he had uncovered in the course of visiting various prison facilities in Serbia, did it really impact on parts of the audience how crucially important the activities of NPMs are, both in Serbia and elsewhere.

In one depressing photograph the severely bruised back of a male prisoner was shown who had allegedly been heavily beaten by prison staff. Regrettably, the Prosecutor General's Office had declined to investigate the incident for reasons known only to it. In another photograph, three open shower cubicles were depicted next to a busy prison corridor, where inmates were forced to shower naked in front of numerous passers-by. In another, a man could be seen lying on a filthy mattress on the ground of an overcrowded prison cell underneath the

## Удиртгал

2012 оны 11-р сард энэхүү нийтлэлийг бичигчийн хувьд Хар тэнгисийн эрэг дээрх Украин улсын Одесс хотноо болсон НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын хэрэгжилтийн талаарх Европын бүсийн уулзалтад уригдан оролцох завшаан тохиосон юм.<sup>2</sup> Энэ хоёр өдрийн арга хэмжээний эхний өглөө Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын дагуу мандат олгосон тус улсын үндэсний урьдчилан сэргийлэх механизмын тэргүүн болох Сербийн Дэд Омбудсман Милош Янкович өөрийн тэргүүлж буй механизмын үйл ажиллагааны талаар танилцуулав.<sup>3</sup> Дэд Омбудсманы илтгэл сонирхолтой байсан ч түүнийг дэлгэцэн дээр Сербийн олон шоронгуудад шалгалт хийх явцдаа илрүүлсэн хүний эрхийн зөрчлүүдийг харуулсан хэдэн гэрэл зураг гаргах үед л Сербд төдийгүй бусад газар урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үйл ажиллагаа ямар чухал ач холбогдолтой болохыг оролцогчдод мэдрүүлэх шиг болсон юм.

Нэг зураг дээр шоронгийн ажилтнуудад зодуулсан бололтой нэг хоригдлын нуруун дээрх сорвийг үзүүлсэн байв. Харамсалтай нь Ерөнхий Прокурорын Газар тодорхой шалтгаан хэлэлгүйгээр уг хэргийг шалгахаас татгалзсан байна. Өөр нэг зурагт шоронгийн хонгилоор өнгөрөх олон хүний нүдний өмнө хоригдлууд задгай шүршүүрт орж байгааг харуулжээ. Мөн ачаалал хэтэрсэн шоронгийн өрөөнд гурван давхар төмөр орны доод давхарынх нь доор шалан дээр дэвссэн бохир гудсан дээр хэвтэх нэгэн хүнийг харуулав. Эдгээр нь Европын Холбоонд элсэхээр горилж буй Сербийн бодит байдлыг 2012 оны намар харуулсан зургуудын цөөн хэдийг нь л сонгон харуулсан нь тэр байлаа. Талархууштай нь мөн энэ нь Сербийн

<sup>2</sup> Optional Protocol to the United Nations Convention against Torture and Other, Inhuman and Degrading Treatment or Punishment, UN Doc. A/RES/57/199, 18 December 2002.

<sup>3</sup> For more information please see: <http://www.zastitnik.rs/>

<sup>2</sup> Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь гутаан доромжилж харьцах буюу шийтгэхийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцийн Нэмэлт Протокол, НҮБ-ын Баримт бичиг A/RES/57/199, 2002 оны 12-р сарын 18.

<sup>3</sup> Цаашид <http://www.zastitnik.rs/> хаягаас үзнэ үү.



bottom bunk of a three-tier iron bed. These were just a small selection of real-life photographs from Serbia, an aspiring future member of the European Union, in autumn 2012. Thankfully, it is this same reality which the Serbian NPM, like many other NPMs under the OPCAT around the world, are striving to change for the better.

As there are seemingly no end of Optional Protocols to UN human rights instruments these days (this author counted no less than eight), it would be useful to briefly recap at the outset of this paper what is entailed when a country ratifies the OPCAT. Interested readers might also wish to consult the Association for the Prevention of Torture's (APT) website ([www.apt.ch](http://www.apt.ch)) for further detailed information.

In a nutshell, the OPCAT aims to prevent torture and other ill-treatment by establishing a system of regular visits to all places of detention. On the basis of these visits by international and national experts recommendations are elaborated aimed at improving the treatment and conditions of detention of detainees, which are then submitted to the government authorities.

The visits at the national level are undertaken by so-called NPMs or National Preventive Mechanisms (please see below for more details). In addition, visits of States Parties can also be undertaken by an international body of 25 experts, the UN Subcommittee for the Prevention of Torture or SPT. While the reports of visits by NPMs are automatically made public, the reports of SPT visits can only be published upon the agreement of the State Party.

урьдчилан үндэсний сэргийлэх механизм, бусад олон улс орны механизмуудын нэгэн адилаар эерэг өөрчлөлт авчрахаар тэмцэж байгааг харуулж байна.

Өнөөдөр НҮБ-ын хүний эрхийн баримт бичгүүдэд нэмэлт протоколуудыг нэмж баталсаар байгаа (зохиогчийн тоолсноор 8-аас доошгүй) үед улс орон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орсон тохиодолд түүнээс ямар шаардлага үүдэн гардаг талаар энэ хүү нийтлэлийнхээ эхэнд тоймловол хэрэгтэй байх болов уу. Уншигч авгай сонирхвол Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх Холбооны цахим хуудаснаас ([www.apt.ch](http://www.apt.ch)) дэлгэрэнгүй нэмэлт мэдээлэл авч болох юм.

Товчхондоо бол Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол нь эрүү шүүлт болон бусад хэлбэрийн зүй бус харьцаанаас урьдчилан сэргийлэхийн тулд бүх хорих газруудад тогтмол очиж шалгах тогтолцоог бий болгох зорилготой юм. Олон улсын болон үндэсний мэргэшсэн шинжээчдийн хийх эдгээр шалгалтын үр дүн дээр суурилан хоригдогчидтой харилцах харьцаа, тэдний хоригдож байгаа нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжүүдийг боловсруулж, эрх баригчдад өгдөг.

Үндэсний хэмжээнд явуулах шалгалтын ажлыг урьдчилан сэргийлэх үндэсний механизм хэрэгжүүлэх юм. Мөн түүнчлэн мэргэшсэн 25 шинжээчээс бүрдсэн НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд Хороо гишүүн улсуудад айлчлал хийж болно. Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын хийж байгаа шалгалтын тайлан гарсан даруйдаа олон нийтэд ил болдог бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны тайланг гагцхүү гишүүн улсын зөвшөөрснөөр хэвлэн нийтэлдэг юм.

Анх улс орон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орохдоо энэ тогтолцоонд шилждэг. Уг баримт бичиг уншиж ойлгоход тийм ээдрээтэй биш байх атал бодит байдалд хэрэгжүүлэх үед хэд хэдэн бэрхшээл гардаг нь тийм ч давж гаршгүй зүйл биш. Үүний нэг нотолгоо гэвэл 10 жил буюу харьцангуй богино хугацаанд

In essence, countries sign up to this system of visits when they accede to the OPCAT. While the instrument is not a complicated one to read and digest, it does present a few challenges when implementing it in practice, although none of these are in any way insuperable. A testimony to this fact is that, in the relatively short time span of just 10 years, 67 countries across all regions of the globe have already ratified the OPCAT.

### Mongolia and the OPCAT

If Mongolia were to ratify the OPCAT today, it would become the 68<sup>th</sup> States Party to this important human rights instrument.<sup>4</sup> The country would then face the task of putting in place within one year one or more NPMs. The question of Mongolia ratifying the OPCAT is certainly not a new item for discussion in the country. It has been discussed on several occasions over the past five or so years, beginning in April 2008 when the very first national round-table was held on the topic in Ulaanbaatar.<sup>5</sup>

Hypothetically speaking, if Mongolia were to ratify the OPCAT today how would it implement its international obligations under this UN treaty? As the OPCAT text does not prescribe the organisational form of NPMs, each State Party is at liberty to choose the structure most appropriate to its specific national context. In a word, no single type of body is inherently better than any other. What matters most of all is that NPMs work *effectively* to prevent torture and ill-treatment.

<sup>4</sup> As of 9 February 2013 there were 67 States Parties to the OPCAT and 20 Signatories.

<sup>5</sup> The author of this paper first visited Ulaanbaatar to raise awareness about the OPCAT as long ago as August 2005 and, since then, has repeatedly visited the country to do so.

дэлхий бүх бүс нутгаас нийт 67 орон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлаад байна.

### Монгол Улс ба Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол

Хэрэв Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орсон бол энэхүү хүний эрхийн чухал баримт бичгийн 68 дахь гишүүн орон болох байв.<sup>4</sup> Тэр тохиолдолд элсэн орноос хойш нэг жилийн дотор нэг буюу түүнээс дээш тооны үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулах үүрэг хүлээнэ. 2008 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотод анхны үндэсний хэмжээний дугуй ширээний уулзалтаар хөндсөнөөс эхлэн сүүлийн таван жил орчмын хугацаанд хэд хэдэн удаа энэ сэдвээр ярилцаад байна.<sup>5</sup>

Хэрэв Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон баталсан бол НҮБ-ын энэ баримт бичгийн дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх байв гэдгийг төсөөлье. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол нь үндэсний урьдчилан сэргийлэх механизмын зохион байгуулалтын хэлбэрийг тусгайлан заагаагүйгээс гишүүн улс бүрт өөрийнхөө улс орны нөхцөл байдалд хамгийн тохирсон бүтцийг сонгон хэрэглэх эрх нь бий. Нэг үгээр хэлбэл анхнаасаа аль нэг хэлбэрийг бусдаасаа илүү дээр гэж заагаагүй. Хамгийн гол нь үндэсний урьдчилан сэргийлэх механизм нь эрүү шүүлт, зүй бус харьцаанаас бодитойгоор урьдчилан сэргийлж чаддаг байхад оршино.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол үндэний урьдчилан сэргийлэх механизмын ямар бүтэцтэй байвал зохихыг нарийвчлан тодорхойлоогүй ч уг механизмаас ямар үр дүн юу хүлээх ёстой талаар нарийн зааж өгсөн юм. Ялангуяа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн

<sup>4</sup> As of 9 February 2013 there were 67 States Parties to the OPCAT and 20 Signatories.

<sup>5</sup> The author of this paper first visited Ulaanbaatar to raise awareness about the OPCAT as long ago as August 2005 and, since then, has repeatedly visited the country to do so.

While the OPCAT may not spell out the organizational form the NPM should assume, it does go into some detail regarding what is required of the mechanism. In particular, Articles 17 to 23 of the OPCAT text outline a number of fundamental requirements which all NPMs should meet. These include: their functional and financial independence; human and financial resources; diverse expert composition; functions; access to all places of detention, persons detained there and information pertaining to deprivation of liberty; and specific powers and guarantees. For reasons of brevity this paper will not dissect these key OPCAT articles in any great detail, although they will be referred to in passing.

### Global NPM related Practice

Of the 67 current States Parties to the OPCAT, 46 states have officially informed the SPT that they have put in place one or more NPMs.<sup>6</sup> Although there is no singularly best organizationally way of doing so, in practice we can see the following four trends relating to how the OPCAT is being implemented around the world: (1) the designation of an existing body as the NPM, usually a National Human Rights Institution or NHRI; (2) the designation of an NHRI and civil society actors as the NPM; (3) the establishment of a new specialized body as the NPM; and (4) multiple body NPMs. Each individual approach has both advantages and disadvantages, of which countries intending to ratify the OPCAT should be aware. What follows is an overview of the four NPM trends and their related challenges.

<sup>6</sup> As of 9 February 2013.

Нэмэлт Протоколын 17-23 дугаар зүйлд урьдчилан сэргийлэх аливаа механизмын хангах ёстой олон тооны суурь шалгуур үзүүлэлтийг тодорхойлж өгсөн байдаг. Эдгээрт үйл ажиллагааны болон санхүүгийн бие даасан байдал, олон төрлийн мэргэшсэн шинжээчдийн бүрэлдхүүн, тодорхой гүйцэтгэх үүрэг, хорих аливаа байгууламжид нэвтрэх болон тэнд хоригдсон хүн, тухайн хүний эрх чөлөөг хязгаарласан талаарх бүхий л мэдээлэлд хүрэх боломж, тусгайлсан эрх, баталгаа зэрэг орно. Товчхон байхын тулд энэ нийтлэлд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд эдгээр зүйл заалтыг нарийн тоочин тайлбарлахгүй ч хойно товч дурдах болно.

### Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбоотой олон улсын туршлага

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нэгдэн орсон 67 улсаас одоогийн байдлаар 46 нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд албан ёсоор нэг буюу түүнээс дээш тооны үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулсан болохоо мэдэгдсэн байна.<sup>6</sup> Хэдий зохион байгуулалтын цор ганц шалгарсан арга байхгүй боловч бодит нөхцөлд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг олон улс оронд хэрэгжүүлж байгаатай холбогдуулан дараах дөрвөн хандлага байгааг ажиглаж болно. Үүнд: нэгд одоо байгаа байгууллагыг урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар тогтоох, ихэнх тохиолдолд хүний эрхийн үндэсний байгууллага, хоёрт уг үүргийг хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн байгууллагуудын холимог тогтолцоонд олгох, гуравт шинээр мэргэшсэн байгууллага байгуулах, дөрөвт олон тооны байгууллагад урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүргийг оноох. Эдгээр хэлбэр тус бүртээ өөр өөрийн давуу болон сул талуудтай болохыг уг протоколыг соёрхон батлах гэж буй улс орон урьдаас мэдэж

<sup>6</sup> As of 9 February 2013 оны 2 дугаар сарын 9-ний байдлаар.

### **(1) The Designation of an Existing Body as the NPM**

Globally a sizeable number of OPCAT States Parties have designated an existing NHRI as their country's NPM. NHRIs are usually grouped into two broad categories, namely national human rights commissions (as in Mongolia) and ombudspersons' offices (as in Serbia, for example).

There are clearly several advantages of designating an existing NHRI as an NPM. An NHRI may already enjoy significant public confidence and have a high profile as a key national human rights actor. In certain countries they are highly respected independent institutions, a reputation often built up over decades of relentless work. Furthermore, some NHRIs have accumulated considerable experience in monitoring places of detention and protecting the rights of detainees in a wide range of detention settings. Moreover, certain NHRIs already possess a good number of the requirements demanded by Articles 17 to 23 of the OPCAT text. NHRIs often also play a keen role commenting on legislation and public policy relating to criminal justice matters, as required by the OPCAT.

Thus, it comes as no surprise that various governments have considered this option of employing an existing NHRI as the NPM to be a politically expedient and relatively inexpensive way of implementing the OPCAT. At the time of writing at least 20 countries had designated one existing NHRI as the NPM and this option was under consideration in various other countries.

байвал зохино. Мөнхүү урьдчилан сэргийлэх үндэсний механизмын дөрвөн хэлбэр болон тэдгээрт тулгардаг асуудлуудын талаар тоймлон хүргэе.

### **(1) Оршин байгаа аль нэг байгууллагад урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүргийг олгох нь**

Олон оронд оршин байгаа хүний эрхийн үндэсний байгууллагадаа урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат олгосон туршлага байна. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь гол төлөв хоёр үндсэн ухагдхуунд хуваагддаг нь хүний эрхийн үндэсний комисс (Монголд байдгийн адилаар) болон омбудсманий алба(Жишээ нь Серб).

Оршин байгаа хүний эрхийн үндэсний байгууллагыг урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар сонгох нь тодорхой хэдэн давуу талтай. Хүний эрхийн үндэсний байгууллага нь хэдийнээ олон нийтийн итгэлийг хүлээсэн хүний эрхийн үндэсний голлох үүрэг хүлээгч болохын хувьд нэр хүндтэй, байр сууриа эзэлсэн байх нь бий. Зарим улсад тэд ихээхэн хүндэтгэл хүлээсэн бие даасан байгууллага байх бөгөөд нэр хүнд нь ихэнхдээ олон арван жилийн цуцашгүй хөдөлмөрийн үр дүнд бий болсон байдаг. Цаашилбал зарим хүний эрхийн үндэсний байгууллага хорих байгууллагуудад хяналт тавих, олон янзын хорих байгууламж дахь хоигдож буй хүмүүсийн эрхийг хамгаалах тал дээр арвин туршлага хуримтлуулсан байна. Мөн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын 17-23 дугаар зүйлд заасан олон шалгуурыг хэдийнээ хангасан хүний эрхийн үндэсний байгууллагууд ч байна. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь ихэнхдээ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд шаардсаны адилаар эрүүгийн шүүхийн асуудалтай холбоотой хууль тогтоомж, төрийн бодлогын талаар үнэлэлт, дүгнэлт өгөх идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг юм.

Тиймээс ч олон орны төр засаг одоо байгаа хүний эрхийн үндэсний байгууллагыг урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагаар томилох энэ шийдлийг Эрүүдэн шүүхийн

The Czech Republic's NPM, the Public Defender of Rights (Ombudsman), is a good case in point.<sup>7</sup> It is one of Europe's longest serving mechanisms, having been formally designated as the NPM in January 2006. The institution astutely used the moment of its designation as a moment for self-reflection with a view to reorganizing and restructuring its activities. As a result, a separate NPM unit has been established within the NHRI, comprising 12 members of staff. In addition, among other progressive steps, the institution re-developed its visiting methodology to take into account its new proactive torture prevention mandate. It now also regularly visits a much wider range of different types of detention facilities, not just prisons and police stations. As a result of these changes, the institution is generally regarded as undertaking good quality torture prevention work.

Despite the advantages of bestowing on an NHRI the mandate of NPM, one must remain aware of various related challenges.<sup>8</sup> These mainly, although not exclusively, relate to issues of resources, independence and perceptions thereof, NPM founding legislation, preventive visits and complaints-handling, staff composition, and commenting on legislation and public policy.

An important lesson to be learned from existing practice is that the act of designating an

эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг хэрэгжүүлэх улс төрийн хувьд зохимжтой, харьцангуй хямд арга хэлбэр гэж үзсэнд гайхах зүйлгүй юм. Энэхүү нийтлэлийг бичин буй үед багаар тооцоход 20 орчим улс оршин байгаа хүний эрхийн үндэсний байгууллагаа урьдчилан сэргийлэх үндэсний механизмээр томилоод байсан бөгөөд олон оронд энэ шийдлийг авч үзэж байлаа.

Бүгд Найрамдах Чех Улсын урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага болох Омбудсман харьцуулж үзэхэд яг таарах жишээ болно.<sup>7</sup> Энэ нь 2006 онд томилогдсоноороо Европ дахь хамгийн олон жилийн туршлагатай механизмын нэг юм. Уг байгууллага тийнхүү томилох үеийг ухаалгаар ашиглан үйл ажиллагааныхаа зохион байгуулалт, бүтцийг шинэчлэх үүднээс шинжилгээ шалгалт хийсэн юм. Үр дүнд нь 12 ажилтнаас хүнээс бүрдсэн бие даасан урьдчилан сэргийлэх үндэсний механизмын нэгжийг байгууллага дотроо байгуулсан байна. Мөн түүнчлэн өөр бусад дэвшилтэт арга хэмжээнүүдийг авсны дотор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мандатаа бодит ажил хэрэг болгох үүднээс газар дээр нь очиж шалгалт хийх арга барилаа сайжруулан боловсруулжээ. Одоо шорон, цагдаагийн газар төдийгүй өөр олон төрлийн хорих байгууллагуудаар тогтмол шалгалт хийдэг ажээ. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд энэ байгууллагыг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай сайн явуулдаг гэдгээр нь мэдэх болсон юм.

Хүний эрхийн үндэсний байгууллагад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатыг олгох нь давуу талуудтай боловч түүнтэй холбоотой олон төрлийн бэрхшээл тулгардгийг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.<sup>8</sup> Эдгээр нь голлон хүний болон санхүүгийн боломж, бие даасан байдал болон түүнийг хэрхэн үзэж байгаа

<sup>7</sup> For more information please see: <http://www.ochrance.cz/en/protection-of-persons-restricted-in-their-freedom/>

<sup>8</sup> These challenges are explained in much greater detail in the APT publication, Optional Protocol to the UN Convention against Torture Implementation Manual, 2010, available in various languages including English and Russian at: <http://www.ap.t.ch/en/resources/the-optional-protocol-implementation-manual/>

<sup>7</sup> <http://www.ochrance.cz/en/protection-of-persons-restricted-in-their-freedom/> хаягаас үзнэ үү.

<sup>8</sup> Эдгээр бэрхшээл хүндрэлийн талаар дэлгэрэнгүйг Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх Холбооны 2010 онд Англи, Орос зэрэг олон хэлээр хэвлүүлсэн Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг хэрэгжүүлэх гарын авлагаас <http://www.ap.t.ch/en/resources/the-optional-protocol-implementation-manual/> хаягаар орж үзнэ үү.



existing NHRI as the NPM should not be viewed by States Parties as an ‘inexpensive’ or ‘cheap’ way of implementing their obligations under the OPCAT. Giving an additional mandate to an existing NHRI will always require additional resources, both human and financial. The former Chairperson of the SPT, Dr Silvia Casale, underscored this point publicly on several occasions, noting that the implementation of the OPCAT could never be ‘cost neutral’.<sup>9</sup>

Regrettably, this is a common misunderstanding on the part of certain governments which have allocated the NPM mandate to an NHRI without giving it additional human and financial resources or, at best, very few. In its 2011 Annual Report, for example, the Polish NPM bemoaned its lack of financing, having suffered a reduction in income in 2011, on the back of cuts in 2010. It stated in this report: “*In 2011, the Sejm cut the budget of the Office of the Human Rights Defender from the planned PLN 36,477,000 to PLN 35,424,000. This cut resulted in a reduced budget for the National Preventive Mechanism from the planned PLN 1,740,000 to PLN 1,265,000. Thus, the tasks of NPM were performed at the expense of other activities of the Defender, and were largely limited. This constituted a breach of Article 18(3) and (4) of the OPCAT.*”<sup>10</sup>

Disappointingly, the Polish NPM is not alone in its financial plight, as other NHRI-NPMs find themselves battling for precious

<sup>9</sup> Presentation delivered at the ‘Preventing Ill-treatment: Ireland and the OPCAT’ Conference, Dublin, Ireland, 7 September 2007.

<sup>10</sup> Report of the Human Rights Defender (Ombudsman) on the activities of the National Preventive Mechanism of Poland 2011, June 2012 – page 13.

байдал, урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулсан хууль тогтоомж, урьдчилан сэргийлэх шалгалт үзлэг, гомдол хянан шийдвэрлэлт, ажилтнуудын бүтэц бүрэлдхүүн, хууль тогтоомж, төр засгийн бодлогын асуудлаар үнэлэлт дүгнэлт өгөх асуудал зэрэгтэй холбоотой байдаг.

Одоогийн туршлагаас гарч буй чухал сургаж нь Хүний эрхийн үндэсний байгууллагыг урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар томилох шийдлийг гишүүн улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх “хямд, хялбар арга” гэж харахгүй байхыг шаардаж байна. Хүний эрхийн үндэсний байгууллагад нэмж мандат олгож байгаа бол хүний нөөцийн болон санхүүгийн нэмэлт нөөц боломжоор хангах шаардлага зайлшгүй гарна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дарга асан доктор Силвиа Касале ийм ойлголтыг өмнө нь удаа дараа буруушааж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын хэрэгжилт хэзээ ч өртөг аргацаасан байж болохгүй хэмээн тэмдэглэсэн нь бий.<sup>9</sup>

Харамсалтай нь Хүний эрхийн үндэсний байгууллагад нэмэлт хүн хүч, санхүүжилт өгөлгүйгээр буюу сайндаа л бага хэмжээний нэмэгдэлтэйгээр урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатыг олгосон зарим улсын төр засгийн хувьд нийтлэг байдаг өрөөсгөл ойлголт юм. Польшийн урьдчилан сэргийлэх үндэсний механизм 2011 оныхоо ээлжит илтгэлдээ 2010 онд төсвөө тануулсны дараа мөн 2011 онд хасуулж санхүүжилт тааруу байгаадаа харамслаа илэрхийлэв. Мөнөөх илтгэлд “2011 онд Сейм Хүний эрхийн Омбудсманы Газрын төсвийг анх төлөвлөсөн 36,477,000 злотоос 35,424,000 злот болгож бууруулсан болно. Энэ хасалтаас шалтгаалан урьдчилан сэргийлэх үндэсний механизмд зориулсан төсөв төлөвлөсөн 1,740,000 злотоос буурч 1,265,000 злот болов. Тиймээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үйл

<sup>9</sup> Зүй бус харьцаанаас сэргийлэх нь Ирланд ба Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол сэдэвт Журал дээр тавьсан Илтгэл, 2007 оны 9 дүгээр сарын 7.

resources. A shortage of staff and finances will invariably have a negative impact on the capacity of NPMs to monitor a variety of places of detention throughout the country on an adequately frequent basis as well as on other aspects of its mandate.

Functional independence and perceptions of independence by other actors are crucial for any NPM if it is to robustly monitor the detaining authorities and enjoy legitimacy, especially in the eyes of civil society. Nevertheless, NHRIs do vary significantly in these respects. The Azerbaijani NPM is a very good case in point.<sup>11</sup> The Commissioner for Human Rights (Ombudsman) was designated as the NPM in January 2009, despite widely held concerns about the independence of the institution. These same concerns were later echoed by the UN Committee against Torture in Geneva during its periodic examination of Azerbaijan in November 2009. The Committee stated in its Concluding Observations that “... the Ombudsman lacks the requisite degree of independence ... to serve as the national prevention mechanism under the Optional Protocol to the Convention against Torture”.<sup>12</sup> Unfortunately, the Azerbaijani NHRI is not the only example of an NHRI lacking the prerequisite independence to be an NPM.

Another common problem associated with NHRIs designated as NPMs is weak founding legislation. In order to establish the NPM mandate in law amendments inevitably have to be made to the law establishing the

ажиллагааг Омбудсманы Газрын бусад үйл ажиллагааныхаа зардлаар ихээхэн хязгаарлагдмал байдалд гүйцэлдүүлсэн болно. Энэ нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын 18 дугаар зүйлийн 3 болон 4 дэх хэсгийг зөрчиж байна” гэжээ.<sup>10</sup>

Гэхдээ дан ганц Польшийн урьдчилан сэргийлэх үндэсний механизм ч биш өөр бусад Хүний эрхийн үндэсний байгууллагууд ч шаардлагатай хүн хүч, санхүүжилтийн дутагдалд байна. Хүн хүч, санхүүгийн хомсдол нь урьдчилан сэргийлэх үндэсний механизмын улс орон даяар олон төрлийн хорих газруудад давтамжтайгаар мөн мандатынхаа хүрээнд өөр бусад хэлбэрээр хяналт шалгалт хийх чадавхид адилхан сөрөг нөлөө үзүүлэх юм.

Хэрэв хорих байгууллагуудад хяналт тавьж, бүрэн эрхээ баталгаатай хэрэгжүүлэхэд үйл ажиллагааных нь бие даасан байдал, түүнийг бусад этгээдийн зүгээс хүлээн зөвшөөрөх нь ямар ч урьдчилан сэргийлэх үндэсний механизмд, тэр тусмаа иргэний нийгэм ажиглаж байгаагаар, онцгой ач холбогдолтой. Гэсэн хэдий ч хүний эрхийн үндэсний байгууллагуудаас эдгээр тал дээр олон ялгаа харж болно. Үүн дээр Азербайжаны урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар жишээ авъя.<sup>11</sup> Олон талын төлөөлөл Хүний эрхийн Комиссар буюу Омбудсманы бие даасан, хараат бус байдалд сэтгэл зовниж байсныг үл харгалзан 2009 оны 1 дүгээр сард урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат олгожээ. Хожим нь 2009 оны 11 дүгээр сард хийсэн ээлжит хяналт шалгалтынхаа үеэр Женев дэх НҮБ-ын Эрүү шүүлийн эсрэг хорооноос энэ анхааруулгыг дахин өгч байв. Тус хороо Ажиглалт дүгнэлтдээ “Омбудсманд ... Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмын үүргээ биелүүлэхэд ... зайлшгүй шаардлагатай бие

<sup>11</sup> For more information please see: <http://www.ombudsman.gov.az/view.php?lang=en>

<sup>12</sup> UN Doc. CAT/C/AZE/CO/3, 8 December 2009 – paragraph 10.

<sup>10</sup> Польшийн урьдчилан сэргийлэх үндэсний механизмын 2011 оны үйл ажиллагааны талаарх Омбудсманы илтгэл, 2012 оны 6 дугаар сар – 13 дахь параграф.

<sup>11</sup> <http://www.ombudsman.gov.az/view.php?lang=en> хаягаар үзнэ үү.

NHRI. The amended legislation seen by the APT in practice has been quite poor, as key NPM elements have been absent, especially those highlighted in Articles 17 to 23 of the OPCAT text. In 2009-2010 the APT and various other international experts spent a significant amount of time commenting at length on draft legislation to designate the Montenegrin NHRI, the Protector of Human Rights and Citizens, as the NPM.<sup>13</sup> The Montenegrin parliament passed the amended legislation in 2011, regrettably ignoring much of the internationally offered legal advice. Thus, as it stands, the NHRI-NPM law is woefully inadequate from an international legal perspective, a state of affairs which could have been easily avoided.

The task of balancing proactive preventive monitoring with complaints-handling is another challenge actors should be mindful of, although this matter can be quite easily surmounted. An NHRI's mandate is usually broad, in some cases ranging from human rights promotion to exercising quasi-judicial powers. Many NHRIs are also granted powers to receive and investigate individual complaints about violations, including torture and ill-treatment. The OPCAT distinguishes between regular visits to places of detention to prevent ongoing and future ill-treatment of any detainee in such facilities and visits to particular detention facilities in order to investigate individual complaints of abuse which have already taken place. While complaints-handling is very important, especially for the complainant, NHRI-NPMs need to find a way of effectively

даасан хараат бус байдал байхгүй байна.”<sup>12</sup> Харамсалтай нь Азербайжаны хүний эрхийн үндэсний байгууллага нь урьдчилан сэргийлэх үндэсний механизм байхад шаардлагатай бие даасан байдал дутагдалтай байгаа цорын ганц хүний эрхийн үндэсний байгууллага биш юм.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат бүхий хүний эрхийн үндэсний байгууллагуудтай холбоотой өөр нэг нийтлэг асуудал бол үүсгэн байгуулсан эрх зүйн сул орчин юм. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулахын тулд Хүний эрхийн үндэсний байгууллагыг үүсгэн байгуулсан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай. Нэмэлт өөрчлөлт орсон хуулийг Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх Холбооноос бодит байдалд авч үзэхэд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын гол элементүүд, ялангуяа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын 17-23 дугаар зүйлүүдэд орсон элементүүд тусаагүйгээс нилээн тааруу болсон байна. 2009-2010 онд Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх Холбоо болон олон улсын бусад олон мэргэшсэн шинжээч Монтенегрогийн хүний эрхийн үндэсний байгууллагад урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат олгосон хуулийн төсөл дээр ихээхэн цаг зарцуулан ажиллаж дүгнэлт өгсөн юм.<sup>13</sup> Харамсалтай нь Монтенегрогийн парламент 2011 онд хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлахдаа олон улсын шинжээчдийн өгсөн олон зөвлөмжийг харгалзан үзээгүй юм. Ийнхүү одоогийн байдлаар Монтенегрогийн хүний эрхийн үндэсний байгууллага-урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухай хууль нь олон улсын эрх зүйн үүднээс харамсмаар зохимж муутай бөгөөд ийм нөхцөл байдалд хүргэхгүй байж болох байв.

Санаачлагатай урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг гомдол хянан шийдвэрлэх ажиллагаатай тэнцвэрийг хангах ажил бол гүйцэтгэгч этгээд байнгын анхаарал тавих

<sup>13</sup> For more information please see : <http://www.ombudsman.co.me/eng/index.htm>

<sup>12</sup> НҮБ-ын баримт бичиг CAT/C/AZE/CO/3, 2009 оны 12 дугаар сарын 8 –10 дугаар заалт.

<sup>13</sup> <http://www.ombudsman.co.me/eng/index.htm> хаягаар үзнэ үү.



handling complaints and ensuring preventive monitoring, as envisaged by the OPCAT.

In certain countries this hurdle has been cleared by establishing a separate NPM unit within the NHRI, which is only responsible for NPM-related preventive visits. Individual complaints are therefore handled by another internal department. The NHRI-NPMs in Costa Rica, Czech Republic and the Maldives have all adopted such an approach. In other countries, such as Estonia and Slovenia for example, written complaints collected during an NPM-related visit are taken back to NHRI headquarters for another staff member to process.

While certain NHRI-NPMs do actively comment on legislation and public policy, as envisaged under Article 19 (C) of the OPCAT, others are less active in this respect. One of the reasons for this fact is that some NHRIs adopt a legalistic approach to their work, which focuses on determining whether specific administrative actions comply with proper administrative procedures and/or standards of fairness. They may therefore find it challenging to adopt the approach required by the OPCAT, as this involves commenting on draft and existing legislation and policy relevant to the NPM mandate.

For example, in December 2012 the Norwegian government took the formal decision to ratify the OPCAT, which is likely to take place in the first half of 2013. The future NPM will be the Parliamentary Ombudsman, which is a long-standing and prestigious institution.<sup>14</sup>

<sup>14</sup> For more information please see: <http://www.sivilombuds->

зүйл боловч үүнийг харьцангуй амархан гүйцэлдүүлж болох юм. Хүний эрхийн үндэсний байгууллагын мандат ихэнхдээ өргөн хүрээтэй, зарим тохиолдолд хүний эрхийг хөхиүлэн дэмжихээс эхлээд хагас шүүхийн шинжтэй эрх мэдэл хэрэгжүүлэх хүртэл байдаг. Олон Хүний эрхийн үндэсний байгууллага хүний эрхийн зөрчил, түүний дотор эрүү шүүлт, зүй бус харьцааны талаар гомдол хүлээн авах, шалгах эрхтэй. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол нь хорих ангиудад хоригдогчдод тохиолдож байгаа болон тохиолдох зүй бус харьцааг шалгахын тулд хийх шалгалтын ажлыг аль хэдийн болсон зөрчлийн талаарх хувь хүний гомдлын дагуу тодорхой нэг хорих байгууллагад хийдэг шалгалтаас ялгаж өгч байгаа юм. Гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа чухал боловч урьдчилан сэргийлэх үндэсний механизм-хүний эрхийн үндэсний байгууллага нь үр дүнтэйгээр гомдол хянан шийдвэрлэж, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд заасны дагуу урьдчилан сэргийлэх хяналт тавих арга замыг эрэлхийлэх хэрэгтэй юм.

Зарим улс оронд Хүний эрхийн үндэсний байгууллага дотроо зөвхөн урьдчилан сэргийлэх шалгалт үзлэг хийх үүрэг бүхий бие даасан нэгж байгуулан дээрх бэрхшээлийг арилгаж байна. Тиймээс хувь хүний гомдлыг өөр дотоодын хэлтэс, алба хариуцаан ажилладаг ажээ. Коста Рика, Бүгд Найрамдах Чех Улс, Малдив улсууд дахь урьдчилан сэргийлэх үндэсний механизм-хүний эрхийн үндэсний байгууллага бүгд ийм хэлбэрийн шийдлийг сонгосон байна. Эстони, Словени зэрэг орнуудад, жишээ нь, урьдчилан сэргийлэх үндэсний механизмын шалгалтаар цуглуулсан бичмэл гомдлыг хүний эрхийн үндэсний байгууллага дээр авчирч, өөр ажилтан хянан шалгадаг байна.

Зарим урьдчилан сэргийлэх үндэсний механизм-хүний эрхийн үндэсний байгууллага Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын 19 дүгээр зүйлийн (C)-д зааснаар хууль тогтоомж, төр засгийн бодлогын шийдвэрт байнга дүгнэлт өгдөг бол бусад нь энэ тал дээр идэвхтэй

Nonetheless, one of the key areas it will need to address in order to become an effective NPM will be to develop its legislation and policy work under Article 19 (C) of the OPCAT. In other countries NHRI designated as NPMs are less active in this regard simply - and understandably - due to a lack of human resources. This state of affairs fact is especially true for several NHRI-NPMs in the Balkans region, where all six countries have now ratified the OPCAT.<sup>15</sup>

Finally, another challenge to be aware of is that the nature of NHRIs (and especially ombudspersons' offices) often means that their members and staff are predominantly lawyers. However, the NPM preventive mandate requires the expertise of members from diverse professional backgrounds, including medical fields. For example, the Georgian Public Defender of Rights (Ombudsman), which has set up a department of eight persons to act as the NPM, currently has no in-house medical expertise.<sup>16</sup> In order to address this professional imbalance it draws on the expertise of medical professionals from academia and NGOs. Unfortunately, the situation of NHRI-NPMs not having in-house medical expertise is not an exception.

It should be that none of the aforementioned challenges are insurmountable. All of these matters can be adequately addressed through changes in legislation, organizational structure and methodology as well as the provision of additional human and financial resources.

ажилладаггүй ажээ. Үүний нэг шалтгаан бол зарим Хүний эрхийн үндэсний байгууллага тодорхой нэг захиргааны шийдвэр захиргааны зохих ёсны дүрэм журам, зүй ёсны стандарт хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэсэн зарчим, эрх зүйт чиг баримжаа баримталдагт оршино. Тиймээс тэд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд шаарддаг чиг шугам баримтлах нь урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатад хамаарах хууль тогтоомж болон тэдгээрийн төсөлд үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг үйл ажиллагааг хамрах болдог тул хүндрэлтэй байдаг бололтой.

Жишээ нь 2012 оны 12 дугаар сард Норвегийн засгийн газар Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах албан ёсны шийдвэр гарсан нь 2013 оны эхний хагаст бүтэж магадгүй байна. Урьдчилан сэргийлэх үндэсний механизм болох гэж буй парламентийн омбудсман нь олон жилийн түүхтэй хүндтэй алба юм.<sup>14</sup> Гэхдээ үүргээ бодитоор хэрэгжүүлж чадах урьдчилан сэргийлэх механизм болохын тулд анхаарвал зохих асуудлуудын нэг бол Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын 19 дүээр зүйлийн (C)-д заасан хууль тогтоомж, бодлогын үйл ажиллагаагаа боловсронгуй болгох явдал юм. Бусад улс оронд урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар сонгогдсон Хүний эрхийн үндэсний байгууллага нь энэ тал дээр идэвхи бага байдаг нь мэдээж хүний нөөц дутмаг байдгаас болдог. Ийм нөхцөл байдал ялангуяа бүх 6 улс нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон баталсан Балканы хойг дахь хэд хэдэн урьдчилан сэргийлэх үндэсний механизм-хүний эрхийн үндэсний байгууллагад бодит болоод байна.<sup>15</sup>

Эцэст нь анхаарвал зохих өөр нэг асуудал бол Хүний эрхийн үндэсний байгууллагуудад байдаг нэг шинж чанар(ялангуяа омбудсманы

mannen.no/?lang=en\_GB

<sup>15</sup> These include Albania, Croatia, Macedonia, Montenegro, Serbia and Slovenia.

<sup>16</sup> For more information please see : <http://www.ombudsman.ge/index.php?page=5&lang=1>

<sup>14</sup> [http://www.sivilombudsmannen.no/?lang=en\\_GB](http://www.sivilombudsmannen.no/?lang=en_GB) хаягаар үзнэ үү.

<sup>15</sup> Эдгээрт Албани, Хорват, Македони, Монтенегро, Серб, Словени улсууд орно.

Moreover, these same problems are often faced by other types of NPMs, as we will see below.

## **(2) The designation of an NHRI and civil society actors as the NPM**

This paper opened with several disturbing examples of abuse uncovered by the Serbian NPM, the Ombudsman's Office. This institution, however, does not work alone in the fulfilment of the country's NPM mandate. Rather, it actively cooperates with an NHRI in the autonomous region of Vojvodina as well as with nine NGOs. In the context of the OPCAT a growing number of examples of NHRI-civil society collaboration have emerged in recent years, most of which emanate from the Europe and Central Asia region. These include Armenia, Croatia, Denmark, Georgia, Kazakhstan, Macedonia, Moldova, Serbia, Slovenia and Ukraine. As with all other approaches to OPCAT implementation, this approach has distinct advantages as well as disadvantages.

A number of the hybrid NPMs, noted above, are very new and have not been operating for any length of time. For example, NHRI-civil society collaboration seen in Serbia and Croatia has not yet been operational for a year, although there are positive signs that both NPMs have started off well. In contrast, in Kazakhstan, the legislation to establish such an arrangement is still under consideration by the authorities, even though it looks highly likely that the country will implement the OPCAT in this manner.

At the present time the Slovenian NPM is the longest serving example of this type of

газруудад) гишүүд, бүрэлдэхүүн нь хуульч, эрх зүйчид байдагтай холбоотой. Гэвч урьдчилан сэргийлэх үндэсний механизмын урьдчилан сэргийлэх мандат нь ангаахын гэхчилэн олон төрлийн мэргэжлийн гишүүдийн экспертизийг шаарддаг. Жишээ нь Гүржийн Омбудсман нь урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүрэг гүйцэтгэх 8 хүнтэй алба байгуулсан атал тэдгээрийн дунд нэг ч эмнэлгийн эксперт байхгүй байна.<sup>16</sup> Төрөл мэргэжлийн энэхүү тэнцвэргүй байдлыг шийдвэрлэхийн тулд тэд эрдэм шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллагуудаас эрүүл мэндийн мэргэжилтний туслалцааг авдаг ажээ. Харамсалтай нь өөрийн эмнэлгийн мэргэжилтэнгүй байгаа байдал урьдчилан сэргийлэх үндэсний механизм-хүний эрхийн үндэсний байгууллага д зөвхөн байгаа зүйл биш юм.

Өмнө дурдсан бэрхшээл саадын аль нь ч даван туулах, шийдвэрлэх боломжгүй юм биш. Энэ бүх асуудлыг хууль тогтоомж, бүтэц зохион байгуулалт, арга зүйгээ өөрчлөх шинэчлэх, мөн хүн хүч, санхүүгээ нэмэх замаар зохистойгоор шийдвэрлэж болно. Мөн эдгээр асуудал нь бусад хэлбэрийн урьдчилан сэргийлэх механизмд ч тулгардгийг бид хожим өгүүлнэ.

## **(2) Хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн байгууллагад урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат олгох нь**

Энэ нийтлэлийн эхэнд Сербийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм болох Омбудсманы Газрын илрүүлсэн хүний эрхийн зөрчлүүдийг харуулсан сэтгэл өвдмөөр жишээг өгүүлсэн билээ. Энэ байгууллага гэхдээ тус улсын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мандатыг дангаараа хэрэгжүүлдэггүй юм. Харин Войводинагийн өөртөө засах бүсийн хүний эрхийн үндэсний байгууллага болон есөн ТББ-тай идэвхтэй хамтран ажилладаг байна. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын

<sup>16</sup> <http://www.ombudsman.ge/index.php?page=5&lang=1> хаягаар үзнэ үү.

collaborative arrangement between a country's NHRI and civil society, having been set up in 2007.<sup>17</sup> It also appears to be an NPM set-up which is operating effectively in practice. It is therefore a good example to use to highlight some of the advantages and disadvantages of such an NPM model.

The Slovenian NPM is especially interesting from several perspectives. Within the Ombudsperson's Office a separate NPM unit was established, which currently comprises nine persons of various professional backgrounds. Thus, for a small country like Slovenia, this was already a reasonably good start resource-wise. Over the past six years the Ombudsperson's Office has engaged key Slovenian NGOs to undertake the NPM-related monitoring and reporting activities. The NGOs have been recruited by the NHRI through a series of public tenders, during which interested NGOs were asked to apply to the Ombudsperson's Office. At present, five different NGOs are involved in the NPM-related activities and have signed contracts of cooperation with the NHRI.

The Director of the NPM unit is Deputy Ombudsman, Ivan Šelih, who is a keen advocate for NHRI-NPM collaboration in the context of the OPCAT. According to him<sup>18</sup>, one of the key advantages of working with civil society actors is that they put at the disposal of the NPM additional human resources and increased professional diversity. In addition, the involvement of such actors has also enhanced

хүрээнд Хүний эрхийн үндэсний байгууллага-иргэний нийгмийн хамтын ажиллагааны жишээ сүүлийн жилүүдэд улам олширч байна. Тэдгээрийн ихэнх нь Европ, Төв Азийн бүс нутгаас гарч байна. Үүнд Армени, Хорват, Дани, Гүрж, Казахстан, Македони, Молдав, Серби, Словени, Украин орж байна. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг хэрэгжүүлэх бүхий л арга хэлбэрийн дунд энэ арга хэлбэр нь өвөрмөц давуу тал болон мөн л өөрийн сул талуудтай.

Дээр дурдсанчлан холимог хэлбэрийн олон тооны урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдаад удаагүй, ажилласан туршлага багатай байна. Жишээ нь Серб, Хорват дахь хүний эрхийн үндэсний байгууллага-иргэний нийгмийн хамтын ажиллагааны хамтын ажиллагаа ажиллаж эхлээд жил ч болоогүй хэдий ч аль аль нь гараа сайтай байгаа эерэг шинж тэмдэг үзүүлж байгаа юм. Харин Казахстанд эрх зүйн орчныг нь хангах ёстой хууль тогтоомж нь одоо болтол хэлэлцүүлгийн шатанд байгаа ч энэ улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын хэрэгжилт энэ арга хэлбэрээр явах бололтой.

Яг одоогоор Словений урьдчилан сэргийлэх үндэсний механизм 2007 онд байгуулагдснаараа ямарваа улсын хүний эрхийн үндэсний байгууллага болон иргэний нийгмийн хооронд хамтран ажиллаж ирсэн хамгийн олон жилийн түүх бүхий жишээ болж байна.<sup>17</sup> Мөн бодит байдал дээр үр дүнтэй ажиллаж байгаа нэг жишээ юм. Тиймээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын энэ загварын давуу тал сул талыг онцлон харуулах хамгийн сайн жишээ ч болж байна.

Словений урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь хэд хэдэн өнцгөөс харвал сонирхол татахуйц өвөрмөц юм. Омбудсманы Газар дотроо бие даасан урьдчилан сэргийлэх үндэсний механизмын нэгжийг байгуулсан бөгөөд тэр нь одоогийн байдлаар янз бүрийн мэргэжлийн намтар бүхий 9 хүнээс бүрдэнэ. Тиймээс Словени

<sup>17</sup> For more information please see: <http://www.varuh-rs.si/about-us/fields-of-work/ombudsman-as-a-nmp/?L=6#c2299>

<sup>18</sup> Presentation delivered at the Fourth East European Conference on NPMs, Odessa, Ukraine – 15 November 2012.

<sup>17</sup> <http://www.varuh-rs.si/about-us/fields-of-work/ombudsman-as-a-nmp/?L=6#c2299> хаягаар үзнэ үү.

the plurality of the overall mechanism and thereby boosting its legitimacy in the eyes of wider society.

There have undeniably been disadvantages relating to the collaborative arrangement. The Deputy Ombudsman has commented in the past that the involvement of civil society actors in the NPM has increased the administrative workload of the NHRI, since its full-time staff now have to organize and coordinate more actors in the overall NPM-related work. In addition, extra financial resources have had to be found to administer the scheme, as the civil society actors are paid for their time and work. Finally, Ivan Šelih has also noted in the past certain NGO representatives have not always appeared to show the required degree of commitment to and enthusiasm for the NPM-related work.

One can see from the above that, once again, the issue of human and financial resources have proven to be essential for the effective operation of the NPM. This fact remains true no matter how the OPCAT is implemented in practice. It must be said that there exist at least two examples of NHRI-civil society hybrid NPM models which have not been especially effective for these reasons.

The Moldovan NPM, for instance, was established in 2008 and consists of an 11-person body called the Consultative Council.<sup>19</sup> Ten of the members are recruited from civil society, while the Chairperson of the institution is one of Moldova's four Ombudspersons. One important

шиг жижигхэн улсын хувьд энэ нь хүн хүчний нөөцийн их ухаалаг эхлэл байлаа. Зургаан жилийн дотор Омбудсманы Газар урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хамаарах хяналт болон илтгэл бэлтгэх үйл ажиллагаануудыг зохион байгуулахад Словений голлох ТББ-уудыг татан оролцуулж иржээ. Тэдгээр ТББ-ыг олон тооны цуврал тендер зарлан шалгаруулан авсан байна. Одоо таван ТББ урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ажилд оролцож, Хүний эрхийн үндэсний байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын нэгжийн дарга нь Дэд Омбудсман Иван Селих бөгөөд тэрээр Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын хүрээнд хүний эрхийн үндэсний байгууллага-иргэний нийгмийн хамтын ажиллагааны хэлбэрийг тууштай дэмжигч юм. Түүний хэлснээр<sup>18</sup>, иргэний нийгэмтэй хамтран ажиллахын нэг гол давуу тал бол тэд урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг ажиллуулахад нэмэлт хүн хүч хаяж, мэргэжлийн нэр төрлийг олон болгосон ажээ. Түүнээс гадна тийм байгууллагыг татан оролцуулснаар нийт механизмын олон талт байдлыг нэмэгдүүлж, нийгмийн өргөн хүрээнд түүний албан ёсны байдлыг өргөж өгдөг байна.

Хамтын ажиллагааны хэлбэрт сул талууд байгааг үгүйсгэх аргагүй юм. Дэд Омбудсман өмнө нь иргэний нийгмийг урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ажилд татан оролцуулах нь орон тооны ажилтнууд нь нийт урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ажилд илүү олон тооны этгээдүүдийг удирдан зохион байгуулж, зохицуулах шаардлагатай болдгоос хүний эрхийн үндэсний байгууллагын захиргааны ажлын ачаалал нэмэгдсэн гэж дурдсан удаатай. Мөн түүнчлэн энэ тогтолцоог удирдахын тулд нэмэлт санхүүжилт олох шаардлагатай болж байв. Эцэст нь Иван Селих мөн зарим ТББ-ын төлөөлөл урьдчилан сэргийлэх үндэсний

<sup>19</sup> For more information please see: <http://www.ombudsman.md/en/anpt/>

<sup>18</sup> Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын талаарх Зүүн Европын 4 дүгээр Бага хурал дээр тавьсан илтгэл, Украин улс, Одесс хот – 2012 оны 11 дүгээр сарын 15.



reason, although not the only one, why the NPM has not functioned especially well has related to the fact that, not only are its members not remunerated for their time, they do not even receive daily expenses for meals and transport. In an economically weak country like Moldova, few persons can afford to incur such costs for any length of time. As a result, the Consultative Council has suffered from a high turn-over in personnel, upsetting the stability of the NPM.

Ivan Šelih's previous point that certain NGO representatives have not always appeared to show the required degree of commitment to and enthusiasm for the NPM-related work is also important. Not all civil society actors may be suited to engage in NPM related activities, particularly organizations or individuals who cannot devote the time to do so. Moreover, certain civil society actors may have difficulties reconciling a critical attitude to authority with the cooperative dialogue approach required by the OPCAT. By becoming a formal part of the NPM, the statutory authority, power, structure and finances may bring with it responsibilities, a lack of flexibility and a requirement to act independently of the interests of the NGO itself that certain civil society entities may find difficult to accept.

### **(3) The Establishment of a New Specialized Body as the NPM**

A minority of states have or are in the process of creating an entirely new specialized body to act as their NPM, as can be seen in countries such as Austria, France, Germany, Guatemala, Honduras, Kyrgyzstan, Paraguay,

механизмын ажилд шаадлагатай хэмжээнд оролцож идэвх санаачлага гаргадаггүй байсан гэж тэмдэглэсэн юм.

Дээрхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үр дүнтэй ажиллахад хүн хүчний болон санхүүгийн нөөц эн тэргүүний болохыг харж болно. Энэ бол Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протокол практикт ямар хэлбэрээр хэрхэн хэрэгжихээс үл хамааран өөрчлөгдөхгүй нөхцөл юм. Эдгээр шалтгаанаас болж ялангуяа сайн ажиллаж чадахгүй байгаа хүний эрхийн үндэсний байгууллага-иргэний нийгмийн холимог хэлбэрийн байгууллагын хоёр ч жишээ байгааг хэлэх хэрэгтэй.

Тухайлбал Молдавын урьдчилан сэргийлэх үндэсний механизм 2008 онд байгуулагдсан бөгөөд Зөвлөлдөх Зөвлөл хэмээх 11 хүний бүрэлдэхүүнтэй байгууллага байна.<sup>19</sup> Гишүүдийн арав нь иргэний нийгмийн төлөөлөл бөгөөд дарга нь Молдавын дөрвөн омбудсманы нэг юм. Уг урьдчилан сэргийлэх үндэсний механизм тухайлан сайн ажиллаж чадахгүй байгаагийн олон шалтгаануудын нэг нь гишүүдийн нэг нь ч үүргээ гүйцэтгэх явцдаа мөнгөн урамшуулал аваагүй төдийгүй өдөр тутмын хоол унааны зардал ч авч байгаагүйтэй холбоотой. Молдав шиг эдийн засгийн чадавхи сул улсад тийм зардлаа өөрөө дааж дийлээд удаан хугацаанд явах хүн ховор. Түүний үр дүнд Зөвлөлдөх Зөвлөлийн гишүүд олноороо солигдож, энэ нь урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тогтвортой байдалд нөлөөлсөн юм.

Иван Селихийн өмнө нь дурдсан зарим ТББ-ын төлөөлөл урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцдоггүй гэсэн нь анхаарахгүй өнгөрч болохгүй хүчин зүйл мөн. Иргэний нийгмийн байгууллага бүр, тэр дундаа цаг зав гаргах боломжгүй байгууллага хувь хүн урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ажилд тохироод байдаггүй. Цашилбал, зарим иргэний нийгмийн байгууллагад эрх баригчдад

<sup>19</sup> <http://www.ombudsman.md/en/anpt/> хаягаар үзнэ үү.

Senegal and Switzerland. Austria, for example, which is a relatively small European country comprising some 8.2 million persons, created an entirely new structure for this purpose as recently as 2012. Six regional monitoring commissions have been established, consisting of 42 part-time experts. The regional monitoring commissions fall under the scope of the Austrian Ombudsman Board.<sup>20</sup> Impressively, an extra 14 persons have been employed in the Austrian Ombudsman Board to assist the six monitoring commissions, while a part-time Human Rights Advisory Council has been created to advise the overall NPM. An overall additional budget of some 2.9 million EUROS has been allocated to the institution for the purpose of the implementation of the OPCAT, which is no small figure in the current economic climate.

Needless to say, there are distinct advantages associated with establishing a new body specifically to carry out the NPM mandate. Such bodies will have a clear and focused preventive mandate and, thus, will be able to give priority to torture prevention issues. As a result, they may have more impact than existing institutions with broader mandates. States may also find it easier to adopt new legislation to establish a new mechanism than to amend the legislation establishing existing operational bodies. Moreover, new bodies established by new legislation may be more OPCAT-compliant in terms of their mandates, independence, powers and diversity of staff than existing bodies.

ханддаг шүүмжлэлт байр сууриа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд шаардсан хамтын ажиллагааны яриа хэлэлцээний шинжтэй чиг баримжаатай нийцүүлэхэд хүндрэлтэй байх нь бий. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын албан ёсны бүрэлдхүүн хэсэг болсноор хуулиар тогтоосон эрх мэдэл, бүтэц, санхүү төсөв зэргээс шалтгаалан үүрэг хариуцлага, хатуу чанд байдал, ТББ-ын ашиг сонирхлоос ангид ажиллах шаардлаг зэргийг дагах ёстой болдог тул зарим иргэний нийгмийн байгууллагын хувьд хүлээн зөвшөөрөхөд хүнд байдаг байж болох юм.

### **(3) Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандаттай шинэ мэргэшсэн байгууллага байгуулах нь**

Цөөн хэдэн улс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүргээр тусгайлан шинэ байгууллага байгуулсан буюу байгуулахаар ажиллаж байгаагийн жишээг Австри, Франц, Герман, Гватемал, Гондурас, Киргизстан, Парагвай, Сенегал, Швейцарь зэрэг орнуудаас харж болно. Жишээ нь 8.2 сая хүн амтай Европын жижигхэн улс болох Австри саяхан буюу 2012 онд энэ зорилгоор шинэ байгууллага бий болгоод байна. Бүрэн бус орон тооны 42 мэргэшсэн шинжээчээс бүрдсэн бүсийн хяналт тавих зургаан комиссыг байгуулжээ. Бүсийн комиссууд Австрийн Омбудсманы Газрын удирдлага зохицуулалтад хамаарах юм.<sup>20</sup> Мөн өөр 14 хүнийг Австрийн Омбудсманы Газарт зургаан бүсийн комисст дэмжлэг үзүүлэхээр ажиллуулж байгаа бол нийт урьдчилан эргийлэх үндэсний механизмд зөвлөмжөөр хангах Хүний эрхийн орон тооны бус Зөвлөлийг байгуулсан байна. Нийт 2.5 сая долларын нэмэлт төсвийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг хэрэгжүүлэх зорилгоор тус байгууллагад хуваарилаад байгаа нь эдийн засгийн одоогийн орчин нөхцөлд бага тоо биш юм.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатыг хэрэгжүүлэхээр шинэ

<sup>20</sup> For more information please see: <http://www.menschenrechtsbeirat.at/en/human-rights/prevention>

<sup>20</sup> <http://www.menschenrechtsbeirat.at/en/human-rights/prevention> хаягаар үзнэ үү.

This NPM option is not without its challenges. Perhaps the greatest challenge of all is securing the required finances to establish an entirely new institution, especially in the current times of global economic woe. The Kyrgyz Republic, for example, has a world-class piece of NPM legislation, which came into force in July 2012, yet the government of this economically weak country, has struggled to find an adequate budget to physically set up the institution.

Similarly, the German NPM, the National Agency for the Prevention of Torture is extremely poorly resourced in terms of personnel.<sup>21</sup> For a country of more than 81 million people, spanning the length of Europe from the Baltic Sea in the north down to the Swiss and Austrian border in the south, the NPM comprises just five part-time Commissioners and a full-time support staff of three persons. This lamentable state of affairs is distinctly unacceptable and has been the source of criticism for the UN Committee against Torture.<sup>22</sup>

It should also be noted that, unlike a well-functioning and respected existing NHRI, a new and unknown NPM may face difficulties in building public confidence regarding its work and establishing its legitimacy and credibility. Awareness-raising activities aimed at informing the authorities and civil society about the NPM's mandate, role, powers and guarantees will be crucial in surmounting these challenges.

Like NHRI-NPMs, certain specialized

<sup>21</sup> For more information please see: <http://www.nationale-stelle.de/index+M52087573ab0.html>

<sup>22</sup> UN Doc. CAT/C/DEU/CO/5, 12 December 2011 – paragraph 13.

байгууллага байгуулах нь өөрийн гэсэн давуу талтай нь маргаангүй юм. Тиймэрхүү байгууллага нь урьдчилан сэргийлэх тодорхой, чиглэсэн мандаттай байхын хувьд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудалд тэргүүлэх ач холбогдол өгч чадна. Түүний дүнд өргөн мандат бүхий бусад байгууллагуудаас илүү нөлөөлөл үзүүлж болох юм. Улс орнуудын хувьд одоо оршин үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын үүсгэн байгуулсан хууль тогтоомжийг өөрчлөхөөс илүүтэй шинэ байгууллага байгуулах хууль тогтоомж батлан гаргах нь хялбар байж болно. Түүнээс гадна шинэ хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж байгаа шинэ байгууллага нь мандат, бие даасан байдал, эрх мэдэл, ажилтнуудынхаа мэргэжлийн хүрээгээр одоо байгаа байгууллагаас илүү Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд нийцэх байж магадгүй.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын энэ загвар нь огтхон бэрхшээлгүй ажиллах юм бас биш. Магадгүй хамгийн хүнд сорилт нь ялангуяа дэлхийн эдийн засаг хүнд нөхцөлд байгаа өнөө үед шив шинэ байгууллага үүсгэн байгуулах санхүүжилтийг бий болгох алхам юм. Жишээ нь Бүгд Найрамдах Киргиз Улс урьдчилан сэргийлэх үндэсний механизмын талаарх дэлхийн жишигт хүрэхүйц хуультай, тэр нь 2012 оны 7 дугаар сард хүчин төгөлдөр болсон боловч эдийн засгийн хувьд буурай энэ орон тус байгууллагыг байгуулахад шаардлагатай хөрөнгө бий болгох хэцүү асуудалтай тулгараад байна.

Мөн түүний адилаар Германы урьдчилан сэргийлэх үндэсний механизм хүн хүчний хувьд тун тааруу нөөцтэй юм.<sup>21</sup> Хойд зүгээс Балтийн тэнгисээс өмнө зүгт Швейцарь, Австри улсуудтай хиллэн тогтсон нутагтай 81 сая гаран хүн амтай улсын хувьд урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь бүтэн орон тооны бус тавхан гишүүн, орон тооны гуравхан ажилтнаас бүрдэж байгаа юм. Энэ харуусалтай нөхцөл байдлыг хүлээн

<sup>21</sup> <http://www.nationale-stelle.de/index+M52087573ab0.html> хаягаар үзнэ үү.



NPM bodies also suffer from an over-representation of the lawyers in their staff composition. The German and Swiss NPMs both have shortcoming in this connection. In contrast, other newly created NPMs, such as the French NPM, the General Inspector of Places of Deprivation of Liberty, has been very successful in attracting a diversity of professions. In a sum, there are both pluses and minuses associated with the establishment of new specialized bodies as the NPM.

#### (4) Multiple Body NPMs

Inevitably, certain NPM structures do not easily fall within the three above described categories. This category of NPMs constitutes the fourth NPM trend seen in practice. These are mostly multiple body NPMs based on the geographic, thematic or jurisdiction focus (or a mixture thereof) of their constituent bodies. For instance, the Maltese and Swedish NPMs comprise two institutions, while New Zealand and Holland's NPMs comprise 5 and 6 different bodies respectively. In stark contrast, the United Kingdom designated 18 existing bodies which are coordinated by Her Majesty's Inspectorate of Prisons in England and Wales.<sup>23</sup>

One of the main challenges faced by such multi-body NPMs is, unsurprisingly, that of coordination. This may be especially problematic when more than body has the responsibility to monitor one specific category of detention facility. For example, in England and Wales three different bodies can potentially visit police

зөвшөөрч болшгүй бөгөөд НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг хорооноос шүүмжлэл хүлээх шалтгаан болоод байна.<sup>22</sup>

Одоо байгаа, үйл ажиллагаа нь цэгцэрсэн, нэр хүндтэй хүний эрхийн үндэсний байгууллагуудаас ялгаатай нь шинэхэн, олонд танигдаагүй урьдчилан сэргийлэх үндэсний механизмд үйл ажиллагааныхаа хувьд олон нийтийн итгэлийг олох, эрх мэдлээ хүлээн зөвшөөрүүлж байр сууриа олоход хүндрэлтэй тулгарч болох юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат, гүйцэтгэх үүрэг, бүрэн эрх, баталгааныхаа талаар албан тушаалтан, иргэний нийгэмд мэдээлэл өгөхөд чиглэсэн сурталчилгаа, мэдээлийн үйл ажиллагаа нь эдгээр сорилтыг даван туулахад онцгой чухал юм.

Хүний эрхийн үндэсний байгууллага-иргэний нийгмийн байгууллагын адилаар тухайлан байгуулсан урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага нь бүрэлдэхүүний хувьд мөн л хуульчдын төлөөлөл давамгайлах хандлагатай байдаг. Герман болон Австрийн урьдчилан сэргийлэх үндэсний механизм хоёулаа үүнтэй холбоотой бэрхшээлтэй байна. Харин Францын урьдчилан сэргийлэх үндэсний механизм болох хүний эрхийг хязгаарласан газруудын асуудал хариуцсан Ерөнхий Байцаагч зэрэг бусад шинээр байгуулагдсан урьдчилан сэргийлэх механизмууд олон мэргэжлийн боловсон хүчин тагаж бүрэлдүүлэх тал дээр амжилт гаргасан байна. Ерөнхийдөө шинээр урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага үүсгэн байгуулах нь эерэг ч сөрөг ч талтай нь харагдаж байгаа юм.

#### (4) Олон байгууллагаас бүрдсэн урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандат

Зарим урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүтэц дээрх гурван ангиллын алинтай нь ч таарахгүй байх тохиолдол байна. Ийм хэлбэрийн урьдчилан сэргийлэх механизмууд практикт дөрөв дэх чиг

<sup>23</sup> For more information please see : <http://www.justice.gov.uk/about/hmi-prisons/preventive-mechanism>

<sup>22</sup> НҮБ-ын баримт бичиг. CAT/C/DEU/CO/5, 2011 оны 12 дугаар сарын 12 – 13 дахь заалт.

detention facilities, while in Northern Ireland prisons are in theory covered by three different institutions, all of which are members of the NPM. More often than not, these multi-body NPMs have or are in the process of establishing internal coordination points in order to pave the way for their overall affective functioning.

It should also be noted that a number of the other challenges highlighted in this paper can also impact on multiple body NPMs, including problems relating to a lack of human and financial resources, perceptions of independence and effectiveness, complaints-handling and ensuring preventive visits and staff composition.

## Conclusion

This paper has attempted to give the reader in Mongolia an informed overview of how the OPCAT is being implemented in practice. This same issue is currently under discussion in Mongolia and it is therefore hoped that this paper will somehow contribute to this discussion. There are unmistakably advantages and disadvantages associated with the different approaches to implementing the instrument at the national level, which human rights actors and decision-makers in Mongolia must remain mindful of.

As noted previously, the first national round-table to discuss the possible ratification and implementation of the OPCAT took place in Ulaanbaatar in April 2008. Since then, various further round-table and training events have taken place, the most recent of which took place in April 2012, which a member of the SPT attended. In addition, at the domestic level

хандлага болж байна. Эдгээр нь их төлөв газар нутаг, хариуцсан асуудал, эрх мэдлийн чиглэл дээр суурилсан байгууллагууд байдаг. Жишээ нь Малтийн болон Шведийн урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд тус бүр хоёр байгууллагаас бүтдэг бол Шинэ Зеланд, Нидерландын урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд тус бүр таваас зургаан өөр өөр байгууллагаас бүрддэг юм. Их Британий үндэсний механизм бүр эсрэгээрээ 18 байгууллагаас бүрдэх бөгөөд Англи, Уэльс дэх хатан хааны хорих байгууллагуудыг хариуцсан Ерөнхий Байцаагчийн алба зохицуулалтыг нь хангадаг байна.<sup>23</sup>

Ийм хэлбэрийн олон байгууллагаас бүрдсэн урьдчилан сэргийлэх үндэсний механизмд тулгардаг гол бэрхшээл бол мэдээж хоорондын зохицуулалт. Энэ нь тодорхой нэг төрлийн хорих байгууллагад нэгээс дээш тооны байгууллага хяналт тавих үүрэг хүлээсэн бол бүр ч ярвигтай асуудал болно. Жишээ нь Англи, Уэльсд цагдаагийн харьяа хорих байруудад шалгалт хийх гурван байгууллага байдаг бол Умард Ирландын хорих байгууллагуудыг хамаарах гурван өөр байгууллага байгаа нь бүгд урьдчилан сэргийлэх үндэсний механизмын гишүүн байгууллага байдаг. Ийм олон байгууллагаас бүрдсэн урьчилан сэргийлэх үндэсний механизмууд ихэнхдээ нийтлэг үр дүнтэй үйл ажиллагааг хангахын тулд дотоод зохицуулалтын журамтай байдаг буюу тийм зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байгаа ажээ.

Энэ нийтлэлд онцолсон бусад бэрхшээлүүд түүний дотор хүний нөөцийн болон санхүүжилтийн дутмаг байдал, бие даасан хараат бус байдал, гомдол хянан шийдвэрлэлт, урьдчилан сэргийлэх шалгалтууд, албан хаагчдын орон тооны бүтэц зэрэг асуудлууд нь энэхүү ангиллын урьдчилан сэргийлэх механизмд тулгардгийг тэмдэглэх нь зүйтэй.

## Дүгнэлт

Энэ нийтлэлээр Монголын уншигчдад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг практикт хэрхэн хэрэгжүүлдэг талаар тойм ойлголт өгөхийг зорилоо.

<sup>23</sup> <http://www.justice.gov.uk/about/hmi-prisons/preventive-mechanism> хаягаар орж үзнэ үү.

various working groups have been set up to discuss this matter, comprising representatives from government and non-government circles as well as the country's NHRI, the National Human Rights Commission of Mongolia.

In the wake of these constructive and interesting exchanges it can only be hoped that Mongolia takes the step in the near future to sign and ratify the OPCAT. In doing so, Mongolia will join the ever expanding number of countries which have committed themselves to taking concrete measures to prevent acts of abuse and unacceptable conditions of detention. After all, the depressing images of acts of abuse and conditions of detention conveyed in the opening paragraphs of this article are, needless to say, not just phenomena found in Serbia. They are regrettably acts found in all countries to some extent, including Mongolia, which we are all legally and morally obliged to prevent.

\*\*\* Geneva, 9 February 2013

Монгол Улсад яг одоо энэ асуудлаар хэлэлцэж буй тул энэхүү нийтлэл тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна. Энэхүү баримт бичгийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэлбэрүүдтэй холбоотой эерэг болон сөрөг тал гарцаагүй байгааг Монгол Улсын хүний эрхийн байгууллага, хувь хүмүүс, шийдвэр гаргагчид анхааралдаа авах бизээ.

Өмнө нь дурдсанчлан Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлах эсэх тухай болон хэрэгжүүлэх талаар үндэсний хэмжээний анхны хэлэлцүүлэг 2008 оны 4 дүгээр сард Улаанбаатарт болсон юм. Түүнээс хойш олон хэлэлцүүлэг уулзалт болсноос хамгийн сүүлийнх нь 2012 оны 4 дүгээр сард болж Эрүү шүүлтээс Урьдчилан сэргийлэх Холбооны гишүүн оролцов. Түүнээс гадна дотоодын түвшинд энэ асуудлыг хэлэлцэхээр төрийн болон төрийн бус байгууллагууд, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон олон янзын ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж ирлээ.

Ийнхүү бүтээлч, санаачлагатай, сонирхолтой арга хэмжээнүүдээр санал солилцсоны үр дүнд Монгол Улс ойрын ирээдүйд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколд гарын үсэг зурж, соёрхон батлах буй за хэмээн найдаж болохоор боллоо. Тийнхүү соёрхон баталснаар улам бүр нэмэгдэн буй олон улс орны хамтаар шорон, хорих байгууллага дахь зүй бус байдал, тэвчишгүй нөхцлийн эсрэг тэмцэх үйлст нэгдэх болно. Энэ бүхний эцэст нийтлэлийн эхэнд дурдсан хорих байгууллага дахь зүй бус байдал, хүнд нөхцөл дан ганц Сербэд тохиолддог үзэгдэл биш гэдэг нь маргаангүй. Харамсалтай нь энэ бол Монгол Улсыг оруулаад бүх оронд тохиолдож байгаа хууль зүйн үүднээс ч, ёс зүйн үүднээс ч хориглож, урьдчилан сэргийлэх ёстой үйлдлүүд билээ.

\*\*\* Женев хот  
2013 оны 2 дугаар сарын 9

## ШОРОН ДАХЬ ЭРҮҮ ШҮҮЛТ



Шихихутуг ХЗДС-н багш, докторант,  
Монгол Улсын Гавьяат хуульч

### Р.ОЮУНБАДАМ

Өнөөгийн монголчуудын зарим нь бусдыг хөрөнгө чинээ нийгэмд эзлэх байр суурь, ажил албаны байдал, зүс царай, насаар ялгаварлах үзэл давамгайл болжээ гэвэл олон хүн санал нийлэх байх. Тэгвэл хүүхэд, хөгшдийн асрамжийн газрууд, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эмнэлгүүд, архи, согтууруулах, мансууруулах донтой хүмүүсийг албадан эмчлэх газар, мөрдөн байцаах газар, хорих, цагдан хорих газруудад нийгмийн дотор алагчлал байхгүй гэвэл бас үнэмших хүн ховор бизээ.

Эрхэм уншигч Та бүхэнтэй эрүү шүүлт хүнлэг бус харьцаа гэж юу болох, эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаатай хэрхэн тэмцэх ёстой. Олон улсын гэрээ конвенцид эрүү шүүлт хүнлэг бус харьцааг хэрхэн заасан тухай, тэр дундаа шорон дахь эрүү шүүлтийн талаар санал бодлоо хуваалцахыг зорилоо.

1992 оны Үндсэн хуульд “Монголын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцдуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно” хэмээн тунхаглаад 20 гаруй жилийг ардаа үджээ. **“Хүмүүнлэг” гэсэн есөн үсэгтэй сайхан үгийг хэрэглэх**

### **нь олонтаа ч ойлгосон нь бага байх шиг.**

Хүмүүнлэг гэсэн үгийг Монгол хэлний язгуур утгаар нь үзвэл ердөө л “нинжин сэтгэл” гэсэн үг юм байна. 1984 онд НҮБ-аас хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах ба шийтгэхийн эсрэг конвенц батлагдсан бөгөөд 1990 оноос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрүүгийн тогтолцооны комиссын хуралдаанаас шүүхийн өмнөх шатанд хоригдож байгаа хүмүүстэй хэрхэн харьцах хандлагын талаар мөн хүний эрхийн дэлхий дахины бага хурал Венийн тунхаглал зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд батлагдан гарсан нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хөдөлгөөн дэлхий дахинд өрнөсөн гэхэд болно. НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид “Эрүүдэн шүүх гэдэг нь төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж буй этгээд хэн нэг хүн буюу гуравдахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гуравдахь этгээдийг

үйлдсэн гэж сэрдэгдэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн гуравдахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлдэг гэж тодорхойлжээ<sup>24</sup>.

Эрүү шүүлтийн талаар цөөн үгээр тайлбарлахад амаргүй тул жаахан нуршуу авч үзэх болж байна. Эрүү шүүлтийн тухай Монгол Улсын хуулиудад төдийлөн дэлгэрэнгүй задаргаатайгаар хуульчлагдаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Хүний эрхийн тухай Америкийн Конвенц зэрэгт “харгис хэрцгий” гэсэн нэр томъёог агуулаагүй байна. Харин Европын Хүний эрхийн тухай Конвенцийн 3 дугаар зүйл болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “...хэнийг ч эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар харьцах ба шийтгэхгүй байх” гэж онцгойлон авч үзсэн. Зарим эрх зүйн баримт бичигт, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн хувьд хүнлэг ёсоор бие хүний хувьд угаас заяасан нэр төрийг хүндэтгэн харьцах учиртайг заасан. Монгол Улс шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд хүний эрхийг бүхий л талаар хамгаалах олон арга хэмжээ авч явуулж байсны нэг нь төрийн болоод төрийн бус байгууллагууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олны чихэнд хүчтэй сонсогдох хэмжээний ажлууд зохион байгуулж байв. Ялангуяа манай улс 2000 оны эцсээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орсон нь эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх орнуудын эгнээнд

багтсан юм. Ардчилсан нийгмийн хамгийн үнэт зүйлийн нэг бол хүний төрөлхийн заяамал нэр төрийг тэдний хувийн болон нийгмийн байдлаас үл хамааран хүндэтгэн үзэх явдал мөн. Хүмүүнийг хэр зэрэг эрхэмлэн үзэж байгаа нь аливаа нийгэмд эрүүгийн хуулийг зөрчсөн эсвэл зөрчсөн гэж буруутгагдаж байгаа хүмүүст хэрхэн хандаж байгаагаар илэрнэ. Эдгээр хүмүүс нь өөрсдөө бусдын заяамал нэр төр, эрхийг хүндэтгээгүй боловч хорих газрын ажилтнууд нь тэдний хийсэн хэргийг эс харгалзан нийгмийн нэрийн өмнөөс хүндэтгэн үзэх онцлог үүрэг хүлээдэг. Хорих байгууллагын үйлчилгээ нь эрүүгийн шүүхийн тогтолцооноос иргэний заяамал эрхэд шилжихэд нөлөөлөл үзүүлэх ёстой. Тиймээс хорих газрын харгалзагч бороохой гозогнуулан хоригдлуудын дундуур явах зэрэг бүхий л төрлийн дээрэнгүй хандлага харьцааг хориглодог. Эрүү шүүлт нь төрийн албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдийн санаатай буюу санамсаргүй үйл хөдлөлөөр үйлдэгддэг.

**Эрүү шүүлт, хэрцгий хандах гэдэгт:** Хилсээр хэрэг хүлээлгэх, албадан мэдүүлэг авах, эрүү шүүлт тулгахаар заналхийлэх, тохуурхан даажигнах, доромжлон гутаах, зодох, бие махбодид ямар нэг төрлийн гэмтэл санаатай учруулах, тарчлаан зовоох мөн

**Хүний нэр төрийг доромжлон гутаах гэдэгт:** Ор үндэсгүй мэдээ, мэдээллийг зохиох, хуурамч нотлох баримт бүрдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж олон нийтийн хүртээл болгох зэрэг үйлдлүүд орно.<sup>25</sup>

**Хүнлэг бус харьцаа** энэ талаар конвенцид тусгайлан тодорхойлолт өгөөгүй боловч аливаа хэлбэрээр хоригдож, эрх нь хязгаарлагдсан хүний өдөр тутмын хэвийн

<sup>24</sup> Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх 1997 он 63 дахь тал.

<sup>25</sup> Шударга шүүхээр шүүлгэх эрх Эмнести Интернэшнл – 2012 он 88, 89 дэх тал



амьдралын нөхцөл байдлыг доройтуулж буй үйлдлүүдийг хэлдэг. Тухайлбал, эрх нь хязгаарлагдсан хоригдогчдод хоол хүнс, ундны усны хангамж, хувцас, ариун цэвэр болон эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байгаа байдал, орон байрны хүрэлцээгүй, агааржуулалт муутай, гэрэл гэгээгүй байлгах нь хүнлэг бус харьцааны төрөл мөн. Түүнчлэн хоригдолтой догшин хэрцгий харьцах, төрөл садан ойр дотны хүмүүсээс эргэлт уулзалт авах эрхийг хязгаарлах, тогтоосон журмаас гадуур зохистой хоол ундаар хангагдах эрхийг хязгаарлах, хоригдсон хүмүүсийн салхилах эрхийг хязгаарлах зэрэг нь хүнлэг бус харьцаа юм.

Эдгээр шинж чанар нь тухайн үйлдлийг санаатайгаар хэд хэдэн цагаар тасралтгүй үргэлжлүүлсэн эсэх болон бие махбодь, сэтгэл санааны хувьд бодит хохирол хэр зэрэг учруулсан байх зэргээс шалтгаална. Хохирогчийг айлгах, сэтгэл санаагаар унагаж дордуулсан мэдрэмж төрүүлдэг оюун санааны хувьд үүрдийн эрэмдэг болгодог.

1992 онд Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн бүр халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөтэй байх эрх, амьд явах эрхтэй гэж заасан нь хоригдож байгаа болон цагдан хоригдож байгаа хүнд нэн хамаатай. Эдгээрийн дотроос халдашгүй дархан байх эрхийг дараах байдлаар тайлбарлаж байна. Хоригдогчид хоригдож байх хугацаандаа эрүү шүүлтэд өртөхгүй байх, хилсээр хэрэгт тулгуулахгүй байх, хэн нэгний дарамт шахалтанд өртөхгүй байх, тэдэнд сэтгэл санааны дарамт учруулахгүй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг орно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн хувьд мөн хорих ялаар шийтгүүлсэн ч ялтан хуулиар олгогдсон эрх эдлэх, үүрэг хүлээх, мэдээлэл авах, гадаад ертөнцтэй харилцах, нөхцөл сайтай

байранд амьдрах, биологийн хэрэгцээ болон алдсан энергийг нөхөх хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, ундны усаар хангуулах, эмнэлэгийн үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон зүйл багтана.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, хууль зүйн ухааны доктор П.Оюунчимэг “Эрүү шүүлттэй тэмцэх үндсэн асуудал, онол практик” бүтээлдээ “Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл ангид зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилгах тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус хүч хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол хэмээн гэмт хэргийн субъектийг зөвхөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хэрэгжүүлэгч гишүүдийн нэг болох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар тогтоосон нь учир дутагдалтай” гэж үзсэн байна. Тэрбээр өнөөдөр хорих, цагдан хорих газруудад эрүү шүүлт зарим талаараа гүнзгий илэрч байгааг шүүмжилжээ. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2010 онд хорих ангиудад хийсэн шалгалтын дүнгээс үзвэл, “...хоригдлууд амралтын байрандаа чөлөөт цагаа тухтай өнгөрөөх, ном соних унших, тоглоом тоглох боломж муутай. Хорих байгууллагын ажилтан албан хаагчдын зүгээс хоригдлуудтай зүй бусаар харьцдаг, хэл амаар доромжилдог, зоддог, сахилгын байранд үндэслэлгүйгээр хорьдог, дэглэмийн дасгал хийлгэдэг, дарамталдаг талаар хоригдлуудтай бүлгээр болон ганцаарчлан уулзах уулзалтын явц дунд их хэмжээгээр гомдол гаргадаг” тухай тэмдэглэсэн<sup>26</sup> байна.

Бичигч бийвээр монголын хорих байгууллагад олон арван жил ажиллаж тэр тусмаа хорих ангийг удирдаж явсан болохоор шорон дахь эрүү шүүлтийн талаар

<sup>26</sup> ХЭҮК-ын 2010 оны тайлан илтгэл

судалдаг нэгэн. 1966 онд батлагдаж гарсан засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн ерөнхий ангид ял шийтгэлийг эдлүүлэхдээ “Хүний бие махбодийг зовоох буюу хүн гэсэн нэрийг доромжлон гутааж болохгүй”<sup>27</sup> гэж хуульчилж өгсөн боловч харамсалтай нь энэ хуулийн бусад зүйл заалтуудад бусад хууль дүрэм журмаар ямарч зохицуулалт хийгдээгүй юм.

Нэгэнтээ эрх зүйн зохицуулалтгүй болохоор хэрэгжүүлэх механизм арга зүйч гэж онцын юм байгаагүй. Нөгөө талаар 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль нь 1931 онд “Монгол улсын доторх аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын батлагдсан тухай” анхны хуулиас даруй 25 жилийн дараа мөн НҮБ-аас батлаж гаргасан “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм” батлагдснаас 11 жилийн дараа батлагдан гарсан. Мөн тэр үеийн ЗХУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулийн нэлээд хэсгийг орчуулан хэрэглэсэн зэрэг олон онцлогуудтай холбон тайлбарлаж болох юм.

Хорих байгууллагын ажилтнууд шорон дахь эрүү, шүүлт хүнлэг бус харьцаа, нэр төрийг гутаан доромжлох тухай онол арга зүйн талаар төдийлөн нарийн мэдлэггүй. Манжийн ноёрхлын үеийн эрүү шүүлт, есөн эрүүгийн зарим төсөөлөлтэй байсан байх. Яагаад гэвэл дараа дараагийн хууль болох 1981 онд батлагдсан Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль, 1993 онд батлагдсан хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль, Сэжигтэн яллагдагчийг цагдан хорих тухай хууль, өнөөдөр дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хууль батлагдсан 2002 оныг хүртэл хоригдогчдод эрүү шүүлт үзүүлэх,

тэдэнтэй хүнлэг бус харьцах тухай эрх зүйн зохицуулалт хуульчлагдаагүй юм. Мөн дүрэм, журамд ч тусгалаа олоогүй хэрэгжүүлэх аргачлал нь ч сул дорой байгаа нь мэдээж хэрэг юм. Өнөөдөр дэлхийн бусад орны хорих байгууллагуудад хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, тэмцэх, арилгах боломжийг бүрдүүлж өгдөг чухал аргачлал бол хорих ялын стандарт юм. Тэгвэл манай хорих байгууллагуудад өнөөг хүртэл хорих ялын стандартгүй байна. Мэдээж хэрэг хүн амьдрах нөхцөл боломжийг хангах нь цөөн хэдэн зүйлээр хязгаарлах асуудал биш юм. Гэвч хүний заяамал эрхийг хангахаас эхлээд амьдралд тохиолдох бүхий л зүйлийг хуульчлах нь нэг талаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөгөө талаар хэдийгээр хоригдож байгаа боловч хүний амьдрал баян учир тэр болгоныг хууль журмаар заагаад байх нь ач холбогдол багатай. Тэгвэл хорих газарт хүний эрхийг зөрчихгүй байхад хамгийн ойр баримт бичиг бол хорих ялын стандарт юм. Энэ сэдвийн хүрээнд хорих ялын үндэсний стандартай болох асуудал бол хойшлуулшгүй ажил мөн. Хорих байгууллага олон талт үйл ажиллагаа явуулдаг, их нарийн төвөгтэй газар гэдгийг хаа хаанаа мэддэг зүйл. Хорих байгууллагын ажилтнууд шүүгч прокурор өмгөөлөгчийн нэгэн адил хууль урдаа тавьчихаад хууль зөрчсөн этгээдтэй харьцдаггүй тийм боломж ч байхгүй. Хорих байгууллагын ажилтан, хууль дүрмээ хэрэгжүүлэхэд мөн хүний эрхийг зөрчихгүй байхад стандарт туслана.

Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд “Хорих, цагдан хорих газар бол заавал хянах ёстой газар” гэж үздэг. Яагаад гэвэл хуулийн дагуу хоригдож буй хүмүүсийн эрх эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдана. Тухайлбал гадагш зорчих, эвлэлдэн нэгдэх эрхээ хязгаарлуулна. Аливаа хэлбэрээр саатуулагдаж байгаа хүмүүс

<sup>27</sup> Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл 5 дугаар боть 2010 он 435 дахь тал

болон хоригдлууд тодорхой хяналтын дор байдаг учраас эмзэг байдаг. Хоригдож байгаа этгээдийн эрхийн зарим хязгаарлалт нь түүний хувь заяанд нөлөөлсөн байдаг. Хуульд тодорхойлсноор хорих, цагдан хорих газар нь хаалттай бүс юм. Тиймээс хоригдогч нийгмээс тусгаарлагдаж нийгмийн гадна үлддэг. Хорих ял эдлэгсэд нь хоригдож байгаа газраа ямар ч цаг үед ширүүн догшин харьцаа амсах, эрүү шүүлтэнд өртөж болзошгүй байдаг. Хорих, цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийнх нь амьдралаар амьдрах боломж олгодоггүй гэх мэт олон эрсдэлтэй учраас хянах ёстой газар юм. “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-д “Гадаад ертөнцтэй аль болох илүү холбоотой байхыг хүлээн зөвшөөрч хөхиүлэн дэмжих нь зүйтэй. Уулзалтын нөхцөл нь аюулгүй байдлын шаардлага ба хүний нэр төрийг хүндэтгэсэн байх ёстой. Гэр бүлтэйгээ тусдаа уулзах өрөө тасалгааг урамшуулан дэмжих ёстой. Хоригдогчид зөвхөн гэр бүл, найз нөхдөөс гадна өмгөөлөгч болон шүүхийн байгууллагын ажилтнуудтай уулзах эрхээр хангагдах ёстой” гэж үзжээ. “Эмэгтэй хоригдлын тоо цөөн байдгаас эмэгтэйчүүд ихэвчлэн гэрээсээ нэлээд зайтай эсвэл байрны нөхцөл муу тохиромжгүй байранд хоригдох нь олонтаа байдаг. Энэ байдал нь хоригдлуудын ар гэрийнхэн нь эргэлтээр ирэхэд хэцүү өртөг зардал ихтэй болгодог байна. Эдгээр байдлыг харгалзан үзэж эргэлтээр ирсэн гэр бүл болон хоригдлуудын хүүхдүүдийн эргэлтийн хугацааг бүхэл эсвэл амралтын өдрийн турш сунгах зэрэг арга хэмжээнүүдийг авч болно” гэжээ<sup>28</sup>. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль жирийн дэглэмд ял эдэлж буй хоригдол бусадтай түр хугацаагаар уулзахад хязгаарлал тогтоогоогүй тул зарим

хоригдлууд ялангуяа эмэгтэй хоригдлууд хувийн хэрэгтээ бараг 20-30 түүнээс ч олон хүн бичүүлсэн байх тохиолдол байдаг. Ар талдаа бололцоотой, хэргийн хувьд ихэвчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн зарим хоригдол шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааны 20 гаруй хувийг гэр бүл найз нөхөдтэйгээ уулзаж эргэлтээр ирсэн зүйлийг идэж уух, элдвийг ярилцан өнгөрөөж байгааг судалгаагаар тогтоосон. Энэ нь сайн талтай ч нөгөө талдаа хорих байгууллагын ажилтны ажлын чанартай цагийг багасгасан, хохирогчийн гомдол дагуулсан, ял завших сул талтай. Хэдийгээр хуульд эрх нь нээлттэй ч хоригдол бүр энэ эрхийг харилцан адилгүй эдэлдэг.

Алслагдсан аймаг орон нутагт гэр бүл, ах дүү нь амьдардаг, унааны зардал амьдралын хүрэлцээгүй байдал өндөр настай эцэг эхтэй, ах дүү садангүй /10-15 жил/-ээс дээш хорих ялтай, олон удаа давтан хэрэг үйлдсэн, ойрын садан төрөл найз нөхдөө гомдоосон гэх мэтээр ихэнх хоригдлууд бусадтай уулзах эрхээ эдлэж чаддаггүй.

2008 онд Хууль зүй хотоод хэргийн яамны сайдын тушаалаар баталсан Хорих ангийн дотоод журамд “...хоригдсон этгээдэд өгөх цай хоол өдөрт 2 удаа халуун хоол, 3 удаа цай, 1 удаа гурилан бүтээгдхүүн, хоногийн хоолны илчлэг нь 3400 ккл-с багагүй байна, нэг удаа олгох цай 1,5л, хоол 0,5л байна” гэжээ<sup>29</sup>. Үүнээс харахад хоригдогчийн хоол ундны хангалт сайн, илчлэг өндөртэй байгаа мэт байвч хуваарилалт хийхэд илчлэг болон хэмжээ тогтооход хүндрэлтэй, магадгүй алагчлал гарч болохоор харагдаж байгаа юм. 1955 онд батлагдсан хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 20-д “Шоронгийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдогч бүрийн эрүүл мэнд, хүч тамирыг

<sup>28</sup> Хүний эрх ба хорих байгууллага гарын авлага. Женев хот 2002 он 97 дахь тал.

<sup>29</sup> Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ШШГБ-ын харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль журмын эмхэтгэл 2011 он 93 дахь тал.



хэвийн хадгалах хангалттай тэжээллэг сайн чанарын сайтар бэлтгэсэн хоолундаар хангах, хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундны устай байх, хоригдлын хоолны амт чанар хэмжээ нэр төрлөөрөө хоригдогчийн эрүүл мэндийн наад захын шаардлагыг хангахуйц байх ёстой” гэжээ<sup>30</sup>. Ийнхүү нийт хоригдогч нарт хамааралтайгаар ерөнхийд нь авч үзлээ. Үүнээс гадна нас хүйсийн ялгаа тухайлбал, эмэгтэйчүүд, насанд хүрээгүйчүүд, цаазаар авах ялтай хоригдлууд бүх насаараа хоригдох болон олон жил хоригдох ялтай хоригдлуудыг олон улсын хэмжээнд онцгой зэрэглэлийн хоригдлууд гэж авч үзэж эрх зүйн байдал, ял эдлүүлэх нөхцөл журмыг бусдаас ялгаатай авч үздэг. Гэвч хоригдлуудтай харьцах болон нөхцөл байдлын нийтлэг зохицуулалт тэдэнд нэгэн адил хамаатай.

**Эмэгтэй хоригдол.** Монгол улсад эмэгтэй хоригдолд хорих ял эдлүүлдэг цорын ганц хорих анги бий. Тэнд насанд хүрээгүй, насанд хүрсэн бүх эмэгтэйчүүд хорих ял эдэлдэг. Эмэгтэй хоригдол хорих ангид шинээр ирэхдээ аль эсвэл ял эдлэх хугацаандаа жирэмсэн болох нь цөөнгүй байдаг. Тэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332.1.2-д жирэмсэн бол төрөхөөс өмнө 45 хоног төрснөөс хойш 1 жилээс илүүгүйгээр хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулдаг бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332.2-д онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон жирэмсэн хоригдолд энэ эрх эдлэхийг хориглосон тул зарим эмэгтэйчүүд 0-1 хүртэлх насны хүүхэдтэйгээ хорих анги дээр хамт байдаг. Мөн жирэмсэн эмэгтэйчүүд жирийн чанга дэглэмд хорих ял эдлэдэг. Баривчлах ялтай эмэгтэйчүүд ч нэг

хамгаалалтын бүсийн дотор ял эдэлдэг. Хүнд хэлбэрийн сүрьеэтэй бусад халдварт өвчтэй хоригдлыг ч эмэгтэй гэдэг утгаараа өөр тийш шилжүүлэх боломж муутай. Эмэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдсноос сэтгэл санааны шаналал, стрейс ихтэй, гэр бүл үр хүүхэддээ илүү зовдог, эмзэг сэтгэлгээтэй биологийн онцлогтой гэх мэтээр тоочоод байвал ялгаа ихтэй. Цагдан хорих төвүүдэд дунджаар 100 шахам эмэгтэй хоригддог. Тэд сэжигтний, яллагдагчийн давж заалдах хугацаанаас хамаараад хамгийн багадаа 14 хоног тэгээд цаашаа сар жилээр ч хоригдох тохиолдол бий. Гэвч эмэгтэй хүнийг цагдан хорих нөхцөл журам тухайлбал, хоол хүнс, хувцас, ариун цэвэр, эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэх мэт олон асуудал нь зайлшгүй онцлог зохицуулалттай байх ёстой. Харамсалтай нь манай хууль, дотоод журамд жирэмсэн эмэгтэйн талаар ганц хоёр зүйл дурдсанаас өөр зохицуулалт байдаггүй. Иймд жирэмсэн биш бусад эмэгтэй хоригдогчийн онцлогт нь тохирсон зохицуулалт үгүйлэгдэж байна. НҮБ-с 1955 онд баталсан Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм болон тусгайлсан баримт бичгүүдэд “...Эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хэрэгсэл тавьж олгох нь зүйтэй. Хоригдогчийн хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй. Хувцас нь цэвэр бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас тавьж олгож байвал зохино. Эмэгтэйчүүд хувийн ариун цэвэр сахиу үүднээс хэвийн болон сарын тэмдэг үзэгдэх үед шаардлагатай хэрэгслээр тогтмол хангах ёстой” гэж үзсэн байна. Мөн эмч, эмнэлгийн ажилтнууд хоригдсон буюу саатуулагдсан хүмүүсийн биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах, хоригдоогүй буюу саатуулагдаагүй хүмүүсийн адил чанар түвшинд өвчнийг нь

<sup>30</sup> Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх 1997 он 5 дахь тал

эмчлэх үүрэгтэй. Хорих ял эдлэх хугацааг хойшлуулах боломжгүй зарим эмэгтэйчүүд хүүхдээ өөр ердийн эмнэлэгт гаргахад зохих дэмжлэг үзүүлнэ. Хүүхэд эхтэйгээр хамт хорих газарт байх тохиолдолд сайтар анхаарал тавих шаардлагатай. Хүүхэдтэйгээ хамт хорих анги дээр байгаа эмэгтэйчүүдийн талаар дэлхийн улс орнуудын хууль тогтоомж харилцан адилгүй байдаг. Зарим улс оронд эмэгтэй хоригдлуудад хүүхдээ тодорхой хугацаанд, тухайлбал, 9 сар, 18 сар буюу 2-5 нас хүртэл өөр дээрээ байлгахыг зөвшөөрдөг. Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд эх нь хоригдол бол эх хүүхдийн хоорондын харилцаанд хохирол учирдаг гэж үздэг. Бүхий л тохиолдолд хүүхдийн эрх ашгийг илүү харгалзан ээжтэй нь үлдээх эсвэл гэр бүлийн аль нэг гишүүнээр асрамжлуулах талаар шийдвэр гаргах хэрэгтэй. Боломжит бүх хувилбаруудыг авч үзсэний дараагаар л жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа эхчүүдийн хорих газарт хорих ёстой. Тухайн хоригдлын суллагад хугацаа ойртсон тохиолдолд хүүхдийг өөр дээр нь байлгах тусгай арга хэмжээ авах шаардлагатай гэж үздэг<sup>31</sup>. Монгол улсын эмэгтэйчүүдийн хориход хуулийн дагуу 0-1 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүд 5-10 бий. Хэвлэл мэдээллийн зарим хэрэгслээр **“Өргөст торонд боодолтой нярай”** гэх мэт сүржин шүүмжлэлд өртдөг. Гэвч хүүхдийн эрхийн конвенцид Хүүхэд хаана байгаагаас үл хамааран хөхөөрөө бойжих учиртай ээжтэйгээ хамт байх ёстой гэж үздэг. 2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль баглагдахаас өмнө эх хорих ял эдлэх хугацааг хойшлуулах эрхийг хуулиар хориглосон зарим хоригдлын хүүхдийг эмнэлэгт төрүүлээд 1-2 хонуулаад эхээс нь салгаж нярайн асрамжийн газарт болон гэрт

нь өгдөг байв. Энэ нь нэг талаар Монгол Улсын нэгдэн орсон конвенцтой зөрчилддөг. Нөгөө талаар 1-2 хоногтой хүүхэд эхээсээ холдоод амьдрах чадвар муутай, эх нялхасын эрүүл мэндийн эрх зөрчигдөх болно. Зарим эмэгтэй хоригдлууд зан төрхийн хувьд нэлээд гүнзгий эвдэрсэн байдаг учир сул доройгоо дарамтлах нэр хочоор дуудах зэрэг нэр төрийг нь гутаах доромжлох явдал бий. Хорих ангийн зарим ажилтнууд хоригдлыг хулгайчаа гэж дуудах, дээрэнгүй харьцах, доромжлох үйлдсэн гэмт хэргийн тухай өөр хоорондоо ярилцах зэрэг ёс зүйгүй үйлдлүүд гардагийг үгүйсгэх аргагүй юм.

Усны хүрэлцээгүй, олон хоногоор усанд орохгүй байх, бие засах газар нь хол, гадаа байдаг, цагаар бие засуулдаг зэрэг зөрчлүүд байна. Цөөн боловч хорих анги дахь хөгжлийн бэрхшээлтэй хоригдлууд эрүү шүүлтэд өртөмтгий бүлэг юм. Ялангуяа тэднийг бусад хоригдлууд гутаан доромжилдог практик бий. Иймд бусад хоригдлоос ялгамжтай нөхцлөөр ял эдлүүлэх боломжийг бүрдүүлэх хууль журмандаа эрх зүйн зохицуулалт оруулах зэрэг зайлшгүй ажиллагаа дутагдаж байна.

Хорих, цагдах хорих байгууллагын ажилтнууд эрүү шүүлтээс ангид байхын тулд анхаарах асуудал олон байна. Заримаас нь дурдвал, албан хаагчдын чадварыг дээшлүүлэх хөлтөлбөрийг тусгай үе шат, бодлоготойгоор хэрэгжүүлэх ажлыг хийх хэрэгтэй байдаг. Эрүү шүүлтэнд өртсөнөөр хохирогч ихэвчлэн хүчтэй сэтгэлийн хөдлөлд орж ичгүүр, гутамшиг, дарамтыг мэдэрч тодорхой бус хугацаагаар саатлын байдалд орох сэтгэл санаагаар унах, гутрах, үл итгэх итгэлийг өөртөө бий болгодог учир энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хянагч, жижүүрийн офицер эмнэлэгийн ажилтнуудад мэргэжлийн сургалт байнга явуулж байвал зохилтой.

<sup>31</sup> Олон улсын шоронгийн холбооны 8-р бага хурлын илтгэл Канад Улсын Ванкувар хот 2006.10-р сарын 13-20.

Даяарчлалын эрин үед Монгол Улс зөвхөн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний эрхийг хамгаалах асуудлын талаар авч үзэх нь явцуу асуудал учраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийг мөрдөх, бусад орны сайн туршлагуудыг өөрийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлэх боломжуудыг бүрдүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Хүнлэг бус харьцааг хүнлэг харьцаа болгоход нөлөөлөх чухал хүчин зүйлийн нэг нь хорих ял эдлүүлэх нөхцөл журам мөн. Иймд хорих ангиуд хөндлөнгийн мониторинг хийлгэж байх шаардлагатай.

Эрүү шүүлтийн талаарх гарын авлагаар ажилтнуудыг хангах, сургалт явуулах, тэдний ажил дүгнэх үзүүлэлтүүдэд хоригдогчидтой зүй бус харьцахгүй байх гэсэн шалгуур үзүүлэлт оруулах, ажилтны ёс зүйн дүрмэнд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг арга хэмжээ авбал зохино.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл өгөхдөө хоригдогчийн нэр төрийг гутаан доромжилсон шинжтэй мэдээ мэдээлэл гаргахгүй байх нь чухал юм. Ялангуяа тэдний үйлдсэн гэмт хэргийн талаар нарийвчлан мэдээлэх нь эрүү шүүлтийн төрөл гэдгийг анхаарууштай асуудал юм. Хорих ялын

үндэсний стандарт боловсруулж хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнээр батлуулан мөрдөж ажиллах хэрэгтэй байна.

Энэ бүхнээс дүгнэн үзвэл эрүү шүүлтийн эсрэг конвенцийг хэрэгжүүлэх болон хэрцгий догшин хүнлэг бус харьцаа, хоригдогчийн нэр төрийг гутаан доромжлох аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхэд дэлхийн бусад орны хүмүүсээс илүү хялбар хэрэгжүүлэх боломж монголчуудад бий. Ийм боломж монгол хүний дотоод мөн чанарт нь, хүн чанарт нь, байгаа гэж үзэж байна. Учир нь монгол хүн өр нэмгэнтэй өрөвч зөөлөн сэтгэлтэй хүмүүс. Бас үнэний мэдрэмжтэй ард түмэн. Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хууль зүйн энэрэнгүй зарчмыг өргөн утгаар хуульчилж өгсөн байдаг. Хууль зүйн энэрэнгүй ёсны зарчим, хүмүүнлэг ёс хоёр ижил утгатай язгуур ойлголт билээ. Энэрэнгүй ёс, энэрэнгүй сэтгэл, хүн хүндээ энэрэнгүй хандах нь бүгд л хүний нинжин сэтгэлээс урган гардаг. Иймд төрийн албан тушаалтны энэрэнгүй хандлага нь аливаа асуудалд уян хатан, өршөөнгүй, өрөвч зөөлөн хандаж амьдралын сайн мууг, асуудлын зөв бурууг ялгах ур чадвартай байх шаардлагатай гэж үзэж байна.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## НУБ-ЫН ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ<sup>32</sup>-Д ДЭЛХИЙН УЛСУУД НЭГДЭН ОРСОН НЬ



Хүний эрхийн Үндэсний Комиссын  
Гомдол, хяналт шалгалт, дүн шинжилгээний  
хэлтсийн дарга, докторант

**Г.АГАР-ЭРДЭНЭ**

### Нэмэлт Протоколын тухай товчхон

1987 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Европын конвенц батлагдаж, 1989 оны 2 дугаар сараас хүчин төгөлдөр болсон бөгөөд уг конвенцоор Эрүүдэн шүүхээс сэргийлэх Европын хороо байгуулагдсан болно. Ийнхүү Европын зөвлөлийн гишүүн бүх улсууд дахь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн байгаа газарт очиж хяналт тавих эрхийг тус хороонд олгосон байдаг. НУБ-аас Эрүүдэн шүүхээс сэргийлэх Европын хорооны үйл ажиллагааг сайшаан дэмжиж, мөн тус хорооны явуулж буй үйл ажиллагааг дэлхий нийтэд түгээх нь зүйтэй гэж үзсэн ба 1993 оны 6 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд Австрийн Вена хотноо хуралдсан Хүний эрхийн Дэлхийн бага хурлаас эрүү шүүлтийг устгахад чиглэсэн арга хэмжээ нь нэн тэргүүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд чиглэгдэх ёстой гэдгийг шийдвэртэй мэдэгдэн, хорих байрыг тогтмол эргэж байх урьдчилан сэргийлэх

<sup>32</sup> НУБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол

тогтолцоог бий болгох зорилгоор Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколыг баглахыг уриалжээ.

Ийнхүү НУБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэсний үндсэн дээр, мөн Европын эрүүдэн шүүх явдалтай тэмцэж буй туршлагад тулгуурлан эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн байгаа газрын үйл ажиллагааг тогтмол хянах олон улсын тогтолцоог бий болгоход чиглэгдсэн Нэмэлт Протоколыг 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, дэлхийн 20 улс<sup>33</sup> соёрхон баталсны дараа 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

<sup>33</sup> НУБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү протокол нь хорь дахь соёрхон баталсан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно.” гэж заасан.

### Нэмэлт Протоколд дэлхийн улсуудын нэгдэн орсон байдал

Нэмэлт Протоколд 2013 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дэлхийн 67 улс нэгдэн ороод буй бол 20 улс нэгдэн орохоор гарын үсэг зураад байна. Эдгээрийг 1, 2 дугаар хүснэгтэд үзүүлэв.

#### Хүснэгт №1 Нэмэлт Протоколыг соёрхон баталсан, нэгдэн орсон улсууд

Тив	Тоо	Улсуудын нэрс
Ази	7	Казахстан, Киргизстан, Камбож, Филиппин, Ливан, Турк, Малдив
Европ	32	Албани, Их Британи, Португал, Испани, Франц, Голланд, Дани, Швед, Эстони, Швейцарь, ХБНГУ, Польш, Чех, Австри, Украин, Молдав, Румын, Серби, Словени, Хорват, Босни Герцеговин, Македон, Болгар, Кипр, Унгар, Лихтенштейн, Люксембург, Мальт, Монтенегро, Азербайжан, Армени, Гүрж.
Америк	14	Аргентин, Мексик, Гветамал, Гондурас, Никарагуа, Коста Рика, Панама, Эквадор, Перу, Бразил, Болив, Парагвай, Уругвай, Чили
Африк	12	Тунис, Мавритани, Мали, Сенегал, Буркина-Фасо, Того, Либер, Бенин, Нигери, Габон, БНА Конго Улс, Мавритын арлууд
Австрали ба Номхон далайн орнууд	2	Шинэ Зеланд, Науру
Нийт	67	

#### Хүснэгт №2 Нэмэлт протоколд нэгдэн орох гэрээнд гарын үсэг зурсан улсууд

Тив	Тоо	Улсуудын нэрс
Ази	1	Тимор
Европ	7	Ирланд, Исланд, Норвеги, Финланд, Бельги, Итали, Грек
Америк	1	Венесуэл
Африк	10	Капе Верди, Сиерра Леон, Гвиней, Гана, Камерун, Замби, Мадагаскар, ӨАБНУ, Чад, БН Конго Улс,
Австрали ба Номхон далайн орнууд	1	Австрали
Нийт		20 улс

Нэмэлт Протоколд Европын 50 улсаас 32 нь нэгдэж ороод байгаа нь өндөр үзүүлэлт юм. Энэ нь дээр дурдсан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Европын конвенц болон түүнд үндэслэн байгуулагдсан Эрүүдэн шүүхээс сэргийлэх Европын хорооны үйл ажиллагаатай нягт холбоотой. Учир нь Нэмэлт Протоколд нэгдэн орсон Европын улсуудын дийлэнх нь тус хороонд гишүүнчлэлтэй байдаг. Харин Литва, Итали, ОХУ, Монако, Сан Марино зэрэг Нэмэлт Протоколд нэгдэж ороогүй улсууд хороонд гишүүнчлэлтэй бөгөөд уг протоколд нэгдэн орох талаар идэвхитэй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээн ажиллаж байна.

Азийн ихэнх орнууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид нэгдэн орсон<sup>34</sup> ч Нэмэлт Протоколд нэгдэх үйл явц хангалтгүй байна.

<sup>34</sup> БНАСАУ, Бутан, Малайз, Вьетнам, Бирм, Саудын Араб, Иран зэрэг цөөн улс нэгдэж ороогүй байна.

Нэмэлт Протоколд Азийн улсуудын нэгдэн орж буй үйл явцад Баруун Австралийн их сургуулийн профессор Нэйл Морган, Ричард Хардинг нар дүн шинжилгээ хийсэн байна<sup>35</sup>. "Тэд Нэмэлт Протоколд Азийн улсуудын нэгдэн орох үйл явц харьцангуй удаашралтай байна" гээд үүний шалтгаан нь дараах хүчин зүйлсээс хамааралтай гэжээ.

Үүнд, **нэгдүгээрт**, Ази бол түүх, газар зүй, улс төр, шашин, үндэстний олон талт шинжээрээ Европ тивтэй харьцуулахад харьцангуй онцлог юм. Зөвхөн нэг жишээ дурдахад дэлхийн хамгийн их хүн амтай долоон улсын тав нь /БНХАУ, Энэтхэг, Индонез, Пакистан, Бангладеш/ тус тивд оршдог. Тийм ч учраас цагдан хорих газар, шорон зэрэгт эрүү шүүлтгийг арилгахад бусад улсуудтай харьцуулахад удаан хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай болдог байна.

**Удаахь** хүчин зүйл нь төсөв, хөрөнгө оруулалтын асуудал юм. Европын нөхцөл байдлаас ялгаатай нь Азийн улсууд эдийн засгийн хөгжлийн түвшнээр харьцангуй доогуур тул эрүү шүүлтгээс илүүтэй хүн амын хүнс, амьжиргаа гэх мэт зүйлд хөрөнгө оруулах шаардлагатай болдог байна. Шоронд ял эдэлж байгаа хоригдлуудыг анхаарахдаа гол төлөв тэдний хоол хүнс, хувцас гэх мэт материаллаг асуудлыг чухалчилдаг гэжээ.

**Гуравдугаарт**, дэлхийн бусад улс, нэн ялангуяа барууны орнуудтай харьцуулахад Азийн улсуудад хүний эрхийн уламжлалт ойлголт, үзэл сэтгэлээ өөрийн гэсэн онцлогтой хөгжсөн гэжээ. Сүүлийн арав гаруй жилд Азийн бүс нутагт хүний эрхийн асуудлыг ихээхэн анхаарах болсныг дурдаад энэ чиглээрх маргаан, хэлэлцүүлэг нь хэд хэдэн сэдвийн хүрээнд өрнөж буйг онцолжээ.

Юуны өмнө НҮБ-ын гэрээ хэлэлцээрээр

<sup>35</sup> Neil Morgan, Richard Harding OPCAT in the Asia-Pacific and Australasia

тодорхойлогдсон “барууны” гэх чиглэлтэй хүний эрхийн тухай ойлголтод дорно дахины үнэлэмжийг тусгах, хүний эрх нь НҮБ-ын конвенцуудад тусгагдсан шиг өргөн хүрээтэй эсэх, эрх гэсэн ойлголттой зэрэгцэн үүргийн тухай ойлголт эн тэнцүү хэрэглэгдэх ёстой эсэхээс авахуулаад хувь хүний бие даасан байдалд чиглэсэн өрнөдийн философи болоод нийгмийн тогтолцоо нь Азийн хамтрал, олон нийтэд чиглэсэн үзэл сэтгэлгээнд нийцэж буй эсэх дээр маргадаг гэжээ.

Хүний эрхийн үндэсний байгууллага бүхий Азийн улсууд Нэмэлт протоколд нэгдэн ороход бусдыгаа манлайлан оролцохыг Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос зөвлөсөн байдаг. Мөн 2011 оны 11 дүгээр сард Швейцарь Улсын Женев хотноо болсон Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн Нэмэлт Протоколын талаарх дэлхийн чуулга уулзалтын үеэр хөндөгдсөн асуудал бол нэмэлт протоколд нэгдэн ороход Азийн улсуудын төр засгийн зүгээс идэвхи санаачлагатай ажиллахыг онцолсон явдал юм. Уг хурлаар Ази-Номхон далайн бүс нутаг дахь 18 Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 нь “А” статустай байгааг анхаарч эдгээр байгууллагууд нь Нэмэлт Протоколд нэгдэж ороход Засгийн газартаа нөлөөлөх хэрэгтэй хэмээн дурджээ<sup>36</sup>.

Нэмэлт Протоколд хамгийн сүүлд 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Португал, 01 дүгээр сарын 24-ний өдөр Науру Улс тус тус нэгдэн ороод байна<sup>37</sup>.

### 3. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухай

Нэмэлт Протоколд зааснаар оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар

<sup>36</sup> The Global Forum on the OPCAT Preventing Torture, UpA holding Dignity: From Pledges to Actions Outcome Report 2012 69-р тал

<sup>37</sup> [http://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?s-rc=TREATY&mtmsg\\_no=IV-9-b&chapter=4&lang=en](http://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?s-rc=TREATY&mtmsg_no=IV-9-b&chapter=4&lang=en)



буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээдэг.<sup>38</sup> Энэ байгууллагыг үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага хэмээн нэрийдэж байна. Үүнийг шүүхийн бус урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэгч механизм гэж үзэж болно.

Тус Протоколд нэгдэн орсон улсуудаас 46 нь урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгон ажиллуулж байна.

*Хүснэгт №3 Урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагатай улсууд*

Тив	Тоо	Улсуудын нэр
Ази	3	Киргизстан, Камбож, Малдив
Европ	28	Франц, Швед, Эстон, Дани, Испани, Голланд, Швейцарь, ХБНГУ, Австри, Чех, Польш, Унгар, Словени, Украин, Молдав, Албани, Македон, Серб, Монтенегро, Хорват, Кипр, Лихтенштейн, Люксембург, Мальт, Их Британи, Гүрж, Азербайжан, Армен
Америк	10	Мексик, Гветмал, Гондурас, Никарагуа, Коста Рика, Эквадор, Чили, Уругвай, Аргентин, Парагвай
Африк	4	Мали, Сенегал, Нигери, Мавритын арлууд
Австрали ба Номхон далайн орнууд	1	Шинэ Зеланд
Нийт		46 улс

Нэмэлт Протоколын оролцогч улсууд урьдчилан сэргийлэх үндэсний байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд

<sup>38</sup> НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын 3 дугаар зүйл.

хараат бус байх нөхцлийг хангах үүрэгтэй ба уг байгууллагыг үүсгэн байгуулахдаа хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагын статус болон үйл ажиллагааны зарчмыг харгалзаж үзэх учиртай.

Дэлхийн улсуудын практикаас үзвэл нийтлэг хэлбэр нь шинээр урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох, эсхүл үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад бүрэн эрх олгох, мөн хэд хэдэн байгууллагад чиг үүргийг хуваарилах замаар хэрэгжүүлж байна.

*Хүснэгт №4*

А. ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМЫН ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА/ОМБУДСМЕН БҮХИЙ УЛСУУД		
Ази	Малдив	Хүний эрхийн Үндэсний Комисс
	Азербайжан	Хүний эрхийн Комиссар
	Армен	Хүний эрхийг хамгаалагчдын газар
	Гүрж	Омбудсмены газар
Европ	Албани	Омбудсмены газар
	Чех	Омбудсмены газар
	Австри	Омбудсмены зөвлөл
	Дани	Омбудсмены газар болон Хүний эрхийн Данийн институт
	Хорват	Омбудсмены газар
	Унгар	Хүний эрхийн Комиссар
	Люксембург	Омбудсмены газар
	Македон	Омбудсмены газар
	Молдав	Хүний эрхийн төв
	Монтенегро	Хүний эрх, эрх чөлөөг хамгаалагч
	Польш	Хүний эрхийг хамгаалагчдын газар
	Словени	Хүний эрхийн Омбудсмены газар
	Испани	Омбудсмены газар
	Украин	Хүний эрхийг хамгаалах парламентын комиссар

Америк	Чили	Хүний эрхийн Үндэсний институт
	Коста Рика	Үндэсний Омбудсмeны газар
	Эквадор	Омбудсмeны газар
	Мексик	Хүний эрхийн Үндэсний Комисс
	Никарагуа	Омбудсмeны газар
	Уругвай	Хүний эрхийн Үндэсний институт
Африк	Мали	Хүний эрхийн Үндэсний Комисс
	Мавритын арлууд	Хүний эрхийн Үндэсний Комисс
АНД	Шинэ Зеланд	Хүний эрхийн Үндэсний Комисс болон бусад 5 байгууллага хамтран
Б. ҮНДЭСНИЙ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМЫН ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ БИЕ ДААСАН БАЙГУУЛЛАГА БҮХИЙ УЛСУУД		
Ази	Киргизстан	Эрүү шүүлтээс сэргийлэх зохицуулах зөвлөл
Европ	Франц	Эрх чөлөөг хязгаарлах газар хариуцсан ерөнхий хянан шалгагч
	ХБНГУ	Эрүү шүүлтээс сэргийлэх үндэсний агентлаг
	Лихтенштейн	Засан хүмүүжүүлэх зөвлөл
	Мальт	Цагдан хоригдсон хүмүүсийн асуудал эрхэлсэн зөвлөл Хорих ангийн асуудал эрхэлсэн зөвлөл
Африк	Нигери	Эрүүдэн шүүхийн асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл
	Сенегал	Эрх чөлөөг хязгаарлах газар хариуцсан үндэсний ажиглагч
Америк	Аргентин	Эрүү шүүлтээс сэргийлэх үндэсний зөвлөл
	Гондурас	Эрүүдэн шүүхийн асуудал эрхэлсэн үндэсний зөвлөл
	Парагвай	Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм

#### 4. Монгол Улсын тухайд

2010 оны 11 дүгээр сарын 5, 8-ны өдрүүдэд НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн талаарх анхдугаар илтгэл (CAT/C/MNG/1)-ийг хэлэлцээд өгсөн зөвлөмждөө "... Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа баривчлах байруудад системтэй, гэнэтийн шалгалт хийх, эрүүдэн шүүхтэй холбоотой өргөдөл гомдлыг авч үзэх, хохирогчдод нөхөн олговор олгосон эсэх, нөхөн сэргээлтэд хамруулсан эсэхийг шалгах зэрэг эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст олгох шаардлагатай байна." гэсэн бол НҮБ-ын Эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай илтгэгч Манфред Новак 2005 оны 6 дугаар сард Монгол Улсад ажилласны дараа өгсөн зөвлөмждөө "n) Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон баталж, хараат бус хяналт шинжилгээний механизмыг бүрдүүлж, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс байдаг улсын хэмжээнд байгаа бүх газруудад очиж үзэж байх. Тусгай илтгэгчийн үзэж байгаагаар энэ механизм нь Хүний эрхийн Үндэсний Комиссын хүрээнд байж болох юм"<sup>39</sup> гэжээ. Мөн 2011 оны 3 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжид "Оролцогч улс цагдан хорих байранд хяналт тавих бие даасан механизм байгуулах шаардлагатай байна..." гэсэн болно<sup>40</sup>.

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг хороо болон Тусгай илтгэгчээс өгсөн зөвлөмжийг бодитой хэрэгжүүлэх ажлыг

<sup>39</sup> Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн эмхэтгэл 2-р боть. 2012 он. 525-р тал

<sup>40</sup> Мөн тэнд.



зохион байгуулах нь цаг үеийн тулгамдсан асуудал болоод байна. Мөн Засгийн газрын 2011 оны 159 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөнд Нэмэлт Протоколыг соёрхон батлуулах, эрүүдэн шүүхийн эсрэг Тусгай илтгэгчээс өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах ажлыг 2011-2012

онд багтаан гүйцэтгэхийг Хууль зүй, дотоод хэргийн яам (одоогийн Хууль зүйн яам)-д үүрэг болгосныг энд дурдах нь зүйтэй юм.

Монгол Улс Нэмэлт протоколд нэгдэн орсноор хорих газруудад хүний эрх зөрчигдөж буй эсэхэд бие даасан, хараат бус шалгалт хийх албан ёсны тогтолцоо бүрдэх, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий харьцах, ял завших явдалтай тэмцэхэд чухал алхам болох юм.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРЧ БУЙ  
НИЙТЛЭГ АЛДАА, ХОЛБОГДОХ ЗӨВЛӨМЖ, ТУХАЙЛАН  
ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫГ  
САЙЖРУУЛАХ ТАЛААР ЗӨВЛӨХ НЬ**



Монголын Эмнести Интернэшнл  
байгууллагын гүйцэтгэх захирал

**Б.АЛТАНТУЯА**

**Нэг. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээний талаарх илтгэлд холбогдох үндсэн мэдээлэл**

Монгол Улс олон улсын олон талт 240 гаруй гэрээнд нэгдэн орсноос хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйтэй холбоотой 50 гаруй, НҮБ-ын Хүний эрхийн суурь найман гэрээний долоог нь соёрхон баталсан байна.

Түүнчлэн Монгол Улс олон улсын эрх зүйн дагуу гэмт хэрэгт тооцогдох хүний эрхийн зөрчлүүдэд ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс болгох чухал алхмыг хийсэн. Үүнд:

- 2002 оны 1 дүгээр сарын 24-нд Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийг соёрхон баталсан.
- 2002 оны 4 дүгээр сарын 11-нд төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах нэн тэргүүний

үүргийг хүлээсэн үндэсний шүүхтэй байх зорилгоор Ромын дүрмийг соёрхон баталсан.

- 2007 оны 2 дугаар сарын 6-нд Монгол Улс нь Хүчээр сураггүй алга болгохоос бүхий л хүмүүсийг хамгаалах тухай Олон улсын конвенцид гарын үсэг зурсан.

Үүнээс гадна Монгол Улс сүүлийн хэдэн жил эрчимтэйгээр Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Нэмэлт протокол, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нэмэлт протокол, Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт Протокол, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Нэмэлт 2 дугаар протокол буюу Цазаар авах ялыг бүрмөсөн халах тухай протоколыг соёрхон баталсан.

Монгол Улс сүүлийн 2 жилийн дотор нэгдэн орсон гэрээний хэрэгжилтийн талаар хэд хэдэн илтгэлийг Гэрээний хороодод

нөхөн өргөн мэдүүлсэн, Монгол Улсын нэгдэн орсон гэрээний хэрэгжилтийн талаар иргэдэд тайлагнах [www.humanrights.mn](http://www.humanrights.mn) цахим хуудсыг шинээр нээн, зарим нэг Гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийг орчуулан тавих, өргөн мэдүүлсэн илтгэлээ нийтэд хүртээх зорилгоор ажиллуулж байна.

### **Хоёр. Хэрэгжилтэнд гарч буй нийтлэг алдаа**

*А. Монгол Улс нь үндэсний хууль тогтоомжоо нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэх үүргээ хэрэгжүүлж чадахгүй байна.*

Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн конвенцоор хүлээсэн үүрэгтэй дотоодын хууль тогтоомж болон шинээр боловсруулж буй хуулийн төсөл хэрхэн нийцэж байгаа эсэхийг Засгийн газрын хэмжээнд ХЗДХЯ хянаж, УИХ-д Хууль зүйн байнгын хороо хянан хэлэлцэх зохицуулалттай ч Засгийн газрын хэмжээнд яам хоорондын хамтын ажиллагаа, уялдаа муу, УИХ-аас хяналт тавих үүргээ хэрэгжүүлдэггүйгээс<sup>41</sup> Монгол Улс НҮБ-ын гэрээний хорооноос конвенцийн агуулгыг хууль тогтоомжинд тусгаагүй гэдэг шүүмжлэлд өртдөг.

Тухайлбал, НҮБ-ын эрүү шүүлтийн Тусгай Илтгэгч “Монгол Улс нь эрүү шүүлтийг Эрүүдэн шүүхийн эсрэг олон улсын Конвенцид нийцүүлэн тодорхойлоогүй”<sup>42</sup> гэжээ. Эрүүгийн хуулийн 44.1-т “Заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй” гэжээ. Энэ нь хууль сахиулагчдыг хүний амьд явах эрхийн эсрэг,

<sup>41</sup> Х.Тэмүүжин, Парламентийн хяналт, Нээлтэй нийгэм хүрээлэн дээр тавьсан илтгэлийн үеэрх хэлэлцүүлгээс

<sup>42</sup> НҮБ-ын Хүний эрхийн Комисс, Эрүүдэн шүүхийн Асуудлаарх Тусгай Илтгэгч, Монгол дахь айлчлал, E/CN.4/2006/6/Add.4, 2005 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, 16-р бүлэг.

эрүү шүүлтийн гэмт хэрэг үйлдсэний төлөө ял шийтгэлгүй үлдэх боломжийг бүрдүүлж байна.

Мөн Арьс үндсээр алагчлах явдлыг устгах талаарх Хорооны<sup>43</sup> хамгийн сүүлийн үеийн ажиглалтын тэмдэглэлд “Монгол улсын үндэсний хууль тогтоомжинд арьс үндсээр ялгаварлан гадуурхах тухай тодорхой тодорхойлолт байхгүй” гэсэн байна. Түүнчлэн бэлгийн чиг хандлага, хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох тухай зохицуулалт хууль тогтоомж, Үндсэн хуульд нь ч байхгүй гэж үзсэн байна. Түүнчлэн Монгол Улс нь Олон Улсын Эрүүгийн Шүүх байгуулахыг хүчтэйгээр дэмжсэн төдийгүй Ромын Дүрмийг хамгийн түрүүнд соёрхон баталсан 60 улсын эгнээнд багтсан ч, гэрээний үүргээ биелүүлэх зорилгоор Олон улсын эрүүгийн шүүхтэй бүрэн хэмжээгээр хамтран ажиллах, төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг үйлдэгчдийг эрэн сурвалжлах, мөрдөн мөшгөх, шүүхийн өмнө хариуцлага ногдуулах талаарх хууль батлаагүй байна.

*Б. Хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлыг шуурхай, хараат бус, үр дүнтэй мөрдөн шалгах, шударга шүүхээр хариуцлага тооцон, ял шийтгэлгүй өнгөрөөхийн эсрэг хамгаалалт тогтоогоогүй байна.*

Монгол Улс ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэс болгох зорилготой гол гэрээнүүдийг соёрхон батлан үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэхдээ гэрээний заалтыг бүрэн тусгахгүй тунхаглал шинжтэй болгох өмнөх алдаанаас гадна хэрэгжүүлэх механизмын чиг үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой тусгахгүй байх нь нийтлэг байна.

Төрийн байгууллагын алба хаагчдад

<sup>43</sup> Арьс үндсээр ялгаварлан гадуурхах хорооны ажиглалтын дүгнэлт, 2006 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, CERT/C/MNG/CO18, 12-р бүлэг

зориулсан хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөр байхгүй, нэгдэн орсон гэрээ хэлэлцээрээ таниулах, хэрэглэх талаарх сургалтыг системтэйгээр явуулдаггүйгээс албан тушаалтнаас захиргаадалтын шинжтэй шийдвэр гаргах, эсхүл илүүц хязгаарлалт тавин албадлага хэрэглэх харилцаа ноёлсон байна. Мөн түүнчлэн шүүх дээр олон улсын гэрээг хэрэглэсэн практик байхгүй, хэрэглэх боломж бүрэн байсаар байхад албан орчуулга байхгүй, яаж хэрэглэх талаар заавар байхгүй гэх аар саар шалтгаан тоочих хандлага хууль, шүүхийн байгууллагын ажилтны дунд түгээмэл байна.

2007 оноос хойш эрүүдэн шүүж, зүй бус харьцсантай холбоотой 744 хэргээс ганц л хүн ял эдэлж бусад нь ял шийтгүүлээгүй үлдсэн байгаа нь хууль зөрчигчдөд ял завших боломж олгож байна гэж Эрүүдэн шүүхийн Тусгай Илтгэгч үзсэн байна.

Иргэний нийгмийн байгууллагуудаас Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрх, эрх чөлөөний асуудал Үндсэн хуулийн цэцийн авч үзэх маргааны хүрээнд ороогүй тул үндсэн хуулийн эрхээ зөрчигдлөө гэж үзсэн иргэн Үндсэн хуулийн цэцэд хандах боломжгүй байна гэж үзсэн байна.<sup>44</sup>

*В. Гэрээний тайлангуудыг цаг хугацаанд нь илгээх, илтгэлийг бэлтгэхдээ иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах, конвенцийн хороодын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хангалтгүй хандаж байна.*

Хороонд өргөн мэдүүлсэн илтгэл нь Гэрээний тайлан бичих стандарт загварт нийцээгүй, хуулинд оруулсан өөрчлөлт болон хийсэн ажлаа тоочих замаар бичих алдааг нийтлэг гаргаж байна. Үүний улмаас Хорооноос үр дүнтэй зөвлөмж гарахгүй байх, гарсан зөвлөмжид оролцогч улс ач

холбогдол өгөн хэрэгжүүлэхгүй байх явдал гарахыг үгүйсгэхгүй.

Монгол Улс зөвхөн өнгөрсөн оноос эхлэн гэрээний хорооны зөвлөмжид ач холбогдол өгч түүнийг хэрэгжүүлэх ажлыг баталсан байна. Гэвч холбогдох яамдын хариуцсан мэргэжилтний олон улсын эрх зүйн талаарх болон конвенцид туссан эрхийн агуулгын талаарх мэдлэг дутмагаас шалтгаалж, илтгэл бичихдээ ач холбогдол өгөхгүй байх, иргэний нийгмийн оролцоог хязгаарлах, нэр төдий оруулах дутагдал ихээр гаргаж байна.

Мөн түүнчлэн нэгдэн орсон гэрээний Хороотой хамтран ажиллах талаар ч учир дутагдалтай ажиллаж байна. Тухайлбал, Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай Илтгэгчийг Монгол улсад айлчлах үеэр цаазаар авах ялтай хоригдлуудын нөхцөл байдалтай танилцах зөвшөөрөл олгоогүйгээс гадна өгсөн зөвлөмжийн дагуу ямар арга хэмжээ авснаа засгийн газар мэдээлээгүй гэсэн шүүмж байдаг.<sup>45</sup>

Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт Монголын Төрийн бус байгууллагуудаас хүргүүлсэн илтгэлд дурдахдаа “аливаа шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх тодорхой механизмыг аль ч хуульд суулгаагүй тул энэ эрх хэрэгждэггүй гэх зэрэг нийтлэг алдаанууд байна.

*Г. Нэгдэн орсон Конвенц, бодлогын баримт бичгүүдийг мэдээлэх, сурталчилах, авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ тайлагнах ажиллагаа дутагдаж байна.*

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын талаарх үндэсний илтгэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

<sup>44</sup> Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт Монголын төрийн бус байгууллагуудаас өргөн барьсан нэгдсэн илтгэл

<sup>45</sup> Ээлжит нэгдсэн хэлэлцүүлэгт Монголын төрийн бус байгууллагуудаас өргөн барьсан нэгдсэн илтгэл

эрхийн тухай конвенц, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 29, 105, 138, 111, 182 дүгээр конвенцийн хэрэгжилтийн талаарх ээлжит тайлан бэлтгэх төлөвлөгөө гаргаснаас харахад хүргүүлсэн илтгэлийг яамны цахим хуудсанд байрлуулах, нийгмийн түнш байгууллагуудаас санал авах, үүргийг төлөвлөгөөндөө тусгадаг болсон байна.<sup>46</sup> Гэвч хэрэгжилтийн түвшин бодит байдал дээр хэт доогуур буюу бараг хэрэгжээгүйг Хүний эрхийн Үндэсний Комисс гэрээний хэрэгжилтийн байдлыг тайлагнахдаа дурдсан байна.

Хуульчдад зориулсан сургалт тогтмолжоогүй, өргөн хүрээг хамарч чадахгүй байх, төрийн байгууллагаас явуулж олон улсын эрх зүйн талаарх сургалтууд нь уялдаа холбоогүй, гарын авлага, ном, товхимол хүртээмж муутай байна.

*Д. Хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих механизм, үнэлэх шалгуур үзүүлэлт, байхгүй.*

Олон улсын гэрээний тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Засгийн газрын 2009 оны 362 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нэгдэн орсон гэрээний хэрэгжилтийн тухай үндэсний илтгэл бичих журам, Үндэсний илтгэл хариуцан боловсруулах байгууллагын жагсаалт зэрэг баримт бичгүүдэд гэрээ, конвенцийн хэрэгжилт, түүнд хяналт тавих зохицуулалтыг тус бүр тусгасан байна.

Гэвч Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн бүрэлдхүүн, төлөөлөл, сонголт, томилолтыг хэрэгжүүлэх хуулийг Парисын зарчимд бүрэн утгаар нийцүүлээгүйтэй холбоотойгоор гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих чадавх, хараат бус байдлын асуудал хөндөгддөгөөс нэгдэн орсон гэрээ

<sup>46</sup> НХХЯ-ны 2011 онд олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэлийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх ажлын төлөвлөгөө

бүрийн хэрэгжилтэнд өргөн утгаар, байнгын бүрэн цогц хяналтыг тавьж чадахгүй байна.

### **Гурав. Холбогдох зөвлөмж**

Монгол Улс хүний эрхийг дээдлэх улс төрийн хүсэл зоригоо батлахын тулд нэгэнт нэгдэн орсон гэрээндээ үнэнч байх буюу олон улсын гэрээний уламжлалт зарчим болох “гэрээ зохих ёсоор биелэх ёстой” гэсний дагуу гэрээний үүргээ шударгаар биелүүлэх, хэрэгжилтэнд тогтмол хяналт тавих, дүн шинжилгээ хийх, дутагдлыг засах, тодорхой хэмжээгээр ахиц дэвшил гарган ажиллах ёстой.

Дээр дурдсан нийтлэг алдааг засах, хэрэгжилтийг сайжруулах тал дээр дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд:

- Конвенци, гэрээний хэрэгжилтэнд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт бий болгох, хяналт тавих аргачлалыг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтны ажилд нэвтрүүлэх, тайланг батлагдсан журмын дагуу тавих;
- Хэрэгжилтийг хариуцах, хянах байгууллага, албан тушаалтны үүргийг тодорхой болгох;
- Гэрээ конвенцийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болгох;
- Гэрээний үзэл санааг сурталчилах, орчуулгыг хүртээмжтэйгээр тараах, танилцуулах арга хэмжээг өргөнөөр зохион байгуулах, хуулийн уялдаат цогц шинэчлэлийг хийх;
- Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар гаргасан Хөтөлбөрүүд хэрэгжих эдийн засгийн хангалттай боломжийг бүрдүүлэх, холбогдох гэрээ конвенцийн хорооноос гаргасан зөвлөмжийг биелүүлэх тал дээр анхаарч ажиллах;
- Иргэний нийгмийн байгууллагын хөгжил, чадавхид анхаарч хөрөнгө оруулалт хийх,




Хороонд тавих илтгэлийн хэлэлцүүлэгт бодитой ороолцох боломжоор хангах, Гэрээ, конвенцийг сурталчилах, таниулахад тэдний нөөц бололцоог дайчлах;

- Шүүх эрх мэдлийн салбарт ажиллагсад хүний эрхийн боловсрол, эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх, тэдний олон улсын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг тогтолцооны хүрээнд авч үзэх, мөн хараат бусаар ажиллах тогтолцоо бий болгох;

Дээрх зөвлөмж өөр хоорондоо харилцан уялдаатай, тогтолцооны хувьд цогц байдлаар хэрэгжүүлэх, хүн хүч, хөрөнгийн нөөц, цаг хугацаа шаардах хэдий ч хамгийн гол нь олон улсын хүний эрхийн гэрээний хэрэгжилтэнд хандаж буй өнөөгийн хандлагыг өөрчлөхгүйгээр дорвитой үр дүнд хурдан гаргаж чадахгүй юм.

**Дөрөв. Тухайлан Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэх шалгуурыг сайжруулах талаар зөвлөх нь**



*Гэрээний хэрэгжилтийг зөв үнэлэх нь цаашид авах арга хэмжээг зөв тодорхойлоход чухал хувь нэмэр оруулж, түүнд оруулах хүний болон материалын нөөцийг зөв хуваарилах, ингэснээр цаг алдахгүй хүний эрх, эрх чөлөөг нийтэд эдлүүлэх боломж бүрдүүлдэг онцгой*

*ач холбогдолтой юм. Тиймээс илтгэлийнхээ төгсгөл болгож Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн үндсэн гэрээний хэрэгжилтийг үнэлсэн шалгуурыг<sup>47</sup> шинэчлэн хэрэглэх талаарх зөвлөмжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор жишээлэн хүргэе.*

*1. Хэм хэмжээ шүтэж сонгосон оновчгүй шалгуур*

Үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээг харьцуулан судалснаар зөвхөн үндэсний хууль тогтоомжоор, конвенцоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй, эрх зүйн хамгааллыг нь бууруулаагүй эсэхийг л тодорхойлно. Гэтэл гол шалгуураа үндэсний хууль тогтоомж конвенцийн заалттай нийцэж байгаа эсэхээр сонгосон нь хэдийгээр өнөөгийн тулгамдаж буй асуудал мөн боловч харамсалтай нь хэрэгжилтийг үнэлэхэд төдийлөн ач холбогдолгүй, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэх гол зорилгыг огт хангахааргүй шалгуур юм.

Монгол Улсын хууль тогтоомжид Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэг ч заалтыг тусгаагүй байсан ч гэсэн манай улс нэгэнт тус конвенцид нэгдэн орсон тул дотоодын хууль тогтоомжийн адил үйлчлэх учиртай.<sup>48</sup> Тиймээс, одоогийн шалгуур зарчмын хувьд үр дүн багатай байна.

Мөн хуулийн 16 дугаар зүйлийн 14-р заалтын дагуу: “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” байдаг. Тиймээс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хэм

<sup>47</sup> Монгол Улс МХЗ-ын 9 дэх зорилт буюу хүний эрх, эрх чөлөөний байдлыг үнэлэхдээ тогтоон хэрэглэсэн шалгуур

<sup>48</sup> Монгол Улсын Үндсэн Хуулийн 10 дугаар зүйлийн 3-т: “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байдаг.

хэмжээний талаас үнэлэх гэсэн оролдлого арга зүйн хувьд туйлын оновчгүй сонголт байжээ. Өмнөх шалгуурын зорилго зөвхөн Монгол Улсын Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэм хэмжээтэй хэр нийцэж байгаа эсэхийг тодруулахад оршиж байжээ. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлт боловсруулахдаа Конвенцийн үндсэн зорилго, агуулгыг бүрэн тусгаагүй байна. Конвенцийн хэрэгжилтийг үнэлэхэд:

- 1/ Эрх зүйн хамгаалалтаар хангах,
- 2/ Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх,
- 3/ Хохирлыг арилгах,
- 4/ Олон улсын хэмжээнд хамтран ажиллах талаар гэсэн 4 асуудалд анхаарвал зохино.

Гэтэл өгүүлэн буй шалгуурт Конвенцийн 1, 2, 3, 13, 14, 15 дугаар заалтыг сонгож үнэлгээ хийсэн нь Конвенцийн урьдчилан сэргийлэх, олон улсын хэмжээнд хамтран ажиллах зэрэг үүргийг нь орхигдуулсан байна. Даяарчлагдаж буй өнөө үед шүүн таслах харьяаллын асуудлыг тодорхойлох шаардлага тулгарч болзошгүй эрсдэлтэй энэ үед хууль сахиулах төдийгүй, манай дипломат ажилтнуудын тус конвенцийн талаарх мэдлэг, ялангуяа олон улсын хэмжээнд хамтран ажиллах тухай заалтын ойлгоцыг хэмжих жишээ болоод байна.

Конвенцийн заалтыг нэн тэргүүний, хэмжиж болохуйц гэх мэт шалгуураар сонгох нь буруу. Угаас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүний хэм хэмжээ нэг мөр бүрэн хэрэгжиж байх ёстой учраас Конвенцийн заалтыг хэсэгчилэн, түүвэрлэн авах ёсгүй бөгөөд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалт бүр бүрэн хэрэгжих ёстой. Өмнөх асуулга дахь Конвенцийн заалтын сонголт нь зарим заалтыг хэрэглэхгүй, хойш тавьж болно гэсэн ойлголт хандлагыг бий болгох сөрөг талтай юм.

## 2. Практик хэрэгжилтийг үнэлэх боломжгүй

Өмнөх шалгуур үзүүлэлт нь практик судалгаа муутайгаас бодит хэрэгжилтийн түвшинг үнэлж чадаагүй байна. Тухайлбал, шүүхийн практик ямар байгааг, мөрдөн байцаалтын практикийн алдаа юунд байгааг судлаагүйгээр үл барам наад зах нь, хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдын хэдэн хувь нь энэ конвенцийн талаарх сургалтанд хамрагдаж, мэдлэг, мэдээлэлтэй байгааг ч тодруулах боломжгүй байна.

Өмнөх шалгуураар Конвенцийн агуулга Эрүүгийн хууль болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд туссанаар нь 1-5 хүртэл оноогоор үнэлж, хэрэгжилт нь 3, 4 хувь нийцэж байна гэж дүгнэжээ. Харамсалтай нь энэ үнэлгээ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц хэрэгжиж байна, хэрэгжилт нь 3, 4 хувьтай байна гэсэн үг хараахан биш билээ, зөвхөн конвенцийн болон үндэсний хууль тогтоомжийн сонгож авсан хэм хэмжээнүүдийн санамсаргүй давхцлын коэффициент төдий болж орхижээ.

Харин бодит байдлыг зарим эх сурвалж жишээ татан өөрөөр тодорхойлж байна. НҮБ-ын тусгай илтгэгч болон Төрийн бус байгууллагуудын гаргасан тайлан, судалгаа Монгол Улс дахь эрүү шүүлтгийн байдлыг нааштай үнэлээгүй юм. Тухайлбал, зөвхөн 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр гарсан үймээнтэй холбоотой асуудлаар:

*“Дэнжийн мянга ойролцоогоор 150 хүнийг хүлээн авах багтаамжтай. 7 дугаар сарын 1-ний өдрийн үймээний дараа Дэнжийн мянгад ойролцоогоор 400 гаруй хүнийг саатуулж байжээ...”<sup>49</sup> гэж,*

мөн түүнчлэн,

<sup>49</sup> Би эндээс хаачих вэ: 2008 оны 7 дугаар сарын 1-ний Монголд болсон үйл явдлын сургаж,

“Хүний эрхийн Үндэсний Комиссоос 7 дугаар сарын 1-ны өдрөөс хойш баривчлагдсан 1000 хүнд хийсэн судалгаагаар тэдний 88 нь баривчлагдаж мөрдөн байцаагдаж байхдаа зодуулж, дарамтлуулсан гэж хариулжээ”<sup>50</sup> гэж тус тус дурдсан байна.

Эдгээр бол зөвхөн хэм хэмжээний нийцлээр бодит байдлыг үнэлэх боломжгүй гэдгийн жишээ юм. Тиймээс өмнөх шалгуур асуулга Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэх зорилгыг хангаж чадахгүй байна.

### Дүгнэлт, зөвлөмж, санал

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг үнэлэхэд үндэсний болон олон улсын гэрээний хэм хэмжээ нийцэж байгаа эсэх талаар санал асуулгын дүнг гаргахаас илүү Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт дээр мониторинг хийх нь илүү үр дүнтэй байх болно.

Аливаа бодлогын хэрэгжилт тавьсан зорилгодоо хүрч байгаа эсэхийг үнэлгээний судалгаа (*assessment studies*)-н дээр тулгуурлан тогтоодог. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг ч мөн ийм судалгааны аргачлалаар нарийвчлан судалвал, илүү бодитой үнэлгээ гарах нь дамжиггүй.

Арга зүйн үүднээс, конвенц хэрэгжихэд хоёр үндсэн асуудлыг тодорхойлох ёстой. **Нэгдүгээрт**, хууль сахиулах байгууллагын ажилтнууд уг конвенцийг мэддэг, хэрэглэдэг эсэх, **Хоёрдугаарт**, мэддэг, хэрэглэдэг бол зүйл заалтыг нь зөв ойлгосон байдаг эсэх зэрэг болно. Энэ хоёр асуудлыг тодорхойлсноор конвенцийг хэр мэдээд, хэр зөв хэрэгжүүлж байгаа талаар өнөөгийн байдлыг тодорхойлж, баримжаалж болно.

<sup>50</sup> ХЭҮК-ийн илтгэл

Нэгдүгээр асуудлыг шийдэхэд арга зүйн талаас социологийн судалгаа илүү үр дүнтэй. Энэ Конвенцийг хэрэгжүүлэх, мөрдөх ёстой үндсэн хүрээ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хилийн төлөөлөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажилтан, прокурор, шүүгч, өмгөөлөгч нар байх нь дамжиггүй.

Хүний когнитив үйлдлийн зарчмыг баримжаалан асуултын тухайд information-evaluation-action гэдгээр респондентоос Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалт бүрийн хүрээнд:

- **нэгд**, тэдгээр заалт бүрийн тухай сонсож мэдсэн эсэхийг,
- **хоёрт**, энэ респондентын туршлагаас үзэхэд энэ заалттай холбоотой асуудал хэр түгээмэл гардаг болохыг,
- **гуравт**, тэдгээр асуудлаас шүүхээр буюу байцаан шийтгэх ажиллагааны журмаар хэд нь шийдэгдэж байсныг лавлан асуувал хэрэгжилтийг үнэлэх тоон баримжаатай болно.

Үүн дээр хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хариултыг өмгөөлөгч, шүүгч нарын хариулттай корреляц хийх замаар яллах, өмгөөлөх талуудын ойлголтын ялгааг ч тодорхойлох боломж бүрдэнэ.

Хоёрдугаар зорилгыг буюу хэр зөв ойлголттой байгааг тоон судалгааны аргаар илрүүлэн гаргах боломжгүй, харин чанарын судалгаагаар илрүүлэх нь оновчтой. Үүнд, арга зүйн хувьд хамгийн тохиромжтой нь тохиол судлалын арга гэж үзнэ. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалт тус бүрийг хэрхэн зөв ойлгож байгааг илрүүлэхийн тулд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн дөрвөн агуулгын хүрээнд холбогдох заалтуудаар өмгөөлөх, хууль сахиулах, шүүхийн хүрээнд хэрхэн ойлгож байгааг үнэлэх судалгаа хийлгэж болно. Ингэхдээ, судлаач тэр зүйлтэй холбоотой шүүхээр шийдсэн хэргийг сонгон олж, хэргийн материалыг судлан,

хэргийг шийдэх үед яллах, өмгөөлөх талын оролцогчид конвенц, конвенцтой холбоотой асуудлыг хэрхэн ойлгож, тайлбарлаж байсан, тэр тайлбар нь конвенцийн тайлбартай хэр нийцтэй байсныг харьцуулан тодорхойлох үүрэгтэй байх, ингэхдээ тухайн сонгож авсан хэрэг нь конвенцийн хэрэгжилтийн талаар илтгэх хугацааны хүрээнд байвал зохино.

Тиймээс конвенцийг ойлгосон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хүрээг тоон судалгаа, анкетийн аргаар, харин конвенцийг зөв ойлгосон эсэхийг сонгож авсан зургаан зүйлийн дагуу шинжээчийн үйлдсэн чанарын судалгаагаар дамжуулан конвенцийн хэрэгжилтийг Хавсралт №1-д заасан хүснэгтээр үнэлж болно гэж үзлээ.

### 3. Хүрэх үр дүн

Конвенцийг хэрэгжүүлэх үүрэгтэй субъектүүд түүний утга санааг мэддэг, хэрэглэдэг эсэх, мэддэг, хэрэглэдэг бол хэр зөв ойлгож хэрэглэдгийг тодруулснаар конвенцийн хэрэгжилтийн үнэлгээ харьцангуй бодитой гарна. Социологийн болон тохиол судлалын аргыг хэрэглэснээр үнэлгээг чанарын ч, тоон ч талаас нь харьцуулан гаргах боломжтой болохоороо давуу талтай бөгөөд зөвхөн хэм хэмжээний хүрээнд биш, харин шүүх, мөрдөн байцаах, хорих практикийг хамруулан өргөн хүрээнд үнэлэх боломж олгож байгаа юм.

Ингэснээр өмнөх шалгуурын дутагдалтай талыг даван гарч:

- Хэм хэмжээ шүтсэн биш, харин практик хэрэгжилтийг үнэлэх зорилгодоо илүү нийцнэ,
- Социологийн судалгааны асуулгыг оновчтой тодорхойлсноор конвенцийн цөөн хэдэн заалтаас илүү конвенцийн талаарх мэдлэгийг бүхэлд нь тоймлох боломжтой болно,
- Практик хэрэгжилтийн түвшинг тоон болон чанарын хувьд тогтоох боломж бүрдэнэ.

Ийм судалгаа хийж, үнэлгээ гаргаснаар, наад зах нь, конвенцийн заалтыг огт мэдэхгүй алдаа гаргаад байна уу, эсвэл мэдсэн мөртөө ойлгохгүй алдаа гаргаад байна уу гэдгийг тодорхойлох боломжтой юм. Конвенцийн хэрэгжилтийг шалгах зорилго бол юу нь болоод, юу нь болохгүй байгааг илрүүлэх явдалд оршино. Цаашилбал, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахын тулд юу хийх вэ гэдэг тодорхой болно. Хууль сахиулах байгууллагын болоод холбогдох албан тушаалтан, алба хаагч нар конвенцийн тухай мэдлэггүйгээсээ алдаж байгаа бол сургах, сурталчлах арга хэмжээ түлхүү авч хэрэгжүүлэх ёстой юм. Харин сонссон мөртөө буруу ойлгоод байгаа бол конвенцийг тайлбарлах, гүнзгийрүүлсэн сургалт явуулах хэрэгтэй нь магад билээ.

ОИ.МН  
СУДАЛГААНЫ САН

**ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ  
БУСААР НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН  
ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ АСУУЛГА**

Сайжруулсан хүснэгт: Энэ хүснэгтийн нүд бүрийг социологийн болон чанарын судалгаа хийхдээ харгалзан үнэлнэ.

	Конвенцийн заалт	Конвенцийг хэр ойлгож, хэрэглэж байна вэ? / Тоон судалгаагаар илрүүлнэ/				Чанарын судалгаагаар илрүүлнэ	Эцсийн үнэлгээ
		Тухайн заалтыг мэддэг эсэх	Тухайн заалттай холбоотой гомдол, маргаан гарч байсан эсэх	Хэрэг, маргаан шүүхээр шийдвэрлэгдсэн байдал	Өмгөөлөх, яллах талын ойлголтын зөрүү		
Эрх зүйн хамгаалалтаар хангах							
Урьдчилан сэргийлэх							
Хохирлыг арилгах							
Олон улсын хамтын ажиллагаа							





## ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ



Хууль Зүйн Яамны Хууль сахиулах  
бодлогын хэрэгжилтийг зохицуулах  
хэлтсийн дарга

**Г.ОЮУНБОЛД**

Нийгмийн хөгжлийн олон үе шатуудад хууль зүйн салбар тэр дундаа хууль сахиулах үйл ажиллагаа эрх зүйн нэгдсэн зохицуулалтгүй явж ирснийг бид мэдэх билээ. Үндсэндээ эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эсхүл захиргааны зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн ойлголт эрүүгийн процессын эрх зүй болон захиргааны процессын эрх зүйд хамаарч, үндсэн хуульд заасан иргэний эрхийг хамгаалах, хүний халдашгүй эрхийг хязгаарлах, үндэслэл бүхий сэжгийг шалгаж, төрийн нэрийн өмнөөс хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх ажиллагаа олон салбарын хууль тогтоомжид өөр өөрөөр тусч ирсэн.

2001 онд Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдаж эрүүдэн шүүлт байгаа эсэх талаар олон улсын шинжээч Манфред Новакийн хийсэн судалгаагаар эрүү шүүлтийн хэлбэрээс гадна гэм буруу нь нотлогдоогүй, хугацаагүй хоригдож байгаа олон хүн байгааг илрүүлж, гэмт хэрэг хүлээлгэх арга болсон тухай иш баримттай дурджээ. Тухайн үеийн хууль

хяналтын байгууллагын зөвлөгөөн дээр энэ алдаа дутагдлын талаар хүчтэй шүүмжлэл явагдаж, урьдчилан хорих байр, хорих ангид тураалаар нас барсан хоригдлын тоо дунджаар жилдээ 120-д хүрч байсан нь бодит үнэн юм.<sup>51</sup> Хуулийн байгууллагын шинэчлэлд ийм амь бөхтэй арга барил, газар авсан хандлага өөрчлөгдөхгүй явсаар ирсэн хожим энэ үр дагаварт хүргэжээ.

Өөрөөр хэлбэл Монгол Улсад хууль сахиулах үйл ажиллагааны нэгдсэн стандарт, түүнийг тогтоосон эрх зүйн хэм хэмжээ байхгүйгээс эрүүгийн тагнуул, мөрдөн байцаах арга барилд тулгуурлаж үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагууд даруй 70 гаруй жил ажиллаж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн нэрээс аваад үзэхэд хууль сахиулагчдад ямар “стериотип” үүсгэж, хандлага төрүүлж байгаа нь тодорхой байна. Эрүүдэж, байцааж шийтгэх тухай хууль гэсэн нэртэй. Уг нь гэмт хэрэг хянан шийдвэрлэх

<sup>51</sup> А.Лхагваа, “Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй” 2011 он.

тухай хууль нь хууль сахиулах үйл ажиллагааны хуультай хослон олон оронд хэрэглэгдэж байна. Хуулийн нэр, зүйл заалт, үзэл баримтлалаас гадна тогтсон уламжлалт хандлагаас хууль сахиулах байгууллагын алба хаагчид ангижраагүй байгаа учраас хүн хэргээ хүлээсэн л бол шийдвэрлэхийг болно гэж үздэг үзэл байгаа талаар ярьж хэлж бичиж байгаа нь ийм түүхэн уламжлалтай юм.

Хууль сахиулах үйл ажиллагаа, гэмт хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанаас ялгаагүй учраас үндсэндээ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль болон татвар, гааль, мэргэжлийн хяналт, байгаль орчны багц хууль тогтоомжоор зохицуулж иржээ.

Эрх зүйн процессын хувьд Ром германы эрх зүйн тогтолцоотой орнуудад төр нь (“ардчилсан журмаар сонгогдсон хууль тогтоогчийн хувьд”) эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг тогтоох гол төв гэж үздэг. Төр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг удирдан чиглүүлдэг ба үүнийгээ шударга бөгөөд хараат бусаар хийнэ гэж найддаг байна. Харин нийтийн эрх зүйн тогтолцоотой газарт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийг хянан шийдвэрлэх төрийн чадавхид эргэлздэг бөгөөд ингэснээрээ маргалдагч талуудын хооронд хараат бус шүүгчид гол найдвар хүлээдэг байна.<sup>52</sup>

Ром германы эрх зүйн тогтолцоон дахь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны

дээрх ерөнхий зарчмаас үүдэн дор дурдсан тогтолцоо буй болжээ. Эх газрын эрүүгийн эрх зүйн бодит байдлыг судлаад үзэхэд төвд тэмүүлэх хүч үйлчилдэг, цагдаа, прокурор, шүүх эрх мэдлийн тогтолцоог төвлөрүүлэх замаар шийдвэр гаргах ажлыг хэрэгжүүлдэг, дээд шатны байгууллагаас доод шатандаа тушаасан хөшүүн систем салбар дотроо буй болгосон (тухайлбал шүүх эрх мэдлийн тогтолцоо дотроо) болон салбар хооронд (хууль тогтоогчоос шүүхийн эрх мэдэл шалтгаалах); тодорхой тогтоосон дүрэм, журам, албан ёсны баримт бичиг, тайланг илүү үзэх “эрүүгийн эрх зүйн ноён нурууг бүрдүүлсэн, дээд удирдлага хянахад шаардлагатай хавтаст хэрэгтэй байх”; албан тушаалтнууд түүний дотор шүүгчдийг сонгон шалгаруулах, сургах, албан тушаалд дэвшүүлэх тогтолцоогоор бэхжсэн хүнд сургалтын арга барил, сэтгэн бодох хязгаарлагдмал хэв маяг зэрэг болно.”<sup>53</sup>

Хууль зүйн салбарт эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл буюу “criminal justice reform” хийгдэж байгаатай холбогдуулан хууль тогтоомжийн төдийгүй дэд бүтцийн бодлогыг салбарын яамнаас шинээр тодорхойлж байна. Бидний мэдэх Эрүүгийн хууль тогтоомж гэсэн ойлголт нь илүү өргөн болж материаллаг болон процессын хуулиудыг бүхэлд хамарч, хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх, оролцогчдын аюулгүй байдлыг хангасан, шударга ёсыг тогтооход чиглэж буй.

Материаллаг хүрээ:		Процессын хүрээ:	
Гэмт хэргийн тухай хууль	Зөрчлийн тухай хууль	Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль	Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял шийтгэлийн төрөл, хэмжээг тогтооно.	Зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийн төрөл хэмжээг тогтооно.	Хууль сахиулах үйл ажиллагааны стандарт, баримтлах зарчим, үндэслэл, журам	Эрүүгийн хэргийг мөрдөх, шүүн таслах ажиллагаанд баримтлах зарчим, үндэслэл, журам

<sup>52</sup> Эрүүгийн эрх зүй дэх хүний эрх судалгааны илтгэл, Франц улс, Страсбург хот 2009 он, 8 дах тал, Швейцарийн хөгжилийн агентлагын санхүүгийн дэмжлэгтэйгээр Иргэдийн Альяанс Төв орчуулан бэлтгэлээ.

<sup>53</sup> [http://www.icac.nsw.gov.au/files/pdf/pub2\\_5q1.pdf](http://www.icac.nsw.gov.au/files/pdf/pub2_5q1.pdf)-ийг үзнэ үү.

Монгол Улсад хууль сахиулах чиг үүргийг олон салбарын мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг боловч өнөөг хүртэл төрөлжсөн хуульгүй явж ирлээ.

Хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг гэмт хэрэг болон зөрчлийг шалган шийдвэрлэх салбар эрх зүйн хүрээнд төдийгүй байгууллагын хэм хэмжээ тогтоосон салбарын хуулиудаар зохицуулж байгаа нь эрх зүйн хийдэл, цоорхой, давхардлыг бий болгож, улмаар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх Үндсэн хуулийн зохицуулалтыг гажуудуулах нөхцөл болж байна.

Иймд үндэслэл бүхий сэжиг, гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг ашиг сонирхлын зөрчил, авилгаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлэх шаардлагад үндэслэн Хууль сахиулах үйл ажиллагааны тухай бие даасан хуулийн төслийг боловсруулж байна.

Гэмт хэрэг илрүүлэх хойшлуулгүй ажиллагаа, иргэний өмч хөрөнгийг битүүмжлэх, хураан авах, нэгжих, үзлэг хийх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах буюу нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, гүйцэтгэх ажил, нийгмийн хэв журам сахиулах, нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанууд “хууль сахиулах үйл ажиллагаа” гэсэн ойлголтод багтаж хууль сахиулагчийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар тогтооно. Ингэснээр хүний халдашгүй эрхийг хязгаарлах, өмч хөрөнгөд халдах ажиллагаа нэг стандартаар хэрэгжих юм.

Гэмт хэргийг мөрдөх, зөрчлийг шалгах, нийгмийн хэв журам сахиулах,

аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй субъект болох ял эдлүүлэх, хил хамгаалах, онцгой байдал, харьяатын албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Монгол Улсын Хилийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай зэрэг тухайн салбарын хуулиар зохицуулж байгаа бөгөөд эдгээр алба хаагчдын эрх, үүрэг, ажиллах нөхцөл, баталгаа нь давхардсан, зохицуулалт нь хангалтгүй байна.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэргийг мөрдөн шалгах “мөрдөх алба”, шүүхийн шат дахь гэрч, хохирогч, шүүгчийн аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй “маршалын алба” зэрэг байгууллагууд шинээр байгуулагдах бөгөөд эдгээр албаны алба хаагчийн эрх зүйн байдлыг мөн нэгдсэн байдлаар зохицуулах, албан хаагчийн хариуцлага, ёс зүйн болон сахилгын дүрмийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах зарчмын шинэлэг зохицуулалт бий болгох, албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд дээрх хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж байна. Энэ хуулийн төслөөр хууль сахиулагч буюу цагдаа, мөрдөх, маршал, ял эдлүүлэх, хил хамгаалах, онцгой байдал, харьяатын албаны алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл, ажиллах баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулж, гааль, татвар, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь энэ

хуулийн үйлчлэлд хамаарах этгээд байхаар тусгана.

Ийнхүү хууль сахиулах үйл ажиллагаа нэг стандартад орсноор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд байдаг цагдан хорих, хөтөлж байцаах, нэр хүндийг нь гутаан доромжилж харьцах зэрэг эрүү шүүлтийн амь бөхтэй оршсоор байгаа хэлбэрүүдийг хязгаарлах боломжтой болж байгаа юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байгаа олон ажиллагаа, үндэслэл журмууд хууль

сахиулах ажиллагаанд хамаарч байгаатай холбоотойгоор Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулагдаж байна. Энэ хуулийн төсөлд хүнийг гэмт хэрэгт сэрдэж, баривчилсан үеэс эхлэн зөвшөөрөл олгох эрх бүхий шүүгч цагдан хорих, бусад эрхийг хязгаарлах бүхий л ажиллагааг хүний эрхийг хангаж байгаа эсэхийг харгалзаж, зөвшөөрөл олгодог байхаар тусгахаар боловсруулж байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ЭРҮҮ ШҮҮЛТИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ ТӨР ХАРИУЦАН АРИЛГАХ ҮҮРЭГТЭЙ



Хүний эрхийн Үндэсний  
Комиссын Ахлах референт

**Б.БАТАА**

### Эрүү шүүлтээс ангид байх эрх

*“...Хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно.”*

/Хүний эрхийн Түгээмэл  
Тунхаглалын 5 дугаар зүйл/

*“Хэнд ч эрүү шүүлт тулгахыг... хориглоно. Тухайлбал, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр хэн дээр ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийж болохгүй.”*

/Иргэний болон улс төрийн эрхийн  
тухай олон улсын пактын 7 дугаар зүйл/

**И**йнхүү хэнийг ч эрүүдэн шүүх, хэрцгий, Хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхгүй хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд заасныг харгалзан, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батласан Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр

төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалын дагуу 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц<sup>54</sup>” /цаашид эрүүдэн шүүхийн эсрэг конвенц гэх/-ийг батлан гаргасан байна.

Энэхүү Конвенцид Монгол Улс 2000 онд нэгдэн орсон бөгөөд ингэснээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийг таслан зогсоох, эрүү шүүлт тулгасан хэнд ч эрүүгийн хариуцлага тооцож байх үүргийг хүлээх болсон билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “... Хэнд боловч эрүү шүүлт тулгаж... болохгүй.” хэмээн эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулан тунхагласан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглосон заалтыг

<sup>54</sup> Монгол Улс 2000.11.02-нд нэгдэж орсон.



хуульчилсан бөгөөд сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглосон билээ.

Эрүү шүүлт нь төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдийн үйл ажиллагаа болон түүний өдөөн хатгалт буюу ил далд зөвшөөрлөөр үйлдэгддэг. Эрүү шүүлт тулгах гэмт үйлдлийг мэдүүлэг авах төдийгүй хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, мэдээ сэлт авах зорилгоор хийдэг.

Эрүү шүүлт тулгах магадлал бүхий субъект нь төрийн эрх бүхий албан тушаалтан байна. Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эрх чөлөө хязгаарлах ажиллагааны явцад албадлага хэрэглэх, эрхшээлдээ байлгах эрх бүхий төрийн тусгай албан тушаалтан байдаг. Жишээ нь: гэмт хэрэгтнийг илрүүлэх, эрэн сурвалжлах, нууц далд аргаар мэдээлэл цуглуулах чиг үүрэг бүхий гүйцэтгэх ажилтан, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх чиг үүрэг бүхий мөрдөн байцаагч, прокурор, саатуулах, баривчлах, цагдан хорих байрны ажилтан зэрэг байж болно.

Эрүү шүүлт тулгах гэдэг нь мэдээ сэлт, мэдүүлэг авах зорилгоор уг эх сурвалжийг мэдэх буюу гаргуулан авах этгээдийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг нэг удаа болон янз бүрийн давтамжтайгаар удаан хугацаанд санаатай хийгдэж байгаа үйлдлийг илэрхийлдэг. Ер нь эрүү шүүлт тулгах нь тодорхой зорилго, сэдэлттэйгээр тодорхой хугацаанд, бусдыг ялгаварлан гадуурхах үндэслэл бүхий, төлөвлөсөн үйлдэл, эс үйлдэхүйн бодит илрэл болж өгдөг. Эрүү шүүлт тулгах гэдэгт гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж байгаа бусад этгээд гэмт хэрэгт холбогдон шалгагдаж болон шүүгдэж байгаа хүнээс эсхүл, гэрч, хохирогч, шинжээч бусад хүнээс

хэргийн талаар мэдээлэл авах, хэргийг хүлээлгэх, өөрийнх нь хүсээгүй мэдээлэл, мэдүүлгийг гаргуулах, ял шийтгэхийн тулд сэтгэхүйн болон биеийн хүч хэрэглэх, айлгаж сүрдүүлэх, албадах, санаатайгаар хүчтэй өвтгөх буюу бие махбод, сэтгэл санааг тарчлаан зовоосон аливаа үйлдлийг ойлгоно. Өөрөөр хэлбэл эрүү шүүлт тулгагч нь хүнээс өөрийн хүссэн мэдээлэл, мэдүүлэг гаргуулахын тулд хүний биеийг зовоох (зодох, өвтгөх), хэл амаар зовоох (аашлах, загнах), сэтгэл зовоох (айлгах, шаналгах, сүрдүүлэх) гурван аргын аль нэгээр буюу нийлбэрээр илэрч болох онцлогтой.<sup>55</sup>

Эрүү шүүлтээс ангид байх эрх нь хүний жам ёсны эрх бөгөөд ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрх юм. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй” гэж, тус зүйлийн 3 дахь хэсэгт “Дээд шатны албан тушаалтны буюу төрийн эрх бүхий байгууллагаас авсан тушаал нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй” гэж тус хуульчилсан нь ямар ч үед хязгаарлагдахгүй байх баталгааг бий болгожээ.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоос гадна Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь болон бусад төрлийн олон баримт бичгүүдэд бусдыг эрүүдэн шүүх ажиллагааг шууд хориглосон заалтыг олноор оруулж баталсан байна. Үүний зэрэгцээгээр бүс нутгийн хүний эрхийн олон улсын гэрээ, баримт бичгүүдэд ч энэ асуудал мөн тусгалаа олсон байдаг.

<sup>55</sup> Хүний эрхийн товч тайлбар. 2012 он. 40 дахь тал

Америкийн Хүний эрхийн тухай конвенц (1969 он), Хүний болон улс төрийн эрхийн тухай Африкийн Харти (1981 он), Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (1950 он), Хүний эрхийн тухай Арабын конвенц (1994 он, одоогоор хүчин төгөлдөр болоогүй) зэрэг баримт бичгүүдэд эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцааг хориглосон байна.

Бие махбод, сэтгэл санааг хүчтэй өвтгөх, эсхүл тарчлаан зовоох үйлдлүүд нь эрүү шүүлтийн түгээмэл хэлбэрүүд юм. Эрүү шүүлт нь зөвхөн бие махбодыг өвтгөхөөр хязгаарлагдахгүй бөгөөд өвтгөх, зовоох үйл ажиллагаа нь нэг удаа бус олон давтагдсан, тарчлаах шинжтэй байхыг ойлгодог. Эдгээр үйл ажиллагааны гол шинж бол зориуд санаатай үйлдэгддэг болохоор болгоомжгүй өвтгөж, зовоосон үйлдэл нь эрүү шүүлтэд тооцогдохгүй.

**Эрүү шүүлт нь гэмт хэрэг мөн**

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улсууд эрүүдэн шүүх бүх үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу гэмт хэрэг хэмээн үзнэ.

Энэ нь эрүүдэн шүүхийг завдах, түүнд оролцох, хамтран оролцоход хамаарна.” гэж тус зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч улс бүр ийм гэмт хэрэг үйлдэгчид хэргийн нөхцөл байдлыг нь харгалзан зохих шийтгэл ноогдуулна.” гэж тус тус заасан байдаг. Тиймээс эрүү шүүлт тулгах үйлдлийг улс орнууд үндэсний хууль тогтоомжоороо гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байх үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээж байгаа юм.

2002 онд батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд Эрүү шүүлт тулгах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүү шүүлтээс ангид байх эрхийг эрүүгийн хууль тогтоомжоороо хамгаалсан байдаг. Түүнчлэн эрүү шүүлт тулгах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байсан төр, эрх зүйн түүхэн уламжлал бий.

Монгол Улс эрүү шүүлт тулгах гэмт явдалтай тэмцэж ирсэн түүхэн уламжлалтай хэдий ч өнөөг хүртэл эрүү шүүлт тулгах гэмт хэргийг тодорхойлохдоо Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн агуулгатай нийцүүлж, түүнээс дордуулахгүй байдлаар хуульчлаагүй байна.

*Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хуульчилж ирсэн түүхэн уламжлал*

Хууль	Бүлэг	Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хуульчилсан байдал
1926, 1929 оны “Шүүх цаазын бичиг”	21-р бүлэг “Аливаа албаны хүмүүс гэмт явдлаар явах” /12-р бүлэг “Шүүн таслах явдалд тэрслэх” хэсэгт хамааруулаагүй байна./	Аливаа албан тушаалтан зүй бусаар хэн хүнийг хорих ба хэрэгтэн хүнийг дарлан айлгаж, өлсгөх буюу эрүү шүүлтийг хэрэглэж, өчиг мэдүүлэг авах /153-р зүйл/
1934 оны “Шүүх цаазын бичиг”	Тусгай анги 2-р бүлэг “Захиргааны журмыг эсэргүүцэх онц аюултай гэмт хэрэг”	Хүний хууль бусаар баривчлах, мэдүүлэг өгөхийг албадах /99-р зүйл/
1942 оны “Эрүүгийн хууль”	4-р бүлэг “Албан тушаалын гэмт хэрэг”	Хүнийг хууль бусаар баривчлах, мэдүүлэг өгөхийг албадах /129-р зүйл/
1961 оны “Эрүүгийн хууль”	“Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бусад гэмт хэрэг”	Мэдүүлэг гаргуулахаар албадан хавчих /149-р зүйл/
1987 оны “Эрүүгийн хууль”	9-р бүлэг “Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг”	Мэдүүлэг өгөхийг албадах /207-р зүйл/

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Конвенцийн зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Энэхүү тодорхойлолт нь хуулийн дагуу авах шийтгэл, арга хэмжээ, түүнээс үүдэн буюу холбогдон үүсэх зовлон, шаналалд хамаарахгүй.” гэж заасан байх ба тус зүйлийн 2 дахь хэсэгт “Хэрэв олон улсын болон бусад дотоодын хуулинд уг ойлголтыг илүү өргөн утгаар хэрэглэдэг бол энэ зүйл нь тэдгээрт хохирол учруулахгүй.” гэж заасан нь оролцогч улс эрүү шүүлт тулгах гэмт хэргийг наад зах нь дээрх байдлаар хуульчлах үүргийг оролцогч улсад хүлээлгээд, үүнээс өргөн хүрээтэй тодорхойлохыг конвенцоор хязгаарлахгүй болохыг онцгойлон дурдсан байна.

Гэтэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлийн 251.1. дэх хэсэгт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан бол...” хэмээн эрүү шүүлт тулгах гэмт үйлдлийг тодорхойлжээ.

Конвенцийн агуулгыг, Монгол Улсын Эрүүгийн хуулийн агуулгатай харьцуулбал дараах зөрүүтэй байдал харагдаж байна.

Субъектийн харьцуулалт:

Монгол улсын эрүүгийн хууль	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц
Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч	Төрийн албан тушаалтан буюу албан үүргээ гүйцэтгэж буй этгээд, түүнчлэн тэдгээрийн өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр өөр хэн нэгэн этгээд

Объектив талын харьцуулалт:

Монгол улсын эрүүгийн хууль	Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц
Хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж мэдүүлэг өгөхийг албадан эрүү шүүлт тулгасан санаатай үйлдэл	Хэн нэгнээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт нь шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор тэдгээрийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоосон санаатай үйлдэл

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс болон Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанд ирж буй эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 60 гаруй хувь нь эрүүгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч, хорих ангийн төлөөлөгч, тагнуулын ажилтан зэрэг гүйцэтгэх ажилтантай холбоотой байдаг. Харин практикт хуулийн байгууллага тэдгээрийг шалгаад хэргийг эцэслэн шийдвэрлэхдээ эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект биш гэх үндэслэлээр өөр хөнгөн зүйл ангиар зүйлчлэх, эсхүл бүрэлдхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж байна.

Ийнхүү конвенцийн агуулгаас хэт хязгаарлагдмал байдлаар тодорхойлсон нь нэгдүгээрт: Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хоёрдугаарт: эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн этгээд

ял завшиж байна, гуравдугаарт: эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнгүй байна гэсэн шүүмжлэлийг дагуулаад байна. Тиймээс НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, НҮБ-ын Хүний эрхийн Хороо, НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс тус тус Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжүүдэд дээрх шүүмжлэлүүдийг дурдаж, хууль тогтоомжоо эрүүдэн шүүхийн эсрэг конвенцтой нийцүүлэхийг удаа дараа зөвлөсөн байдаг.

### Эрүү шүүлтийн улмаас учирсан хохирол

Монгол Улсын нэгдсэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй.”, гэж Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.” гэж тус тус заасан нь эрүү шүүлтийн улмаас учирсан хохирол, эрүүл мэнд, сэтгэл санааны нөхөн төлбөр авах эрхийг баталгаажуулсан байна.

НҮБ-аас батлан гаргасан “Гэмт хэргийн болон эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас хохирсон хүмүүсийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмууд”-ын 3.3.-т төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй байна. Тухайн хохирлыг хариуцах

засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна хэмээн заажээ.

Тиймээс олон улсын эрх зүйн зохицуулалтаар эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг шударгаар, хангалттай нөхөн төлөх үүргийг Монгол Улсын Засгийн газар хүлээж байна. Өөрөөр хэлбэл эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй. Гэтэл Монгол Улс эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Хэдийгээр тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй ч эрүү шүүлт тулгах нь гэмт хэрэг тул гэмт хэргийн улмаас учирсан хохирол гэдэг утгаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаагаар тогтоох, шийдвэрлэх боломж байна. Түүнчлэн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт хуульчилсан байдаг. Тиймээс эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлыг дээрх хоёр арга замаар нөхөн төлүүлж болох эрх зүйн зохицуулалт байна гэж үзэх үндэстэй боловч эрх зүйн зохицуулалт учир дутагдалтай байдлаас шалтгаалан эрүү шүүлтийн хохирогч өөрт учирсан хохирлоо бүрэн дүүрэн, бодитойгоор, шударгаар нөхөн төлүүлж чадахгүй байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. дэх хэсэгт “хохирогч гэж нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хэлнэ” гэж заасан. Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, бие эрхтний хохирол нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаарна. Энэ хохирлын хэмжээг

хэрхэн яаж тооцож, барагдуулах талаарх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсон хэвээр үлдэж байна.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардлын баримт, түүнчлэн аймаг, дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохирлыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.9 дэх хэсэгт заасны дагуу хохирогч нь гэмт хэргийн улмаас өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэхдээ шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийг зохицуулсан холбогдох зүйл, заалтыг хэрэглэхээр байна.

Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно.” гэж заасан ба эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогчийн шаардах эрхийг хуульчилсан. Эдийн бус хохирол нь материаллаг бус бүх хохирлыг багтааж

байдаг. Иргэний хуулийн тайлбарт дурдахдаа Бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна<sup>56</sup> гэжээ.

Гэхдээ Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө.” гэсэн нь хохирол барагдуулах үйл ажиллагааг явцууруулж байна. Үүнийг Улсын дээд шүүхийн 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 6.2.4-т тайлбарлахдаа “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-г эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй.” гэж заасан.

Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.” гэсэн ба үүнд дурдсан гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах зохицуулалт хийгдсэн байна. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.3. дахь хэсэгт “Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана.” гэж заасны дагуу мөнгөөр нэхэмжлэх боломжтой бусад тохиолдолд сэтгэл санааны хохирлыг

<sup>56</sup> Ё.Кают, Э.Шпанглер нар. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар 2010 он. 458-р тал



арилгуулах, нэхэмжлэх эрхгүй байна.

Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан тохиолдолд түүнийг оршуулахтай холбоотой зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт зааснаар тогтоож байна. Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3 дахь хэсэгт “Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй.” гэж заасан ч Дээд шүүхийн өмнөх тайлбарт дурдсанаар эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй хэвээр байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нотлогдоогүй хэсгийг барагдуулуулахаар иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг шүүхийн тогтоолд дурддаг боловч иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргахад санаа сэтгэл, бие эрхтний хохирлыг мөнгөөр үнэлэх аргачлал, эрх зүйн зохицуулалтгүйн улмаас хохирлоо нэхэмжлэх эрхгүй, нэхэмжилсэн хохирлоо бүрэн барагдуулж чадахгүйд хүрдэг.

Тиймээс эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын болон гадаад улс орны эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгахтай холбоотой харилцааг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлэгт зохицуулсан байгаа нь эрүү шүүлтийн зарим хэлбэрийг хамааруулан учирсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 388 дугаар зүйлийн 388.1. дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэтгэл санааны үр дагавраа арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших хийгээд бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй.” гэж заасан байна.

Тус зүйлийг Улсын дээд шүүхийн тайлбар<sup>57</sup>-аар энэ зүйлийн 388.1. дэх хэсэгт заасан “Хууль зөрчсөн ажиллагаа” гэдэгт мөн зүйлийн 389.2.-т заасан тохиолдлуудаас гадна байцаан шийтгэх ажиллагааны явцад эрүүдэн шүүгдэж, хэрцгий, хүнлэг бус харьцаанд өртөж, сэтгэл санаа, эрүүл мэнд, амь насаараа хохирсон явдлыг хамааруулж үзнэ. **“Эрүүдэн шүүгдсэн”** гэдэгт Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн 1-д заасан **“хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдэл”**-ийг ойлгоно хэмээн тодорхойлжээ.

Тиймээс тус заалтыг үндэслэн эрүү шүүлтийн хохирогч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр бүлгийг удирдлага болгон иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гарган, төрөөс хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байгаа юм.

<sup>57</sup> Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоол



Гэвч одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хувьд гэм хор, хохирол гэсэн ойлголтыг ялгаж зааглаагүй харилцан адилгүй байдлаар авч үзсэн, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирлыг хэрхэн яаж тооцох талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаагаас эрүү шүүлтийн улмаас учирсан хохирлоо хохирогч бодитойгоор барагдуулж авч чадахгүй байна. Гэм хор, хохирол нь хоорондоо ялгаатай ойлголтууд бөгөөд гэм хор нь аливаа этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүссэн сөрөг үр дагавар байдаг тул хохирлоос илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Өөрөөр хэлбэл учирсан хохирлоос үүдэн гарах бүхий л сөрөг үр дагаврыг гэм хор гэх ойлголтод хамааруулан ойлгоно. Жишээ нь: хохирогч нас барсан бол гэр бүлийнхэнд үүссэн шаналал зовлон, амьжиргааны доройтол зэрэг нь гэм хор болно.


Эдийн бус хохирлыг тогтоохдоо хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлохоор хууль тогтоогч хуульчилсан боловч Иргэний хуульд эдийн бус хохирол буюу сэтгэл

санааны хохирлыг тооцох аргачлал, журмыг хуульчлаагүй байгаа нь хууль хэрэглэх явцад ихээхэн хүндрэл, бэрхшээл үүсгэх үндсэн нөхцөл болж байна. Тиймээс иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг дан ганц шүүгч, шүүх бүрэлдхүүний дотоод итгэлээр эрх зүйн үндэслэлгүйгээр тогтоож байгаа нь бодит байдалд нийцэхгүй байгаа юм.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэж үзвэл Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тэр дундаа НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, үндэсний хууль тогтоомжоо олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нэн яаралтай нийцүүлэх шаардлагатай болжээ.

**СУДАЛГАА:**

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль батлагдсанаас хойш хилс хэрэгт холбогдсон, эрүү шүүлтэд өртсөний улмаас учирсан эдийн бус гэм хорыг арилгуулахаар 1'021'322'000 төгрөг нэхэмжилснээс шүүх 209'475'149 төгрөгийг буюу 21 орчим хувийг хангаж шийдвэрлэсэн байна.



**МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА****ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БОЛОН ҮНДЭСТЭН  
ДАМНАСАН КОМПАНИУД 2061 ОНД**

*“Хүний эрх нь бизнесүүдийн  
хийх ёстой ажил гэж бид боддог.”*

**НИКОЛА ЖАЙГЕРС**

*Тилбургийн их сургуулийн профессор бөгөөд Үндэстэн дамнасан корпораци зэрэг төрийн бус оролцогч ба хүний хүний эрхийн олон улсын хуулийн асуудлаар ажилладаг.*

**1. Танилцуулга**

**1** 984 оны 12-р сарын 2-ны шөнө дунд болохын өмнөхөн Энэтхэгийн Бопал дахь Юнион Карбайд корпорацийн шавжны хорны үйлдвэрээс 41 тонн метилийн изоцианид задарч, хүрээлэн буй орчинд нэвчсэн юм. Хайнга байдлаас үүдсэн энэ нэвчилт нь хагас сая орчим хүнийг үхлийн аюултай бодист хордуулснаар тэр даруйдаа 7,000-10,000 хүн, үүнээс хойш 20 жилийн турш 5,000 хүн амь насаа алдсан билээ. 100,000 гаруй хүний эрүүл мэнд хүнд байна. Гэтэл өнөөдөр ч тэрхүү хохирогчдын хохирол ямар нэг байдлаар барагдаагүй хэвээр. Юнион Карбайд корпораци, удирдагчид нь уг үйлдлийнхээ хариуцлагыг хүлээхээс татгалзсан бөгөөд хууль зүйн үйл ажиллагаанаас өнөөг хүртэл бултсаар.

Бопалын гамшиг нь хүний эрхэд харшилсан ажиллагаа явуулдаг компани, мөн үндэстэн дамнасан компаниудтай хариуцлага тооцоход ямар хэцүү байдгийн тод жишээ болсон. Хорин долоон жил өнгөрсөн ч, хохирогчид шударга ёс биелэлээ олохыг хүлээсээр л байна.

Эмнести Интернэшнл зэрэг төрийн бус байгууллагууд компаниудыг хүний эрхийн зөрчилд буруутгах нь хэвийн үзэгдэл мөн. Компаний хариуцлага нь Эмнести Интернэшнл “Хүнийг Хүндэл” кампанит

ажлынхаа хүрээнд анхаарлаа хандуулж буй гол асуудлуудын нэг. Компани гэх мэт хувийн хэвшлийн байгууллагуудыг үйл ажиллагааныхаа чиглэлд хамруулах тухай ойлголт нь харьцангуй сүүлд Төрийн бус байгууллагад бий болсон юм. Өмнө нь хүний эрхийг хамгаална гэхээр Засгийн газраас хувь хүнийг хамгаалах тухай ойлголт оршдог байсан. Харин өнөөдрийн даяарчлагдсан ертөнцөд хүний эрхийн байгууллагуудтай сөргөлдөж буй хамгийн хүчтэй тал нь төрийн оролцоогүй хуулийн этгээд болоод байна.

Сүүлийн гучин жилийн дотор Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага улс орнууд дахь компаниуд хоорондын сөргөлдөөн бүр олон улсын хэмжээнд хүртлээ даамжирчээ. Энэ нийтлэлээр хүний эрхийн хөдөлгөөнд Төрийн бус байгууллагууд, ялангуяа Эмнести Интернэшнл ямар нөлөөтэй оролцсоныг тайлбарлах болно.

Компаниудын арга барилд нөлөөлөх гэж оролдсон Төрийн бус байгууллагуудын хүчин чармайлт юунд хүрсэн, одоо ямар бэрхшээл тулгарч байгаа юм бол оо?

**2. Олон улсын хүний эрхийн хуулийн үндсэн үзэл санааг өөрчилсөн нь**

Дэлхийн хоёрдугаар дайны дараа хүний эрхийг дэлгэрүүлэх, хамгаалахад ихээхэн ач холбогдол өгч, олон улсын хууль гэдэг улс орнуудын хуулиндаа тусгах ёстой хэм

хэмжээ бий боллоо.

Гэвч хувийн хэвшил, төрийн оролцоогүй хуулийн этгээдүүдийн талаарх олон улсын хүний эрхийн хуулийн боловсруулалт нь даяарчлалын үйл явцтай зэрэгцэж явж чадаагүй юм. “Төрийн оролцоогүй байгууллага” гэдгээр Олон улсын валютын сан гэх мэт олон улсын санхүүгийн байгууллагаас эхлээд Аль Кайда гэх мэт террорист байгууллагуудыг ойлгоно. Олон хэлбэрийн төрийн оролцоогүй байгууллагаас үүдэн гарсан хүний эрхийн хор уршиг ч олон янз бөгөөд тэдгээрийг энд хэлэлцэж бүгдийг нь дурдана гэвэл маш их зүйл бичих хэрэгтэй. Тиймээс энэ нийтлэл нь зөвхөн даяарчлалын хамгийн том үр дагавар болон Үндэстэн дамнасан корпорациудыг голлон авч үзэх юм.

Одоогийн байдлаар дэлхийн даяар 80,000 орчим Үндэстэн дамнасан корпорац, тэдний салбарыг тоолбол энэ тоо арав дахин ихсэж, зөвхөн үндэсний хэмжээнд сая, сая хувийн компани ажиллаж байна. Эдийн засгийн өсөлтийн тулгуур хөдөлгүүр гэдэг утгаараа корпорациуд хүмүүсийн амьдралыг дээшлүүлдэг ч, үйл ажиллагаа нь хүмүүст сөргөөр нөлөөлөх нь бий. Эдгээр байгууллагууд хүний эрхийн зөрчилд оролцсон жишээ хангалттай. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хүний эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч судалгаа явуулж ямар нэгэн зүй тогтол, хэв маяг байгаа эсэхийг шалгасан юм. Төрийн бус байгууллагуудын тайланд тусгагдсан нийт 67 тохиолдлыг хамруулан шинжлэхэд нийт тохиолдлын ихэнх хувийг (2/3) олборлолтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай холбоотой гэсэн дүгнэлт гарчээ. Энэ салбарт ажилладаг компаниуд ерөнхийдөө хамгийн ноцтой зөрчил гаргадгийн заримыг нь хүн төрөлхтний эсрэг үйлдсэн гэмт хэрэг гэж үзэж ч болохоор аж. Мэдээж эдгээр үйлдлийг нь нийтийн болон хувийн харуул

хамгаалалтынхан гүйцэтгэсэн байна. Хүнс, согтууруулах ундааны үйлдвэр нь ус бохирдуулах болон хөдөлмөрлөх эрхийг зөрчсөн тохиолдлуудыг ихээр гаргасан байлаа. Хувцас хэрэглэлийн үйлдвэр нь мөн л хүний эрх зөрчсөнөөрөө Тусгай илтгэгчийн гаргасан жагсаалтын гуравдугаар байранд оржээ. Эдгээр нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хувийн нууцтай байх зэрэг эрхийг зөрчсөн хэргүүд бөгөөд цаашилбал, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэнд ч халдах магадлалтай юм. Компаниудын гаргаж буй хүний эрхийн зөрчил нь ихэнхдээ дотроо зөрчилтэй буюу дөнгөж зөрчилдөөн нь шийдэгдсэн орлого багатай орнуудад ажиглагдсан байна. Үүний зэрэгцээ эдгээр зөрчил гарсан газруудад засаглал сул байдаг ажээ.

Компаниуд хүний эрхийн зөрчилд өргөнөөр оролцож байгаа баримт нотолгоо хангалттай олдсоор атал 1990 оны дунд үе хүрч байж Төрийн бус байгууллагууд Үндэстэн дамнасан корпорациудыг кампанит ажлынхаа хүрээнд зүй ёсоор хамааруулдаг болжээ. Тэд Үндэстэн дамнасан корпорациуд үйл ажиллагаандаа хүний эрхийг төдийлөн дээдэлдэггүй болох тухай улам их материал цуглуулсан юм.

Олон улсын хүний эрхийн хуулинд компанийн асуудлыг тусгах тал дээр Төрийн бус байгууллагууд илүү өргөн хүрээтэй, санаачлагатай ажиллахад хүргэсэн хоёр нэмэлт өөрчлөлтийг онцолж болно.

**Нэгдүгээрт,** Төрийн бус байгууллагууд олон улсын (хүний эрхийн) нэгдэлд байр суурь эзлэх болсон нь улс орнуудын Засгийн газрын орхигдуулаад байсан байгууллагуудын хүний эрхийг зөрчсөн байдлыг олж илрүүлэх хоосон орон зайг нөхөж өгсөн. Үндэстэн дамнасан корпорац шиг, Төрийн бус байгууллагууд ч гэсэн даяарчлалын нөлөөнд орж, тэдний дундаас

олонх нь үндэстэн дамнаж үйл ажиллагаа явуулах чадвартай болсон билээ.

Төрийн бус байгууллага нь хүний эрхийн асуудлыг олон улсын анхааралд тавих болсноор олон дэвшил авчирсан юм. Хамгийн гол нь Төрийн бус байгууллагууд учраа олж, арга барилаа эзэмшиж эхэлснээр зөвхөн ажиглагчийн байр суурьнаас хандахаа больжээ. Тэд шүүхийн өмнө хүний эрхийн асуудлаар нэхэмжлэл гаргах, мэтгэлцээнд оролцох эрхтэй болсон. Төрийн бус байгууллагын оролцооны энэ хувьсал нь олон улсын хүний эрхийн хуулинд ч бас тусгалаа олсон юм.

**Хоёрдугаарт,** компаниудыг ноцтой анхаардаг болсон нь тохиолдлоор, бас зарим хамаарлаар эдийн засгийн, нийгэм, соёлын эрхийг хүний эрхийн байгууллагууд хөндөж эхлэхтэй давхцсан юм. Хүний эрхийн төлөөх хөдөлгөөнүүд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэт орхигдуулж, иргэний болон улс төрийн эрхэнд төвлөрч ажиллаж байгаа нь учир дутагдалтай гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Энэ нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой хүний эрхийн кампанит ажлууд зохион байгуулагдах үйл явцыг эхлүүлсэн билээ. Жишээ нь, 2001 онд Эмнести Интернэшнл бүрэн эрхээ эргэн харж, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тал дээр даацтай судалгаа хийсэн нь хүний эрхэд томоохон нөлөө үзүүлэх боломжтой компаниуд анхаарлын төвд орох замыг засч өгсөн юм.

Дараагийн хэсэгт компаниудын хүний эрхэд үзүүлэх нөлөөний талаар ойлголт ямар байдлаар хувьсч өөрчлөгдөж ирсэн тухай өгүүлнэ.

### **3. Компаниудын хүний эрхэд үзүүлэх нөлөөний талаар ойлголтын хувьсал**

Хэдхэн арван жилийн дотор компаниудын хүний эрхийн өмнө хүлээх

хариуцлага нь олон улсын анхаарлыг татах болсон юм. Энэ талаар ойлголт 1960 онд эдийн засагч Милтон Фридман хэлсэн “Бизнесүүд бизнесээ л хийх ёстой” гэж хэлсэн алдарт үгнээс өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлийг шигтгэсэн гурван төвт үзэл буюу компаниуд нь хүн, дэлхий мөн ашгийн төлөө ажиллах ёстой гэсэн шинэ үзэл рүү томоохон шилжилт хийсэн билээ. Тодруулбал, компани нь хүний эрхийг дээдлэх үүрэгтэй гэсэн ойлголт маш өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгджээ.

Хүйтэн дайны дараах үед дэлхийн эдийн засаг даяарчлагдаж эхэлснээр компаниуд дэлхийн хөгжиж буй орнуудад үйл ажиллагаагаа явуулах боломж нээгдсэн. 1970–аад оны үед эдгээр хөгжиж буй орнууд нь үндэстэн дамнасан корпорацуудын сөрөг нөлөөллийг анхаарч эхэлсэн юм. Том компаниуд дотоодын үйл хэрэгт хөндлөнгөөс нөлөөлөх, жишээ нь, ардчилсан зарчмаар сонгогдсон Чилийн ерөнхийлөгч Салвадор Аллендэг хүчээр суудлаас нь буулгахад харилцаа холбооны ИТТ компани маш их үүрэгтэй оролцсон нь үндэстэн дамнасан компаниудад зохицуулалт хэрэгтэй болохыг сануулсан хэрэг болжээ. Энэ сануулга нь өргөн утгаараа “Олон улсын эдийн засгийн шинэ зохицуулалт” бий болох үндэслэлд тооцогдов. Дөнгөж тусгаар тогтносон улс орнууд Үндэстэн дамнасан корпорацуудын үйл ажиллагааг өөрсдийнх нь эдийн засаг, улс төрийн орчинд аюултай гэж үзэх болжээ. Тухайн үед колоничлолыг устгах асуудал үүсч, компаниуд улсын дотоодын үйл хэрэгт оролцохгүй байхыг хаа сайгүй шаардлаа. Үүний хариуд НҮБ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн холбоо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага гэх мэт олон улсын байгууллагууд олон улсын харилцааны ёс зүйн дүрэм боловсруулсан билээ. Гэвч чөлөөт худалдааны гэрээ хийгдсэнээс үүдсэн

худалдааны өсөлтөөс үүдээд компаниудын буруутай үйлдэлд олон нийт төдийлөн анхаарал хандуулах сонирхолгүй байв. Үндэстэн дамнасан корпорацууд хаана ч гэсэн олон улсын зохицуулалтаас ангид ялангуяа хүний эрх хамгаалах тухай ойлголт үйлчлэхгүй байсаар хэсэг хугацаа өнгөрсөн юм.

Ерөнхийдөө үндэстэн дамнасан компаниуд хүний эрх нь Засгийн газрын ажил гэж үздэг бололтой. Гэвч компаниуд Засгийн газраар ч бай, бизнесийн түншүүдээрээ ч бай хүний эрхийн зөрчилтэй холбогдох магадлал асар өндөр болж ирэв. Хүний эрхийн өмнө хүлээх компаний хариуцлагын тухай асуудал жил ирэх тутам олон нийтийн анхаарлыг татлаа. Ялангуяа компаниуд хүний эрх зөрчиж байгаа тухай мэдээлэл интернэт дэлгэрэх үед олонд нээлттэй болсноор бүр их хүчээ авсан юм.

1984 онд Бопалд химийн бодис алдагдаж, аюул тарьсан тухай танилцуулга хэсэгт дурдсан. Энэ нь олон нийтийн уур бухимдлыг шатаасан юм. 1990–ээд оны дунд үед хэд хэдэн томоохон тохиолдлуудаас шалтгаалан компаний хүний эрхийн хариуцлагыг улам ихээр шаардах болжээ. 1995 онд Нигерт Кен Саро-Вива зэрэг есөн хүнийг өчиггүй цаазлахад юу ч хийлгүй дуугүй байсандаа Шелл корпораци олон улсын зүгээс шүүмжлэл хүлээв. Хувцасны Nike, Gap брэндийн бэлтгэн нийлүүлэгчид “хөдөлмөрийн тохиромжгүй орчинд ажиллаж байна” гэсэн шүүмжлэл хүний эрхийн хариуцлагын талаарх асуудлыг улам хурцатгалаа. Эцэст нь өөр нэг ноцтой хэрэг гарсан нь Колумб улсад ВР корпорацийн хамгаалалтын ажилтнуудыг өдүүлсэн үйлдэл байлаа. Эдгээр нь олон улсын анхаарлыг тагаж, компаниудын хүлээх хариуцлагыг тодотгов. 1990–ээд оны сүүл үед

байгууллагын хариуцлагын тухай ойлголт дээд цэгтээ тулж, зохицуулалт хийхээс өөр аргагүйд хүрчээ.

Бизнес болон Хүний эрхийн нөөцийн 1990 оноос хойш бизнес болон хүний эрхийн тухай ойлголт гурван үе шаттайгаар хувьссан гэж үзлээ. Дээр дурдагдсан ноцтой хэргүүдийг залгуулж эхэндээ (1998-2000) маргаан голлон дэлхийн хойд хэсэгт буюу Европ, Хойд Америкт өрнөсөн юм. Голлон хойд нутгийн Төрийн бус байгууллагууд ихэнхдээ хувцасны ба олборлолтын компаниудын удирдах зөвлөлийг анхааралдаа авчээ. Эх сурвалжийн үзэж байгаагаар энэ үе үйлдэл гэхээсээ илүү хэлэлцүүлэг болж өндөрлөсөн ажээ. Хоёрдугаар үед (2003-2006) хэлэлцүүлэг хойд өргөрөгт хэвээрээ байсан ч, дэлхийн урд зүг рүү анхаарал нь шилжсэнээр зөвхөн бодлого биш жинхэнэ нөлөөлөл бий болгов. Тэгэхдээ эмийн болон санхүүгийн салбарт чиглэсэн байна. Эцэст нь 2007 онд бизнест хүний эрхийн асуудал хүрээгээ улам тэлж, өмнөд зүгт бүх салбарыг хараандаа байлгаж байдаг идэвхитэй Төрийн бус байгууллагуудтай, ёс зүйг газар дээр хэрэгжүүлэхэд төвлөрсөн жинхэнэ байгууллага болж өргөжсөн юм.

1970–аад оны үед олон компаний аягладаг байсан занг эс тооцвол одоо олон компани хүний эрхийн асуудалд идэвхитэй оролцдог болжээ. Компаниуд өөрсдөө нэгдэн холбоод, мөн олон улсын байгууллагууд төрөл бүрийн ёс зүйн код боловсруулж мөрддөг болж, хүний эрх ихэнхэд нь хэрэгжиж эхэлсэн байна. Түүнээс гадна бизнес ба хүний эрх нь оюуны салбар болон өргөжиж, олон олон бага хурал зохион байгуулж, зөвлөх агентлагууд ажиллаж эхэлжээ.

#### 4. Хашааны гаднаас уу, хурлын өрөөнөөс үү? Төрийн бус байгууллагууд компаниудад ямар аргаар нөлөөлөхийг оролддог вэ?

1970, 1980–аад онд компаниуд хүрээлэн буй орчинд дураар халдаж эхэлсэн бөгөөд Алагчлалын эсрэг кампанит ажлын үеэр компаниудын чиг үүрэг Төрийн бус байгууллагуудын анхаарлыг татаж эхэлжээ. Иргэний нийгэмлэгүүд компаниудын зарим үйл ажиллагааг, жишээ нь тамхин бүтээгдхүүн, эхийн сүү орлуулах бүтээгдхүүн үйлдвэрлэгчдийн маркетингийн үйл ажиллагааг эсэргүүцэж байлаа. Гэсэн ч бизнесүүдийн нөлөөлөл нь хүний эрхийн томъёололд тусгагдаагүй бөгөөд хүний эрхийн Төрийн бус байгууллагууд тэрхүү компаниудад анхаарал хандуулсангүй. Төрийн бус байгууллага компаниудын хүний эрхэд үзүүлж буй нөлөөнд 1990-ээд оноос эхэлж л анхаарч ирсэн юм. Дээр дурдсанаар бизнес ба хүний эрхийн асуудлын хамгийн гол хурдасгуур нь Төрийн бус байгууллага биш, 1990-ээд онд компаниудын гаргасан алдаа байсан юм.

Өнөөдөр, дэлхийн хүний эрхийн хөдөлгөөнийг дандаа л Төрийн бус байгууллагууд зохион байгуулдаг гэхэд хилсдэхгүй. Түүгээр зогсохгүй хүний эрхийн томоохон Төрийн бус байгууллагууд кампанит ажилдаа компаниудыг ч оролцуулдаг. Компаниуд хүний эрхийг хэрэгжүүлж байгаа эсэхийг шалгах зорилготой хэд хэдэн Төрийн бус байгууллагууд байгуулагджээ.

Төрийн бус байгууллагын кампанит ажлууд нь компанийн хүний эрхийн зөрчлийг ил болгож, баримтыг шүүхийн өмнө танилцуулж байна.

Компаниудын зан төлөвт нөлөөлөх гэж оролдон Төрийн бус байгууллагуудын авдаг арга хэмжээг хэд хэдэн ялгаатай төрөлд хувааж үзэж болно. Винстон энэ

асуудалд “Ятгагчид” болон “Тэмцэгчид” хоёрыг ялган тодорхойлсон байдаг. Ятгагчид нь компаниудтай харилцаанд орж, хүн чанарыг нь хөндөх замаар сайн дураараа ёс зүйн зарчмуудыг авч хэрэгжүүлэхийг санал болгодог. Бизнесмэнүүдийг хүний эрхийн асуудлаар ятгахдаа компаниуд хүний эрхийг хэрэгжүүлэх тал дээр түнш болж ажиллана гэсэн найдвар агуулдаг. Төрийн бус байгууллагууд нэгэн сэтгэлээр ятгалгын аргыг хэрэглэсэн олон жишээ бий. Компаниудтай хүний эрхийн асуудлаар харилцахдаа Төрийн бус байгууллагууд нийтлэг “хэл” олохыг хичээдэг юм. Тэгэх нэг арга нь “хүний эрхийн бизнес сэдэл” танилцуулах юм. Компаниуд хүний эрхийг дээдэлж ажилласнаар маркетингийн давуу боломж олно гэдгийг танилцуулахыг Төрийн бус байгууллагууд хичээдэг. Энэ арга нь олон нийтийн сөрөг үзэл бодолд эмзэг, эцсийн брэнд зах зээлд нийлүүлдэг компанид л таарна. *Хоёрт*, хүний эрхийг дээдэлснээрээ жинхэнээсээ сурталчилгааны ач холбогдолтой эсэх талаар ямар нэгэн судалгаа байхгүй. Сулливаны онож хэлснээр энэ арга нь компаниуд яагаад хүний эрхийг дээдлэх ёстой мөн чанарыг алдагдуулах магадлалтай. Хүний эрхийг зардал–үр ашгийн шинжилгээгээр шийдэх гэдэг нь хүний эрхийн мөн чанарт харшилж байгаа хэрэг.

Иймээс ятгалгын арга шүүмжлэлд өртдөг. Ялангуяа уламжлал ёсоор компаниудтай харьцдаг Үйлдвэрчний эвлэлүүд үүнийг ихээр шүүмжилдэг. Тэмцэгчид ангилалд багтах Төрийн бус байгууллагууд нь “нэрлэж, ичээх” аргыг ашигладаг. Компаниудын санхүүгийн байдалд ямар нэгэн дарамт шахалт үзүүлэх замаар л асуудлыг шийдэж болно гэж энэ ангиллын хүмүүс үздэг.

Эдгээр хоёр арга нь бие биенийгээ нөхөж үйлчлэх боломжтой. Тэмцэгч аргаар



анхаарлыг тагаж, ятгагч аргаар үр дүн гаргаж болохыг Сэр Чандлер “Тэмцлээр асуудлыг дэвшүүлж, ятгалгаар маргаанд ялна” гэж тодорхойлсон юм. Угаас ихэнх Төрийн бус байгууллагууд ятгах буюу тэмцэх аргыг аль нэгийг биш, зэрэгцүүлж хэрэглэдэг.

### 5. Эмнести Интернэшнлийн гүйцэтгэсэн үүрэг

Компаниудын хүний эрхийн асуудлаар Эмнести Интернэшнлийн хийсэн ажил нь тодорхой хэмжээнд авч хэрэгжүүлдэг уламжлалт арга барилтай нь зөрчилдсөн мэт харагдаж мэднэ. Нөгөө талаас цэрэг, хамгаалалт, цагдаагийн хэрэгслийг эрүүдэн шүүх зорилгоор ашиглаж байгаа байдал нь эхэн үеэсээ л Эмнести Интернэшнлийн анхаарлыг татсан. Төрийн оролцоогүй байгууллагуудтай тулж ажиллахын тулд цоо шинэ арга хэрэгсэл хэрэгтэй болсон юм. Учир нь компаниуд зөрчлөөс зай барьж чаддаг бөгөөд яг өөрсдийн биеэр хүний эрхийг зөрчөөгүй, хам байдлаар оролцсон байдаг учир нотлоход бүр хэцүү байдаг. Тиймээс Эмнести Интернэшнлийн компаниудад чиглэн хийх ёстой ажлууд нь цэрэг цагдаа, хамгаалалтын асуудлуудаас арай өөр ялгаатай харагдана.

Бизнесийн салбараас гаралтай гишүүдээс бүрдсэн Их Британий Эмнести Интернэшнлийн Бизнес бүлэг 1991 онд байгуулагдсанаас эхлэн Эмнести Интернэшнл энэ чиглэлээр ажиллах болсон. Тус бүлэг нь шууд ятгалгын арга авч ашигладаг бөгөөд компаниуд хүний эрхийг дээдлэх тал дээр ямар хувь нэмэр оруулж чадах талаар төвлөрөн ажилладаг. Бизнесийн бүлгийг үүсгэн байгуулагч Сэр Чандлерын онцолсноор хүний эрх зөвхөн Засгийн газрын асуудал гэж үзэх хандлагатай байсан тухайн үед энэ нь маш мэдрэмжтэй шийдвэрт тооцогдсон юм. 1991 оны Санамж бичгийн

дагуу бүлгийн зорилт нь “Их Британий бизнес нэгдлүүдэд дэлхийн өнцөг булан бүрт хүний эрхийн асуудал ямар байгааг ойлгуулах”, “Гадаадад хөрөнгө оруулж, үйл ажиллагаа явуулдаг компани, бизнесмэнүүдийг олон улсын холбоогоо ашиглан хүний эрхийн байдлыг улам сайжруулахад урамшуулах” гэсэн байжээ.

Эмнести Интернэшнл энэ санаачилгыг эхэндээ үл ойшоож, удирдлагаас бараг дэмжлэг үзүүлэхгүй байж.

1992 онд Их Британий Бизнес бүлгээс Өмнөд Африк, Хятад гэх мэт тодорхой улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниудад төвлөрч ажиллахаар шийдсэн нь сонирхол татав. Гэсэн ч эхний хэдэн жилдээ Их Британий Бизнес бүлэг олны дэмжлэг хүлээж чадахгүй л байлаа.

Эмнести Интернэшнлийн хувьд үйл явцыг тэдэнд ашигтайгаар хурдасгаж өгсөн хүчин зүйл нь компаниудын өөрсдийн байр төлөв байв. Нигер дэх Шелл корпораци, Колумб дахь ВР корпорацийн гэх мэт ноцтой хэргүүд компаний хүний эрхийн асуудалд олон улсын анхаарлыг ихээр татсан юм. Шелл корпорацийн Кен Саро Вивагийн аллагад оролцсон оролцоонд Эмнести Интернэшнл харьцангуй уламжлалт арга барилаараа хандан эхэндээ Шелл корпорацийн удирдлагуудтай тулж тэмцэв. Шелл тэгэхэд таамаглахааргүй хариу өгч, нийгмийн үзэл санаанд харшилсан хэрэг болсныг хүлээн зөвшөөрсөн юм. Түүнээс улбаалан Их Британид ч, Голландад ч Шелл болон Эмнести Интернэшнл хоёрын хооронд урт удаан үргэлжилсэн хэлэлцээр явагдсан билээ. Ийнхүү 1997 оны Шеллийн Бизнесийн Ерөнхий Зарчмын баримт бичигт хүний эрхийн асуудлыг тусгасан юм. Гэхдээ тэр ололт нь “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”-тай харьцуулахад чамлалттай байлаа. Хамгаалалтынхан нь

олны дургүйцлийг хүргээд байсан ВР-тэй ч гэсэн хэлэлцээр эхэлж, улмаар ВР ч гэсэн бизнесийн зарчмаа албан ёсоор өөрчилжээ. 1997 онд Эмнести Интернэшнл Компаниудын хүний эрхийн талаар баримтлах удирдамж боловсруулж, түүндээ компаниуд яах хэрэгтэйг нилээн нарийвчлалтайгаар тусган бизнес хүний эрхийн асуудлаарх Бирмингамын бага хуралд танилцуулсан билээ.

Компаний хүний эрхийн хариуцлагын асуудлыг нь одоо Эмнести Интернэшнлийн үндэсний салбаруудын ихэнх нь анхааралдаа авч, цөөхөн ч гэсэн Үндэстэн дамнасан корпорацуудтай холбогдож, Шелл, ВР нарын замаар хөтөлж чадлаа.

Жишээ нь, Эмнести Интернэшнлийн Голланд дахь салбар энэхүү асуудалд “Паке Кристи Интернэшнл” Төрийн бус байгууллагатай хамтран эртнээс оролцож эхэлсэн байсан юм. Тус Төрийн бус байгууллагаас хэд хэдэн компанитай дугуй ширээнд цуглан сууж, улмаар 1998 онд “Олон улсын корпорацууд хүний эрхийн асуудлаар” гэсэн илтгэл хэлэлцүүлсэн. Энэ илтгэл нь байгууллагын хүний эрхийн хариуцлагын тухай мэдлэгт хамгийн том нэмэр болсон материалуудын нэг билээ.

Эмнести Интернэшл байгууллагын хүний эрхийн хөдөлгөөнд оруулсан хувь нэмрийг тоймловол тус байгууллага эхлээд байгууллагуудыг ятгах аргаар оролдсон юм. 2002 онд тухайн үеийн Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Ирене Ханы мэдэгдэлд Эмнести Интернэшнлийн байр суурь, цаашид явал зохилтойг илэрхийлсэн байв.

Өнөөдөр компани болон хүний эрхийн асуудалд Эмнести Интернэшнл ятгах, тэмцэх аргыг шаардлагатай тохиолдолд нь солбин, хослуулан хэрэглэдэг билээ. Эхэн үедээ баримталсан ятгалгын арга нь тодорхой үр дүнд хүргээгүй учир стратегээ дахин

бодолцож үзэхэд хүрсэн аж. Түүнээс хойш компаниудыг өөрсөдтэй нь хамтран ажиллах үүрэгтэй болгох улсын болон олон улсын хууль зүйн тогтолцоог бүрдүүлэх, жишиг тогтоох ажилд түлхүү анхаарал хандуулжээ. 1990 оны эхэн үед болгоомжтой эхэлж байсныг нь бодвол компаний хариуцлын тухай асуудал нь өнөөдөр Эмнестигийн гол чиг үүргүүдийн нэг нь болсон юм. Одоогоор тус байгууллага нь судалгаа, шинжилгээний үндсэн дээр доорх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Компаниудын үйлдэж, Засгийн газар нь хориг тавьж чадахгүй байгаа хүний эрхийн зөрчлийг онцлон илрүүлж, боломжтой бол тохиолдол бүрт нь тус компанид хариуцлага хүлээлгэнэ. Бизнес ба хүний эрхийн дэлхийн жишгийг бий болгох, хүний эрхэд үзүүлсэн нөлөөллөөр нь компаниудад хариуцлага тооцох үндэсний болон олон улсын хэмжээний хууль зүйн тогтолцоог хүчжүүлэх зорилготой кампанит ажлуудыг зохион байгуулна.

## **6. Засаглал, зохицуулалтын хариу үйлдэл**

Хүний эрхийг дээдлэн ажилдаггүй компаниудад анхаарлыг ихээр хандуулж эхэлснээр энэ тал дээр зохицуулалт хийх зайлшгүй шаардлага бий болгосон юм. Энэ хэсэгт компаниудыг хариуцлагажуулах шаардлагад компаний засаглал, зохицуулалт талаас хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн, Эмнести Интернэшнл гэх мэт Төрийн бус байгууллагууд тэрхүү хариу үйлдэлд ямар байдалтай оролцсон талаар дурдах болно.

Төрийн бус байгууллагуудын, ялангуяа Эмнести Интернэшнлийн компаниудад тавих хүсэл шаардлагыг ажил болгоход хүний эрхийн хууль чухал нөлөөтэй байлаа. Хүний эрхийн хуульчид “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”-ыг эхлэлийн цэг болгон сонгосон. Энэ баримт бичиг нь

нийгмийн бүрдэл бүрийг, хүн бүрийг хүний эрхийг хамгаалж, дэлгэрүүлэхэд уриалан дуудсан байдаг. “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал”-ын 50 жилийн ойн ёслол дээр Профессор Люис Генкины хэлснээр “Хүн бүрт эрх ашиг гэж бий. Хаана ч байсан, хэн ч байсан, ямар ч компани, ямар ч зах зээл байсан үүнийг үл хайхрах учиргүй” гэсэн байна. Энэ нь бизнесийн зарчим, ёсзүйн дүрэмдээ хүний эрхийн асуудлыг тодорхой тусгах ёстой гэсэн үг.

### 6.1 Хувийн зохицуулалт

Зүй нь компаниудын гаргаж буй хүний эрхтэй холбоотой асуудлыг шийдүүлэхээр Засгийн газарт нь хандах ёстой. Гэвч эрх баригчид нь өөрөө эдгээр компанийг шахаж шаардах сонирхолгүй байдаг. Энэ хоосон орой зай нь компаний хүний эрхийн хариуцлагыг зохицуулалтанд оруулах талаар олон улсын хэмжээнд ажиллах шалтгаан болсон юм. Олон бүс нутагт Засгийн газраас бусад этгээдүүд өөрсдийн гэсэн засаглал тогтоох нь түгээмэл болсон. Сурталчилгаанаас төлбөрийн систем хүртэл бүхий л салбарт бизнесийн холбоод, худалдааны байгууллагууд, Төрийн бус байгууллагууд бий болсон юм. Энэ хувийн зохицуулалтуудын нийтлэг шинж чанар нь Төрийн бус байгууллагууд тэрхүү жишгийг боловсруулах, хэрэгжилтийг хянах ажлыг үндэстэн дамнан хянаж байдаг нь үнэн. Тухайн орны Засгийн газрын оролцоо энэ тохиолдолд маш бага буюу огт байхгүй байдаг. Зохицуулалтын тэрхүү олон талт аргын давуу талыг өдөр ирэх тусам үнэлдэг болжээ. Бүр тэрхүү хэлбэрийн зохицуулалт нь олон улсын хуулиас илүү хувийн хэвшилд нэвтрэх чадвартай байж болох талаар санаачилга гарчээ.

Бизнес ба хүний эрхийн салбарт тэрхүү үндэстэн дамнасан хувийн зохицуулалтын

дэглэмүүдээс олныг дурдаж болно. Жишээ нь Электроникийн үйлдвэрийн иргэний Холбоо, Экваторын Зарчим, Шударга Хөдөлмөрийн Холбоо, Дэлхийн мэдэгдлийн Санаачлага, Кимберлейн процесс, Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын зарчим. Эдгээр жишиг, стандартуудыг хэрэгжүүлэх, хянах санаачлагыг Төрийн бус байгууллагууд хүлээсэн. Жишээ нь, 2000 онд Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлсан Төрийн бус байгууллага нь Эмнести Интернэшнл юм. Эмнести Интернэшнл нь тэрхүү тогтолцоонд Төрийн бус байгууллагуудыг манлайлагч нь хэвээр байна.

Олон улсын хүний эрхийн жишгүүдийг дагаж мөрдөх замаар хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг татах өрсөлдөөн нь компаниуд олон талт санаачлагуудад нэгдэх шалтгаан болж байгаа бөгөөд зах зээлд суурилсан гэж үзэж болно. Олон олон компаниуд түгээмэл ёс зүйн зарчмыг үйл ажиллагаандаа тусгах буюу, салбарынхаа гаргасан дүрэмд нэгдсэн байдаг. Өөр нэг хувилбар нь “эрх зөрчигдөөгүй” жишээ нь гадил, кофе гэх мэт брэнд бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх, ёс зүйтэй хөрөнгө оруулалт, бизнес шийдвэр гэх мэт ойлголтууд юм. Эдгээр ололтуудын гол санаа нь компаниуд хүний эрхийг хамгаалахад анхаарах болсныг илэрхийлж байна.

Компаниуд зах зээлд чиглэсэн эдгээр бодлогыг хэрэгжүүлээд байгаа нь “компаний нийгмийн хариуцлага” гэдэг ойлголт юм. Компаний нийгмийн хариуцлага гэдэг энэ томъёоллын ганц сул тал нь нийтлэг тодорхойлолтгүй, зүгээр л компаниуд өрсөлдөөнд давуу тал олж авах зорилгоор сайн дурын үйл ажиллагаанд оролцох шалтгаан болжээ. Компаний хүний эрхийн хариуцлагыг нийгмийн хариуцлагад тусгаж

эхэлсэн нь хүний эрхийг сайн дураар хэрэгжүүлэх үндэслэл болж өглөө. Мөн, зах зээлийн зарчимд үндэслэсэн дэглэм нь зарим тохиолдолд зохицуулалтын санаачлагыг зөвхөн бэлэг тэмдэг төдий зүйлд хувиргаж байна гэж шүүмжлэлд өртөх нь бий. Бусад Төрийн бус байгууллагуудын л адил Эмнести Интернэшнл ч зарим компаний үзүүлж байгаа аюулыг сайн дурын тогтолцоо халж чадахгүйг анхааран бизнес ба хүний эрхийн дэлхийн жишгийг улам хүчтэй, илүү өргөн хүрээтэй болгохын төлөө ажилласаар байх болно.

## 6.2 Үндэсний хэмжээнд

Олон улсын хүний эрхийн жишгүүдийг дагаж мөрдөн өрсөлдөгчдөөсөө ялгарах хүсэл сонирхлоос гадна үндэсний хууль зүйн системдэх иргэнийг хууль бусаар шүүн таслах аюул нь сүүлийн хэдэн арван жилийн сайн дурын үйл ажиллагааны хөшүүрэг байсаар ирсэн. Компаний хүний эрхийн маргаан нь АНУ-ын Алиен Тортын тогтоомжийг дахин тайлбарлах явдлыг хурдасгасан юм. 1789 оны АНУ-ын Холбооны энэ хууль нь гадны гомдол гаргагч (Алиен буюу харь гаригийн хүн) нь АНУ-ын холбооны шүүхэд “олон улсын хууль”-ийн зүйл заалтыг зөрчсөн тохиолдлоор зарга мэдүүлэх боломж олгожээ. Алиен Тортын тогтоомжид үндэслэн нэгэн компаний эсрэг гаргасан хамгийн анхны хэрэг болох 1997 оны До, Юнокалын хэрэг нь АНУ-ын холбооны дүүргийн шүүхийн өмнө олон сая долларын өрөнд унасан олон хэргийн салхийг хагалсан билээ. АНУ-ын Холбооны шүүхэд олон компани, түүний дотор Эксон Мобил, Техсако, Кока-Кола, Шеврона зэрэг компани олон төрлийн хууль зөрчсөн, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн зэрэг хэргээр дуудагдсан юм. Гэхдээ нэхэмжлэгчдийн гаргасан нэхэмжлэл нь ихэнх тохиолдолд хэрэгсэхгүй болох

байдлаар шийдэгдэж ирсэн нь Алиен Тортын тогтоомж нь байгууллагын хүний эрхийн зөрчлийг зогсоох хүчирхэг зэвсэг мөн гэсэн үнэлгээ нь хэгийдсэн болохыг баталж өгсөн. Түүгээр зогсохгүй, Киобел, Шелл нарын 2010 оны хэрэг АНУ-ын Давж заалдах шатны шүүхэд шийдэгдэхдээ Алиен Тортын тогтоомжийн дагуу өмнөх хэргүүдийг шийдэж байсан жишгийг үл хамааран компанийг олон улсын хуулийг зөрчсөнд буруутгах үндэслэлгүй гэж үзсэнээр найдвар бүр тасарсан билээ.

Тэгсэн ч Алиен Тортын тогтоомжийн дагуу болсон шүүхийн шийдвэрээр хэд хэдэн Үндэстэн дамнасан корпорац хохирогчдын хохирлыг нөхөн төлсөн. Түүгээр зогсохгүй Алиен Тортын тогтоомжийн хүрээнд бий болсон өөрчлөлтүүд нь компаниудыг гадаадад үйлдсэн хэргийнх нь төлөө үндэснийх нь шүүхээр яллаж болно гэсэн жишгийг тогтоож өгсөн. Хөгжиж буй орнуудад байгаа салбар, төлөөлөгчийн газар нь хүрээлэн буй орчин буюу хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлсэн бол толгой компанийг нь хэрэгт татах тохиолдол улам олширсоор байна. Хуулийн хариуцлагыг АНУ болон Европын орнуудад татан авчрахаас гадна Үндэстэн дамнасан корпораттай хөгжиж буй орнууд ч гэсэн хариуцлага тооцох боломж гарч байна. Үүний үр дүнд хүний эрхийг дээдэлдэггүй байгууллагууд хүний эрхийн хариуцлага хүлээх эрсдэл өндөрсөж байгаа юм.

Урт хугацааны шүүхийн заргатай холбоотой цаг хугацаа, зардлыг даах чадвар нь байгууллагын хүний эрхийн хохирогчдод тулгарч буй өөр нэг саад мөн. Төрийн бус байгууллагууд компаний хүний эрхийн хариуцлагыг хүлээлгэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн. Алиен Тортын тогтоомжийн хүрээнд сөхөгдсөн компаний олонхид нь тэрхүү зардлыг нь Үндсэн Хуулийн эрхийн

Төв, Дэлхийн эрх Интернэшнл гэх мэт Төрийн бус байгууллагууд даасан байдаг.

Хүний эрхийг зөрчсөн компаниудад хариуцлага хүлээлгэдэг үндэсний хуулиудаас гадна хүний эрхэд үзүүлэх компаний нөлөөллийг зохицуулах үндэсний түвшний өөр нэг арга хэрэгсэл бий. Гадаад бодлогын зорилт нь компаний зан төлөвийг бойкотлох замаар зохицуулах зохицуулалт байж болно. Үүний нэг жишээ нь Бирм дэх АНУ-ын болон тэндээс бараа бүтээгдхүүн импортолдог компаниуд. Эдийн засгийн зохицуулалтын арга хэрэгсэл нь өөр олон оронд хэрэглэгддэг юм. Гэхдээ эдийн засгийн зохицуулалтын үр дүнтэй байдал нь эргэлзээтэй.

Компаний зан төлөвийг зохицуулах өөр нэгэн үр дүнтэй арга нь компаниудыг нийгмийн асуудлаар тайлан, илтгэл гаргуулах арга юм. Энд санаачлагатай, боломжийн жишээг дурдаж болно. 2010 онд АНУ-д санхүүгийн шинэчлэл хийгдэж буйтай холбоотойгоор үнэт цаасны шинэ зохицуулалтыг нэвтрүүлжээ. Дод-Франк Уол Стритийн Реформын 1502-р зүйл нь (цаашид “1502-р зүйл” буюу Бохир ашигт малтмалын Зарчим гэх) хүний эрхэд чиглэсэн анхны үнэт цаасны зохицуулалт мөн. 1502-р зүйл нь Африкийн Сахар орчмын сөргөлдөөний санхүүжилт, Конго болон холбогдох улсуудаас голлон импортолдог тусгай ашигт малтмал ашигладаг компаниудыг АНУ-ын үнэт цаасны зохицуулах хороонд тайлангаа хүргүүлэхийг шаардсан. Бохир ашигт малтмалын зарчим нь хувьцаат компаниудыг үнэт цаасны зохицуулах хороонд бүтээгдэхүүнд нь Конго болон холбогдох улсуудаас орж ирсэн ашигт малтмал хэрэглэгдсэн эсэх тухай тайлангаа өгөхыг шаардсан юм. Тийм байвал, жилийн тайландаа буюу вэб сайтдаа тэрхүү ашигт малтмалын эх үүсвэрийг тогтоохоор юу хийсэн, тэдгээр нь зэвсэгт мөргөлдөөнийг

санхүүжүүлсэн эсэхийг нь тогтоосон байхыг шаарддаг. Түүнийгээ баталж чадахгүй бол тэр компани бүтээгдхүүнээ “Конгийн зөрчилдөөнд хамаатай” гэж тамгалах ёстой.

1502-р зүйлийн нөлөөлөл нь үнэхээр гайхалтай байх магадлалтай юм. Дээрх ашигт малтмал нь олон төрлийн бүтээгдхүүнд ашиглагддаг бөгөөд ашигт малтмалынхаа эх үүсвэрийг тодорхойлохоор олон компани ажиллах шаардлагатай болно гэсэн үг. Тэрхүү хүчин чармайлтынхаа хүрээнд мөн хүний эрхийн Төрийн бус байгууллагуудын сорилттой нэгдэхээрээ өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн жишиг тогтоно гэж найдаж байна.

Эмнести Интернэшнл нь 1502-р зүйлийг “бохир ашигт малтмалтай тэмцэхэд хамгийн шаардлагатай ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг ил болгож, хариуцлагыг тогтооход чухал алхам” гэж үнэлсэн билээ. 1502-р зүйл нь Төрийн бус байгууллагуудад хүний эрхийн шаардлагыг компаниудад тавихад томоохон ар тал болж чадах юм. Нэгдүгээрт, тус зарчмаар компаниуд тайлангаа зөвхөн үнэт цаасны хороонд ч биш олон нийтэд танилцуулах ёстой болохоор Төрийн бус байгууллагууд мэдээлэл олж авах боломж олгодог байна. Төрийн бус байгууллагууд маш хүчтэй хяналтын үйл ажиллагаа явуулж, мөн тэр мэдээллээ Үнэт цаасны зохицуулах хороо (АНУ-ын хамгийн хүчтэй санхүүгийн байгууллага)-нд өгч болно. Түүгээр зогсохгүй буруу буюу худлаа мэдээлэл компанийг шүүхэд өгөх үндэслэл ч болох юм.

1502-р зүйл нь компаний хүний эрхийг дээдлэх явдлыг үндэсний хэмжээнд баталгаажуулах үр дүнтэй зохицуулалтын арга хэрэгсэл бий болгоход үлгэрлэх зорилгоор зарим талаараа маш нарийн боловсруулагдсан. Компаний ил тод, тунгалаг байдал нь компаний хүний эрхийн

хариуцлагыг сайжруулахад хамгийн хэрэгтэй зүйл. Санхүүгийн бүх мэдээллээ тайлагнаж байхыг шаардах замаар ил тод байдлыг сайжруулах жишээ нь сайн дурын үйл ажиллагаагаар эхэлж, үндсэн шаардлага болон хөгжих замаар өөр улс орнуудад ч гэсэн тогтсон зүйл юм. Европын Холбооны түвшинд, заавал тайлагнах зүйлийн тухай хуулийн төслийг 2011 оны дуусахаас өмнө өргөн барина.

Өдөр бүр нэмэгдэж байгаа компанийг хувийн болон үндэсний түвшинд хариуцлагажуулах шаардлагад зохицуулалт засаглалын хариу үйлдлийн талаарх товч ойлголт нь ямартай ч шийдвэрлэх өөрчлөлтийн эхлэлийг харуулж байна. Гэхдээ дээр дурдагдсан засаглалын болон зохицуулалтын хариу үйлдэл нь мөн л сул талтай. Тэрхүү сул талын ихэнх нь сайн дурын шинж чанар дутсан буюу зохицуулалт нь зарим нэг зүйлээр хязгаарлагдмал байдагтай нь холбоотой. Тиймээс Эмнести Интернэшнл, бусад Төрийн бус байгууллагууд нь дэлхий даяарх төгс зохицуулалтыг төлөвшүүлэхийн төлөө ажилласаар л байх болно.

### 6.3 Олон улсын түвшин

Олон улсын, ялангуяа НҮБ-ын түвшинд, компаний үйл ажиллагааг зохицуулах олон улсын жишиг тогтоохтой холбоотой хэд хэдэн санаа санаачлагууд гарсан. Хэдийгээр энэ амархан ажил байгаагүй ч хүчин чармайлтын ихэнх нь үр дүн муутай, улс төрийн дэмжлэг, хэрэгжүүлэх арга техникийн дутагдалтай.

Энэхүү хэсгийн хөндөх гол асуудал нь НҮБ-ын хүрээн дэх асуудлуудыг хөндөхөөс гадна олон улсын байгууллагуудын компаниудад шууд чиглэн боловсруулсан жишгүүдийг хэлэлцэх болно. 1977 онд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас “Үндэстэн дамнасан компаниудын гурван талт Тунхаг” гэдэг баримт бичгээ

боловсруулсан юм. Мөн чанарынхаа хүрээнд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага нь Төрийн бус байгууллагууд, мөн хязгаарлагдмал ч гэсэн ажилчин болон ажил олгогчдын төлөөллөөс бүрддэг. 1976 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллага мөн эдийн засаг, орчин, нийгмийн хөгжилд компаниудын оруулах хувь нэмрийг дэмжихийн тулд Үндэстэн дамнасан компаниудын Удирдамж гэх сайн дурын зарчим, жишгийн багц баримт бичгээ баталжээ. Компаний хүний эрхийн асуудлын хувьсал нь 2011 оны 5-р сард болсон онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын үйл ажиллагааны тайлангаас харагдана. 2000 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын удирдамжид хүний эрхийн асуудал дурдагдах төдийхөн байсан бол 2011 оны 5-р сарын 25-нд баталсан удирдамжинд хүний эрхийн талаар бүтэн бүлэг оржээ. Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын удирдамжийг шинэчлэн боловсруулах үйлсэд Төрийн бус байгууллагуудын оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй.

НҮБ-д компаниудад шууд ашиглагдах олон улсын зарчмыг боловсруулах анхны оролдлогууд нь 1970, 1980-аад онд НҮБ-ын Үндэстэн дамнасан корпорацуудын асуудлаарх хорооноос хийгдэж, амжилт ололгүй өндөрлөсөн юм. Энэхүү хүчин чармайлт нь шинэхэн тусгаар тогтносон улсын дотоод үйл хэрэгт олон улсын компаниуд эдийн засаг, улс төрийн нөлөөллөө ашиглан хутгалдах болсон тухай шүүмжлэлээс үүдэн гарчээ. 1992 онд энэ асуудлаар дэлхий нийтийн зарчим боловсруулах оролдлогыг зогсоосны зэрэгцээ НҮБ-ын Үндэстэн дамнасан корпорацуудын асуудлаарх хороог НҮБ-ын Худалдааны хөгжлийн Бага хурлаар дуулиангүйгээр татан буулгажээ.

Компани, хүний эрхийн асуудлаар



дэлхийн стандарт тогтоох хүсэл эрмэлзлийг 1998 онд НҮБ-ын хүний эрхийг хамгаалж, дэлгэрүүлэх дэд хороо санаачилж, боловсруулав. 2003 оны наймдугаар сард НҮБ-ын дэд хорооноос Үндэстэн дамнасан компаниуд болон бусад байгууллагуудын Хүний Эрхийн хариуцлагын Жишиг (НҮБ-ын Жишиг) гэдэг баримт бичиг боловсруулж баталжээ. Өнөөдрийг хүртэл энэ баримт бичиг нь олон улсын түвшинд боловсруулагдсан компаниудын хүний эрхийн хариуцлагын талаарх хамгийн хүртээмжтэй, олон талт баримт бичиг хэвээр үйлчилдэг Төрийн бус байгууллагууд энэхүү баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаанд хүч нэмэн оролцсон бөгөөд Эмнести Интернэшнлийг тооцоод олон Төрийн бус байгууллага энэхүү НҮБ-ын жишгийг компаниудад хууль зүйн хариуцлага үүрүүлэх чухал алхам гэж үзэж байсан учир дэмжиж ажилласан билээ. Гэтэл Засгийн газрууд, мөн бизнесийн холбоодууд эсэргүүцэж байлаа. НҮБ-ын жишгийн зарим нэг зүйл заалт нь хэтэрхий дэлгэрэнгүй, хэт ил тод байдлыг илэрхийлсэн нь бизнесүүд болон эрх баригчдад төдийлөн таалагдсангүй. Үүний үр дүнд тэр үеийн НҮБ-ын хороо НҮБ-ын жишгийг батлахдаа хууль зүйн үндэслэлгүй гэдгийг нь тодруулж өгсөн юм. Төрийн бус байгууллагууд энэхүү баримт бичигт дэмжлэг олох өргөн хүрээнд гэж хичээсэн ч, дэмжлэг олоход хэтэрхий ярвигтай асуудал болж таарчээ.

Тэрхүү ацан шалааг тайлахын тулд 2005 оны 8-р сарын НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бизнес ба Хүний эрхийн асуудлаарх тусгай төлөөлөгч томилж, түүнд “үндэстэн дамнасан компаниуд болон бусад компаниудын хүний эрхтэй холбоотой үүрэг хариуцлагын жишгийг тодорхойлж, тодруулах” чиглэл өгсөн байна. Тэрхүү тусгай төлөөлөгчөөр профессор Жон Рагги сонгогдсон юм.

Тусгай төлөөлөгч хүний эрхийн зөрчилд бизнесүүд ямар үүрэгтэй талаарх олон асуудлуудаас тоотой даацтай хэдийг нь сонгож, олон нийтэд дэлгэсэнээр компаний хүний эрхийн хариуцлагыг дахин анхааралд авчирч чадсан. Олон жилийн турш боловсорсон харилцан уялдаагүй зохицуулалтын санаачлагыг нэгтгэн зангидах ажлынх нь хүрээнд тусгай төлөөлөгчийн ажил нь олон сонирхогч талуудын эрх мэдлийн төв цэг болж чаджээ. Түүний тодотгосон байгууллагын хүний эрхийн хариуцлагын талаарх асуудалд ямар хөшүүрэг бий болгосныг доор арай дэлгэрэнгүй дурдъя.

2008 онд тусгай төлөөлөгч хамгаалах, хүндлэх, хохирлыг барагдуулах тухай бодлогыг удирдамжаа (ТТ удирдамж) танилцуулав. Энэ удирдамж нь гурван баганатай. Гуравдагч этгээдүүдээс хүний эрхийг хамгаалах нь Засгийн газруудын үүрэг. Үүнд компаниуд ч хамаарна. Бусдын эрх зөрчигдөхөөс сэргийлэх тал дээр хүчин чармайлт гаргаж ажиллах, үйл ажиллагаандаа хүний эрхийг дээдлэн ажиллах нь компаниудын үүрэг. Хохирогчид гомдлоо мэдүүлж, шүүхийн болон шүүхийн бус журмаар хохирлоо нөхөн төлүүлэх эрх. 2011 оны зургадугаар сард НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл Тусгай төлөөлөгчийн удирдамжийн үйл ажиллагаа чиглүүлэх зорилгоор боловсруулсан зарчмыг хүлээн зөвшөөрсөн. НҮБ-ын жишгийг бодвол ТТ-ийн удирдамж, чиглүүлэх зарчим нь арай төвийг сахисан, “зөрчихгүй байх” гэсэн Засгийн газар, компаниудын үүргийг илүү тодотгож өгсөн байдалтай байв.

Тусгай төлөөлөгчийн сонирхогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдөж, олон Төрийн бус байгууллагууд энэ үйл ажиллагаанд нь хувь нэмэр оруулсан юм. Эмнести Интернэшнл ч гэсэн тусгай

төлөөлөгч бүх сонирхогч талуудыг нэг дор цуглуулж чадсаныг нь үнэлэн ТТ удирдамж боловсруулах явцад өөрийн талаас дэмжлэг үзүүлжээ. ТТ-ийн удирдамж, чиглүүлэх зарчмыг бизнесийн холбоод өргөнөөр хүлээж авсан юм. Учир нь компани, Төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчид, орон нутгийн холбоодын харилцааг хөнгөвчлөхүйц нэгдсэн томъёолол бий болгосон байлаа. Гэвч өөр хэд хэдэн Төрийн бус байгууллагын хамтаар Эмнести Интернэшнл нь ТТ удирдамжинд ялангуяа чиглүүлэх зарчимд шүүмжлэлтэй хандсан.

Тусгай төлөөлөгчийн ачаар НҮБ-ын жишгийн асуудалд үүссэн гацааг арилгаж чадсан боловч харьцангуй прагматик арга барилаас нь болж гол анхаарлыг компаний хариуцлагын асуудлаас компаний үүргийн асуудал руу хазайлгаж орхисон байсан юм. Эмнести Интернэшнл нь компаниудад нэгдсэн нэг дүрэм бий болгохыг зорьдог учир шүүмжлэх нь аргагүй.

Засаглал, зохицуулалтын хариу үйлдэл талаас нь аваад үзвэл Эмнести Интернэшнл нь анхаарлаа компаний үүрэг дээр биш компаний хариуцлага дээр ч гэсэн хандуулсан нь тодорхой болно. Харин тусгай төлөөлөгчийн ажил нь зөвхөн компаний үүрэг рүү чиглэсэн байна.

## 7. Ямар бэрхшээл тулгарч байна вэ?

Компаниудад Төрийн бус байгууллагууд, тэр дундаа Эмнести Интернэшнл ямар нөлөө үзүүлснийг яг дүгнэж хэлэхэд хэцүү. Хүний эрхийг зөрчиж байгаа компаниудыг цаашид ч мөрдөж мөшгинө гэдэг нь ойлгомжтой. Тэгсэн ч сүүлийн хэдэн арван жил хүний эрхэд хандуулах анхаарал асар ихээр нэмэгдсэн гэдгийг нь хүний эрхийг компаниуд үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлснээс харж болно. Бизнес ба Хүний эрхийн нөөцийн төвөөс хүний эрхийг бодлоготоо албан ёсоор

тусгасан компаниудын жагсаалтыг авч болно. Энэ нийтлэлийг бичиж байх үед жагсаалтанд нийт 289 компани бүртгэгджээ. Энэ нь жишээ нь 38 компанитай байсан найман жилийн өмнөх үеийг бодвол хамаагүй өндөр тоо ч гэсэн нийт 80,000 Үндэстэн дамнасан корпорац, өөр сая сая жижиг компаниуд бий гэж бодоод үзэхэд үнэхээр бяцхан тоо билээ. Гэсэн ч энэ жагсаалтанд дэлхийн хамгийн том Үндэстэн дамнасан корпорацууд багтаж байгаагаас гадна энэ 289 компаний олонх нь хүний эрхийн бодлогын үйл ажиллагаагаа Төрийн бус байгууллагуудын хяналтан доор явуулж байна. Хэдий тийм ч хүний эрхийн зөрчил дэх компаний оролцооны талаарх сүүлийн үеийн илтгэл, тайлангаас харахад хийх ажил бас л их байгаа нь ойлгомжтой юм.

Эмнести Интернэшнлийн өмнө юу хүлээж байгааг харвал, Эмнести өөр өөр түвшинд үйл ажиллагаагаа зэрэг явуулах шаардлагатай нь тодорхой болно. Компаниудын муу нөлөөллийг анхаарлын төвд байлгах нь бусад зарчим, шаардлагуудыг ч гэсэн өндөр түвшинд байлгах шаардлагыг бий болгосон. Эмнести Интернэшнл нь хөгжил, цаг уурын өөрчлөлт, аюулгүй байдал зэрэг гол асуудлуудыг бүгдийг нь хүний эрх талаас нь тодорхойлж авч үзэх ёстой. Тусгай төлөөлөгч Раггигийн гурван баганат тодорхойлолт олны дэмжлэгийг хүлээсэн болохоор энэ нь ойрын хугацаанд гол тулгуурт тооцогдох болов уу. Тиймээс энэ хэсгээр Эмнести Интернэшнлд тусгай төлөөлөгчийн тодорхойлсон гурван баганын зүгээс ямар саад бэрхшээл тулгарч болохыг тодорхойлохыг оролдсон юм. Засгийн газрын хамгаалах үүрэг, компаниудын хүний эрхийг хүндлэх үүрэг, хохирогчдын эрхийн талаар.

*Тусгай төлөөлөгч Засгийн газруудад компаний буруутай үйлдлээс ард иргэдээ хамгаалах үүрэгтэйг нь сануулсан.* Компани

болон хүний эрхийн асуудалд засгийн газрын оролцоо хамгийн бага буюу огт байхгүй байдгийг дүгнэж болно. Эмнести Интернэшнл Засгийн газруудад хүний эрхийн олон улсын хуулийн дагуу компаниудад зохицуулалт хийж, арай идэвхитэй оролцохыг шахаж байх хэрэгтэй. Тусгай төлөөлөгчийн удирдамж нэгэн чухал зүйлийг орхигдуулсан нь толгой компанийх нь үйл ажиллагаа явуулж байгаа улсын үүрэг оролцоо юм. Хэдийгээр тэдгээр улсууд компанийн хүний эрхийн хариуцлага бий болоход компаниудад эерэг нөлөөлөх чадвартай, зарим талаар бүр үүрэгтэй. Тэгэх хэд хэдэн ч арга зам бий. Тухайн компаний гадаадад байдаг охин компаний буруутай үйл ажиллагааны хохирогч нь тухайн улсад толгой компанийг нь хариуцлагад татах бололцоог олгож болно. Мөн цаашилбал компаний хүний эрхийн асуудлыг ил тод байлгах талаар тайлан, мэдээгээ ирүүлж байх тухай шаардлага тавьж болно. Жишээ нь, АНУ-ын бохир ашигт малтмалын зарчим (1502-р зүйл)-д заасан жишээг бусад салбаруудад хуулбарлан ашиглаж болох юм. Эмнести Интернэшнл нь угаас зохицуулалтын зарим нэг сул талыг олж мэдсэн учир боловсруулах үе шатнаасаа илүү хяналтын байр сууринд шилжих хэрэгтэй. Жишээ нь Европын Холбооны түвшинд эзэлж байгаа байр суурь шигээ. Хүчинтэй байгаа ямар ч зохицуулалтын үр дүн нь олон нийтэд тодорхой байж л үр дүнг нь үнэлж болдог.

*Тусгай төлөөлөгчийн удирдамжийн удаах багана буюу хүний эрхийг хүндлэх компаний үүрэг нь чамгүй олон* Үндэстэн дамнасан корпорацид мөрдөгдөж эхэлсэн. Гэсэн тэдгээр компаниуд дэлхийн нийт компаний өчүүхэн бяцхан хэсэг нь л болохыг бид ойлгох хэрэгтэй. Эмнести Интернэшнл нь цаашид ятгалга, шаардлагатай бол тэмцлийн аргуудаа ашиглан улам олон

компанийг хүний эрхийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлахад хүргэх ёстой. Жишээ нь Эмнести Интернэшнл өмгөөллийн үйл ажиллагааныхаа хүрээнд Хятад улсад ийм санаачлага маш их чухлыг тодруулсан. Бизнес ба хүний эрхийн нөөцийн төвөөс гаргасан жагсаалтад хүний эрхийг албан ёсоор бодлогодоо тусгасан нийт 289 компани дотор нэг ч Хятад компани байхгүй. Африк гэх мэтийн сөргөлдөөн ихтэй, засаглал султай, хүний эрхийн зөрчил гарах магадлал хамгийн өндөр газруудад Хятадын компаниуд улам өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгааг бодохоор их сэтгэл эмзэглүүлж, санаа зовоосон асуудал болж таарч байгаа юм. 2007 онд Ирене Хаан цохон гэмдэглэснээр “Тэр тив дээрх “хүний эрхийн мөр” –өө цэвэр байлгая гэж Хятадын засгийн газар ч, компаниуд нь ч боддоггүй” ажээ. Африкт үйл ажиллагаа явуулж байгаа Хятадын компаниуд нийгмийн хариуцлагын асуудлыг бодолцож эхэлсэн байж магадгүй гэсэн таамаг дэвшсэн. Тэгсэн ч хятадын компаниудтай холбоотой хүний эрхийн зөрчлийн асуудал, хятад корпорацуудын хүний эрхэнд халтай дэглэм бий болгосон тухай мэдээлэл тасралтгүй хөвөрсөөр л байна.

Хариуцлагаа ухамсарлах хүсэлтэй байгаа компаниуд өсч байхад тэдэнд зөвлөх үйл ажиллагаанаасаа гадна Эмнести Интернэшнл одоогийн болон ирээдүйн үндэстэн дамнасан хувийн зохицуулалтын дэглэмд хүч хөдөлмөрөө зарцуулах ёстой. Жишээ нь Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын Зарчим гэдэг хувийн зохицуулах дэглэмийг сахиулах хүчин байхгүй гэж олон нийт шүүмжилж байсан. Хувийн дэглэмийг туйлын сайн дурын байхаар тогтооно гэдэг бас ч тийм ухаалаг санаа биш юм. Сайн дурын оролцоо ч гэсэн хууль зүйн үндэслэл болдог. Жишээ нь хүний эрхийн

асуудлыг гэрээндээ тусгаж болох юм. Хувийн үндэстэн дамнасан зохицуулалтын нэмэлт үнэ цэнэ нь сайн дурын санаачлага нь урт хугацаанд сулрах хандлагатай бол зохицуулалт нь тасралтгүй ажиллагаатай байж болно. Хүний эрх, аюулгүй байдлын сайн дурын Зарчим жишээ нь, удирдамжийг гэрээ хэлцэлдээ тусгахыг шаарддаг. Энэхүү хууль зүйн үндэслэлгүй шаардлага компани болон үйлчлүүлэгч хоорондын гэрээнд тусгагдаад ирэхээрээ хууль зүйн үндэслэлтэй болдог учир тиймэрхүү хувийн зохицуулалт нь эцэстээ олон улсын гэрээ хэлэлцээрээс илүү хүчтэй, нөлөөтэй байх боломжтой. Тиймээс Төрийн бус байгууллагуудын цэвэр хувийн ч бай, холимог ч бай аргаар стандарт жишиг тогтоох ажил нь зөөлөн шаардлагын хэлбэрээс “хатуу” эрх зүйн үүрэг болж хувирдагаараа сонирхолтой. Эрх зүйн үүргийг компаниудад бий болгох ёстой засгийн газруудын үүрэг нь Төрийн бус байгууллагуудын хөөцөлдөх шаардлагатай асуудлуудын нэг мөн. Үүгээр зогсохгүй сайн дурын оролцоо эрх зүйн реформын суурь хөрс болж ч болох юм. Өөрөөр хэлбэл цэвэр сайн дурын үндсэн дээр гарч ирсэн санаачлагыг илүү эрх мэдэлтэй түвшинд хар зураг болгон ашиглаж болно. Сайн дурын, зохион байгуулалттай алхмууд аль хэдийн хийгдсэн ил тод байдлын шаардлагын асуудал дээр ихээхэн ахиц гарсан.

Сайн дурын олон олон санаачлагуудын чухал нөөц бололцоо хэдий их ч ямар ч сайн дурын жишгийг дагадаггүй, заримдаа бүр ноцтой төрлийн гэмт хэрэгт орооцолддог байгууллагуудыг сөхрүүлэхийн тулд ташуурдах шаардлага зүй ёсоор урган гарж байна. Тиймээс Эмнести Интернэшнл зөвхөн компаний үүрэгт чиглэсэн биш, компаний хариуцлагыг бий болох үйл ажиллагаагаа олон улсын хуульд баттай суурилуулан явуулах хэрэгтэй. Компаниудад эрх зүйн

шаардлага онооход чиглэж байгаа олон улсын хуулийг улам боловсронгуй болгох ажил маш чухал. Компани ба хүний эрхийн тухай асуудал нь цэвэр сайн дурын мөн чанарт хүчтэй тулгуурласан нийгмийн хариуцлагын хөдөлгөөнүүдэд дарагдаад хууль зүйн жишиг, үйл явц болгох ажил саатаад байгаа юм. Компаний хариуцлагын тухай асуудлыг тууштай орхигдуулсан тусгай төлөөлөгчийн ажил ч үүнийг баталгаажуулсан билээ. Эмнести Интернэшнл хүний эрхийг хэрэгжүүлэх ажиллагаа нь сайн дурын асуудал биш болохыг тодруулж өгөх шаардлагатай. Гол санаа нь Эндрью Клапамын хэлснээр “Хүний эрх бол нэг орж, нэг гарч байж болдог асуудал биш” юм.

*Эцэст нь Тусгай Төлөөлөгчийн удирдамжийн гуравдах багана буюу шударга шүүхийг нээлттэй болгох тухай асуудал* дээр ч Эмнести Интернэшнлд хэд хэдэн бэрхшээл тулгарна. Үндэстэн дамнасан хүний эрхийн хариуцлага улам чанарах төлөвтэй ч олон хохирогч хохирсон хэвээр л байна. Эмнести Интернэшнл маш чухал үүрэг гүйцэтгэх ёстой. **Нэгдүгээрт**, Эмнести Интернэшнл өргөн хүрээний сүлжээгээрээ гомдол мэдүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Учир нь дан ганц хувь хүнээс Төрийн бус байгууллага нь энэ талын маргаанд олон талын давуу талтай байдаг. Түүгээр зогсохгүй Эмнести Интернэшнл нь хохирогчид Үндэстэн дамнасан корпорацуудтай заргалдахад үндэсний болон бүс нутгийн түвшинд тулгардаг бэрхшээлүүдийг арилгахад анхаарах шаардлагатай. Жишээ нь Европын орнуудын шүүхийн байгууллагатай харилцаа холбоогоо сайжруулж, шударга ёсыг бий болгох зарчмыг засагладаг, олон улсын хууль гэдэг утгаараа Европын зохицуулалтын ихэнхийнх нь үндэс болсон Европын Холбооны хуулинд ч гэсэн төстэй нэмэлт өөрчлөлт оруулах тал дээр ажиллах

ёстой. Реформ бий болгох кампанит ажил ямар үр дүнтэй байх тухай ганц жишээ дурдахад Европын зохицуулалт нь одоогоор Европын Холбооны гишүүн орнуудын шүүх дээр тус орны компаний салбар байдаг буюу гэрээтэй ажилладаг гуравдагч орнуудын компаниудын эсрэг зарга мэдүүлэх боломж одоогоор байхгүй байна.

## 8. Дүгнэлт

Дэлхий даяар компани ба хүний эрхийн асуудлыг манлайлан хэрэгжүүлж байгаа этгээд нь яах аргагүй Төрийн бус байгууллагууд юм. Эмнести Интернэшнл ч энэхүү үйл ажилд голлох үүрэгтэй оролцож, томоохон Үндэстэн дамнасан корпорацуудтай хүний эрхийн асуудлаар хэлэлцээр хийж эхэлсэн анхны Төрийн бус байгууллагуудад нэг болсон юм. Түүнээс хойш Эмнести Интернэшнл нь компаниудын хүний эрхийн анхаарлыг сайжруулах олон олон санаачлагад идэвхитэй оролцож иржээ. Гэсэн ч Эмнести Интернэшнл гэх мэт Төрийн бус байгууллагуудад хийх ажил ихийн дээр олон түвшинд нэгэн зэрэг үйл ажиллагаа явуулж, компани, олон улсын

байгууллагууд, улс орнуудтай бүгдэнтэй нь харилцаж, өнөөг хүртэл олсон амжилтаа бататгах хэрэгтэй. Энэхүү нийтлэлд өмнө нь тулгарч байгаа бэршээлүүдээс заримыг нь дурдсан. Гэхдээ сүүлийн шинжилгээнд хэдийгээр өнөөг хүртэл чамгүй ололттой ажилласан ч хувийн хэвшлийнхэн бүгд одоо ч гэсэн хүний эрхэнд халтай үйлдэл хийсээр л байна. Тиймээс Эмнести Интернэшнлийн үйл ажиллагаа нь цаашдаа компаний зөвхөн үүрэг тал руу нь биш компаниуд хийсэн үйлийнхээ хариуцлагыг хүлээдэг байхад төвлөрч ажиллавал зохистой. Компаний хүний эрхийн хариуцлагын асуудал нь зарим талаар хэт холын асуудал мэт боловч олон улсын хуулийг өргөтгөж, төрийн оролцоогүй байгууллагуудыг зохицуулдаг ирээдүй болох нь зайлшгүй юм. Сүүлийн хэдэн арван жилд олон улсын түвшинд гэмт хэргийн хариуцлагын талд томоохон алхамууд хийгдэж, түүнтэй төсөөтэй боломжууд байгааг харуулжээ. Дараагийн 50 жилийг төсөөлөн харвал Эмнести Интернэшнлийн гол төвлөрөх ёстой асуудлын нэг нь компаниудын хүний эрхийн зөрчлийн асуудал байх нь ойлгомжтой билээ.

Монгол хэлнээ орчуулсан  
О.Гомбожав

Эх сурвалж:  
Amnesty International 50 Years:  
Reflections and Perspectives, published Utrecht, 2011.  
ISBN/EAN: 978-90-39357071, NUR-code: 828

ЦИН.МН  
СЭДАЛГААНЫ САН

## Зочны яриа

## “ЭРҮҮ ШҮҮЛТИЙН ХЭЛБЭРИЙГ МЭДЭХГҮЙ УЧРААС ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖОО БОЛОВСРОНГУЙ БОЛГОХГҮЙ БАЙНА”



*“Хүний эрх” сэтгүүл энэ удаагийн “Зочны яриа” булангийн зочноороо УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны чиглэлийн ахлах мөрдөн байцаагч М.Гэрэлбадрахыг урьж ярилцлаа. УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба нь манай улс дахь эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийг шалгах, илрүүлэх эрх бүхий цорын ганц байгууллага юм.*

**Гэнэн гэмээр асуултаар ярилцлагаа эхэлье. Манай улсад эрүү шүүлт бий юү? Эрүү шүүлтэд өртсөн тухай гомдол танайд хэр их ирдэг вэ?**

Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэгт холбогдож буй хүмүүсийг эрүүдэн шүүх хэлбэрээр хэрэг хүлээлгэх тохиолдол, эрүү шүүлт байгаа юу гэдэг асуудал олон жил яригдаж байна. Энэ асуудалд хариулт өгөх байгууллага бол Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн Байцаах Алба. Манай байгууллага 2003 оноос хойш өнөөдрийг хүртэл зөвхөн эрүү шүүлтийн чиглэлээр нийт 349 гомдол мэдээллийг шалгасан байдаг. Эдгээрээс 48-д нь эрүүгийн хэрэг үүсгэсэн.

Тэгэхээр Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан эрүү шүүлт тулгасан гэх үндэслэлээр ийм тооны хэрэг үүсгэнэ гэдэг бол Монгол Улсад эрүүдэн шүүх явдал байна, эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийг мөрдөх, шалгах эрх бүхий цорын ганц байгууллага нь ажиллагаа явуулж байгааг нотолж байна. Манайд 2012 оны байдлаар эрүү шүүлттэй холбоотой 67 гомдол ирсэн, үүнээс 4-т нь эрүүгийн хэрэг үүсгэж, 5-ыг нь холбогдох байгууллагад шилжүүлсэн, үлдсэнд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. Эндээс үзвэл эрүү шүүлт байна гэсэн үг.

**Эрүү шүүлттэй холбоотой мэдээллийг шалгаж, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд та бүхэнд ямар бэрхшээл тулгардаг вэ?**

Улсын хэмжээнд эрүү шүүлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, хэргийг шалгаж, иргэдээс гомдол мэдээллийг хүлээн авч, эрүүгийн хэрэг үүсгэж шалгалтын ажиллагаа явуулж байгаа. Олон улсын гэрээ конвенцуудад заасан үндэслэлээр бол манай улсад өнөөдөр дагаж мөрдөж буй Эрүүгийн хууль шаардлага хангадаггүй юм. Жишээлбэл, манай Эрүүгийн хуулиар бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гэсэн субъектийн хүрээнд л эрүү шүүлттэй тэмцэж байгаа болохоос Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид заасан чиглэлээр дэлгэрэнгүй тусгаагүй.

Тэгэхээр энэ зүйл заалтаар бол асар хязгаарлагдмал. Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйл заалт нь маш явцуу байдаг. Манай байгууллага эрүү шүүлттэй холбоотой



гомдол мэдээллийн хувьд бол хязгаарлагдмал хүрээнд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг явуулж байгаа. Энэ бол хууль, эрх зүйн зохицуулалт талаасаа тулгарч буй бэрхшээл юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, тарчилган зовоох, тохуурхан даажигнах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж байгаа тохиолдолд л эрүү шүүлт болох юм. Зөвхөн дээрх чиглэлээр хязгаарлагдаад байцаан шийтгэх ажиллагаа эхлэхээс өмнөх буюу хэрэг хүлээсэн, үйлдсэн эсэхийг тогтоох зорилгоор хуулийн өөр субъектүүд ажиллагаа явуулахдаа эрүү шүүлтийг бий болгож байгаа. Тухайлбал, эрүүгийн төлөөлөгч нар. Гэвч хуулиндаа нөгөө л хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гээд заагаад өгчихсөн болохоор эрүүгийн төлөөлөгчийг эрүү шүүлт тулгасан гэх заалтаар асуудлыг шийдвэрлэх ямар ч боломжгүй. Тэгэхээр эрүү шүүлтийг хаана бий болгож байна?. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу ажиллагаа явуулахаас өмнө гүйцэтгэх ажиллагааны явцад эрүү шүүлтийг тулгаж байгаа нь нууц биш.

**Манай Хүний эрхийн Үндэсний Комиссет ирж байгаа өргөдөл, гомдлын багагүй хувийг эрүү шүүлтэд өртсөн гэх гомдол эзэлдэг. Өнөөдөр эрүү шүүлтийг таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсдэд хариуцлага тооцох эрх зүйн орчин хэр хангалттай байна гэж үздэг вэ?**

Эрх зүйн орчин бүрдээгүй. Эрүү шүүлт тулгасан албан хаагч нарт хууль эрх зүйн хүрээнд хариуцлага тооцох, эрүү шүүлт тулгах гэмт хэргийг шүүх, прокурорын шатанд шийдвэрлэх практик тогтоох, ямар тохиолдол, хэлбэрийг эрүү шүүлт гэж үзэх вэ зэрэг шүүн таслах ажиллагааны чиглэлээр хараахан нэг мөр болоогүй асуудлууд байна.

Практик бий боллоо ч, үндэсний хууль тогтоомжоо өөрчлөөгүй цагт зодож нүдэж байгаад мэдүүлэг авдаг ч юм уу, иймэрхүү үндэслэлүүдэд 251 дүгээр зүйл заалтаа барьж ажиллана. Түүнээс биш, далд үйлдэлтэй хийгдэж буй эрүү шүүлт тулгах гэмт хэргийг Монгол Улсад прокурор, шүүхийнхээ шатанд хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх практик тогтоогүй, хуулийг зөв хэрэглэх талаар ямар нэг аргачилсан зааварчилгаа алга. 251 дүгээр зүйлийн талаар Улсын дээд шүүхээс ямар нэгэн тайлбар байдаггүй.

**Эрүү шүүлтийн ямар хэлбэрүүд манай оронд байгаа бол?**

Хуурч мэхэлж мэдүүлэг авах, мэдүүлэг өгөхийг албадах, гүйцэтгэх ажиллагааны шугамаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс мэдээлэл цуглуулах зорилгоор зодож дарамтлах, камер дамжуулан хорих, онц хүнд гэмт хэрэгтэнтэй нэг дор байлгах зэрэг хэлбэрүүд байна. Энэ бол далд хэлбэрийн эрүү шүүлт. Өрөөндөө дуудаад “чи бол ялтан, энд гарын үсэг зур” гээд сууж байгаа бол мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч хүн илт өөрийн үйл ажиллагаа явуулахдаа эрүү шүүлт тулгаж байгаа хэлбэр. Түүнээс биш энэ нөхөр хэргээ хүлээхгүй байна гээд эрүүгийн төлөөлөгчид хүлээлгэж өгөөд эрүүгийн төлөөлөгч нь өөр өрөөнд оруулаад зодож, нүдээд, камер дамжуулж хориод явж байгаа нь далд, нуугдмал байгаа хэлбэрүүд.

**Түүх сөхвөл монголчууд “есөн эрүү тулгах” зэрэг уламжлалт үг хэллэг, эрүү шүүлтийн хүнд хэлбэрийг хэрэглэж байсан гашуун сургамжтай ард түмэн. Тэгвэл өнөөдөр цаг үеэ дагаад хүн хоорондын харилцаанаас ангид эрүү шүүлтийн хэлбэрүүд байх болж. Жишээлбэл, хорих байрны болон бусад орчны нөхцөл байдал, тухайлбал нэг хүнд оногдох орон**

**байрны талбайн хэмжээ, агааржуулалт, чийгшүүлэлт зэрэг нь хэвийн хэмжээнд биш байгааг “нөхцлийн эрүү шүүлт” гэж үздэг. Нөхцлийн эрүү шүүлт үүссэн тохиолдолд танайх яаж шийдвэрлэдэг вэ?**

Бид Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлээ л хардаг.

**Өөр эрх зүйн баримт бичгийг харгалзахгүй юу?**

Өөр юм харахгүй, өнөөдөр мөрдөж буй хуулиа л дагана. Хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж, тарчилган зовоох, тохуурхан даажигнаж, хуурч мэхлэх... энэ төрлүүд дээр бид ажилладаг. Түүнээс биш таны хэлж буй нөхцлийн эрүү шүүлт болон бусад хэлбэрийн эрүү шүүлт дээр ажиллах боломжгүй. Бид үндэсний хууль тогтоомжид зааснаас бусад эрүү шүүлтийн тохиолдлыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн заалтыг үндэслээд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг журамлаад өгч үзсэн. Шийдэгддэггүй юм байна лээ. Конвенцийн зүйл заалтыг үндэслээд, Эрүүгийн хуулийн 251 дүгээр заалтаас гадуур гэм буруугаа хүлээчихсэн хүн байхгүй.

**Манай улс НҮБ-ын Эрүү шүүлтийн эсрэг конвенцид хэдийнэ нэгдээд орчихсон. Одоо Эрүү шүүлтийн эсрэг нэмэлт протоколд нэгдэн орох асуудал яригдаж, ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа. Гэтэл Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж хэлж болохоор санагдлаа?**

Танай Хүний эрхийн Үндэсний Комисс эрүү шүүлт байна, эрүү шүүлтийг таслан зогсооё гээд тэмцээд байдаг. Гэтэл бидний шалгаад, шүүх, прокурорын шатанд явуулж байгаа хэрэг дээр ямар нэг практик бий болохгүй байгаа нь харамсалтай. Олон улсын гэрээ, конвенцид заасан эрүү шүүлтийн

хэлбэрүүд Монгол Улсад байсаар байхад хуулиндаа яагаад оруулж өгөхгүй байна вэ гэдэг бол асуудал.

**Эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийг танайх шалгаж, илрүүлэх ажиллагааг явуулдаг. Харин энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ямар ажил хийдэг вэ? Манай 5 байгууллагын хамтарсан Санамж бичгийн хэрэгжилт хэр байгаа бол?**

Улсын Ерөнхий Прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хамтран ажиллах Санамж бичиг байдаг. Санамж бичиг эхний 3 жилдээ амжилттай хэрэгжсэн, дахин сунгасан. Эрүү шүүлтээс ангид байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ 5 байгууллага тус бүртээ тодорхой ажлуудыг хийсэн. Манай байгууллагын хувьд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хууль зүйн хүртээмж ба Хүний эрх” төсөлтэй хамтраад шүүн таслах ажиллагааны гэмт хэрэг, тэр дундаа эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Монгол Улсын хэмжээнд нийт гурван бүсэд хууль, хяналтын байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулсан. Ингэхдээ эрүү шүүлтийн талаарх анхан шатны мэдлэг ойлголтын талаарх тандалт судалгааг явуулсан. Судалгаанд гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийг оролцуулсан. Судалгааны дүнг Санамж бичгийн хүрээнд зохион байгуулсан ажлыг дүгнэх Ажлын хэсэгт танилцуулж баталгаажуулсан байгаа.

**Дагаж мөрдөж буй үндэсний хууль тогтоомжийн зүйл заалт өнөөдрийн хэрэгцээ, шаардлагатай нийцэхгүй байгааг Улсын Ерөнхий Прокурорын газраас хууль тогтоох байгууллага, холбогдох**

**албан тушаалтны сонорт хүргэсэн болов уу. Манай Комисс лав энэ талаар “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэл”-дээ зөвлөмж болгон хэдэнтээ оруулсан байдаг?**

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, энэ хуулийн 251 дүгээр зүйлийг өөрчлөх талаар манайх байнга санал хүргүүлдэг. Харамсалтай нь тэр саналууд огт биелдэггүй. Яагаад энэ заалтад өөрчлөлт оруулаад явж болдоггүй юм бүү мэд энэ бас нэг асуултын тэмдэг байгаад байдаг юм.

**Яг ямар албан тушаалтанд хандсан бэ?**

Энэ албан бичгийг олон улсын байгууллагуудад, Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн төслийн удирдагч, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны даргад явуулж байсан байна.

**7 жил өнгөрөхөд байдал өөрчлөгдөөгүй гэж үү?**

Дорвитой өөрчлөгдөөгүй.

**Албан бичиг хүргүүлсэн албан тушаалтанг нэр устай нь хэлэх боломжтой юу?**

Тухайн үеийн УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Мөнх-Оргилд явуулсан байх юм. Эрүүгийн хуулийн зүйл заалтыг дагаж мөрдөхөд гарч байгаа хүндрэл бэрхшээлийн чиглэлийг явуулсан. “Тус хуулийн 251 дүгээр зүйлийн субъект нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байхаар хуульчилсан нь байцаан шийтгэх үйл ажиллагаанд гэмт хэргийг илрүүлэх үүрэгтэй оролцдог эрүүгийн цагдаагийн ажилтнууд хүний эрхийг ноцтойгоор зөрчдөг, албадан тайлбар, тодорхойлолт авч, хууран мэхлэх, дарамтад оруулах зэргээр хэрэг хүлээлгэдэг үйлдлийг дээрх зүйл ангиар зүйлчлэх боломжгүй байна” /албан бичгийг уншиж

өгөв./ гэсэн хүсэлт тавьж байсан. Энэ мэтээр манайх хууль эрх зүйн чиглэлийн гаргалгаа, авах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, ер нь өөрөөс шалтгаалах бүхнээ хийсэн.

**Таны туршлагад тулгуурлан асуухад эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийг бууруулахын тулд цаашид ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?**

Эрүүдэн шүүх чиглэлийн гэмт хэргийн тоог бууруулах, таслан зогсоох үндэслэл байна уу, байна. Зөндөө олон арга байгаа. Эрүү шүүлтийн талаарх мэдлэг ойлголтыг иргэд, албан тушаалтнуудад өгөх. Түүнчлэн мөрдөн байцаах ажиллагааны арга барил, тактикийг оновчтой явуулах, орчин үеийн техник, технологийг энэ салбарт хэрэглэх ёстой.

Гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоохын тулд сэжиглэгдэж буй хүнийг дуудаж авчраад “Чи тэгсэн байна, үйлдсэн хэргээ ярь” гэж загнаж, зодож, сэтгэл зүйн дарамтад оруулж хэрэг хүлээлгэх арга, тактикаас бид салах ёстой юм. Шинжлэх ухаан технологийн ололтой талыг ашиглаж, тухайн хүнийг ярихаас өмнө хэргийг нотлох баримтаар илрүүлэх, криминалистикийн болон шүүх шинжилгээний бусад баримтуудыг хэрэгт хэрхэн уялдуулах, одоо манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар явагдаж байгаа мөрдөн байцаалтын ажиллагааны 90 хувь нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчдын мэдүүлэг байна.

Энэ мэдүүлгийг бид мөрдөн байцаалтын шатандаа авч, нотлох баримт болгон ашигладаг бол гадаад улс орнуудад мөрдөн байцаагч мэдүүлэг авахгүй шүү дээ. Хэргийг энэ хүн гэрчилнэ, тэр мэдээллийг гаргаж өгөх тогтолцоотой. Худал мэдүүлэг өгвөл хуулийн хариуцлага хүлээн гэдгийг сануулаад, шүүхэд мэдүүлэг өгдөг. Бид мөрдөн байцаалтын ажиллагаандаа орчин

үеийн арга, техникийг ашигладаг болсноор эрүү шүүлтийг багасгах боломжтой юм. Үйлдэл дээрээ баригдах, хэргийг үйлдснээс хойш олон сар, жилийн дараа баригдсан бол өөр зүйл. Энэ 2 тохиолдолд хэрэглэх арга, техник газар тэнгэр шиг зөрүүтэй. 100 хэргийн 1 нь л үйлдэл дээрээ баригддаг.

Гэмт хэрэг үйлдчихээд, хулгай хийчихээд хэргийн газар дээр зогсох тохиолдол ховор. Тэгэхээр мөрдөн байцаалт явуулах арга барил, хэрэг илрүүлэх, мөрдөх чиглэлд шинжлэх ухааны аргыг хэрэглэх, байгаа бол орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах, түүнчлэн эрх зүйн орчинг шинэчлэх шаардлагатай юм.

**Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдсан цагаасаа эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийг шалгаж, жил бүрээр тоо баримт хуримтлуулсан байж таарна. Мөрдөн байцаах ажиллагааны хоцрогдсон арга барил нь эрүү шүүлт үүсгэх шалтгаан болж байна гэж ойлгож болох уу?**

Нэг жишээ авъя. Хулгайн хэрэг үйлдсэн, өмнө нь хулгайч байсан хүн байдаг. Нэг хэрэг гарлаа. Гэтэл “За, энэ нөхөр бол рецедив хулгайч, өмнө нь хулгайн гэмт хэргээр ял шийтгэгдсэн, тийм учраас тэр нөхрийг Ганцад аваачиж хорино”. Энэ эрүү шүүлтийн нэг хэлбэр мөн үү, мөн. Гэтэл тэр хүн хулгай хийгээгүй байвал яах юм. Эрүүгийн төлөөлөгчид эзэнгүй баахан хэргээ нөгөө хүнд тохдог. Олон сар, жилээр хорьдог, хоригдоод ирэхээрээ шантардаг, ар гэрээ санадаг. Үндэслэлгүйгээр, шахалтаар хийгээгүй хэрэг хүлээдэг.

Нэг нөхрийг хорьж саатуулаад 15-20 үйлдэлтэй хэргийг хуурамчаар хүлээлгэсэн. Нөгөөх хүн түр чөлөөгөөр гараад ар гэрийнхэнтэйгээ уулзаад буцаж орсныхоо дараа бүх мэдүүлгээсээ буцаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдол бий. Энэ бол эрүү шүүлтийн сонгодог хэлбэр.

Өөр бусад төрлийн гэмт хэрэг үйлдснээр нь шалтаглан эрүүдэн шүүж болохгүй. Цагдан хориод шалгаж байна гэж байна. Энэ бол эрүү шүүлтийн бас нэг хэлбэр. Гарцаагүй байдалд ороод хүнийг хорьчихдог. 1 сар байцаалт авахгүй, 2 сар өнгөрлөө уулзахгүй, дараа нь “За, чи хэргээ ярьчих” гэж тулгаж байгаа нь эрүү шүүлт. Өөр төрлийн гэмт хэрэг тулган хүлээлгэж байгаа нь харамсалтай.

**Эрүү шүүлтийн талаарх ойлголт, нэр томъёоны хувьд маргаантай асуудал хэвээрээ байгаа тохиолдолд эрүү шүүлт байсаар байж магадгүй юм?**

Эрүү шүүлттэй тэмцэхээр Санамж бичиг байгуулан хамтран ажиллаж буй дээр дурдсан 5 байгууллага дотроо эрүү шүүлтээс ангид байх хэмжээний журам заавар, дотоод дүрмийг боловсруулан мөрдөж хэвших хэрэгтэй. Өөрсдөөсөө эхэлнэ гэсэн үг. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр оновчтой ажиллах ёстой. Хуулийн байгууллагууд, хууль баталдаг хууль тогтоогч нар ч эрүү шүүлтийн талаарх ойлголтоо нэг мөр болгох ёстой. Өнөөдөр хууль тогтоогчид маань эрүү шүүлтийн талаар таны хэлсэн шиг “9 эрүү” мэтээр хүлээн авч, гарт нь дөнгө зүүж, хуруу хумсанд нь мод хатгаад хэргээ хүлээ гэж тулгаж байгааг эрүү шүүлт гэж ойлгоод байдаг. Түүнээс биш нийгэмд эрүү шүүлтийн яг ямар хэлбэр байгааг хууль тогтоогчид ойлгохгүй байгаагаас үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгоход анхаарахгүй байна. Эрүү шүүлтийн талаар хамгийн сонгодог тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид заагаад өгчихсөн байгаа.

**Цаг зав гаргаж ярилцсанд баярлалаа.**

**Ярилцсан:** З.Бадмаараг /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хэвлэл мэдээлэл хариуцсан референт/

**Хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенц**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2013 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх  
Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлийг  
хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн санал, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлд дурдсан санал, зөвлөмжийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ нь:**

1. Хүний эрхийн Үндэсний Комиссын 11 дэх илтгэлтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хууль болон “Цагдан хоригдсон болон хорих ял эдэлж байгаа этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журам”, “Иргэд, байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”, “Баривчлах, цагдан хорих байрны

дотоод журам”, “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох тухай” дүрэм, журмыг олон улсын стандарт болон үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн боловсронгуй болгох, холбогдох тогтоол, дүрэм, журамд мониторинг хийж ажиллах;

2/ Баривчлах ял эдлүүлэх байрыг шинээр барих асуудлыг шийдвэрлэх;

3/ Ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй ялтнуудын группын хугацааг сунгах зэрэг нийгмийн халамжийн асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх, тэдгээр хүмүүст тохирсон ажлын байр бий болгох, цалин хөлс олгох тал дээр тусгайлан анхаарах;

4/ Ялтны хөдөлмөр эрхлэх, цалин хөлс авах эрхийг хангах, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх асуудлыг судалж, дэс дараатай шийдвэрлэх, ялтныг аливаа албадан хөдөлмөр хийлгэх зэрэг зөрчлийг таслан зогсоох;

5/ Цагдан хорих болон хорих байрны стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр баталж улсын хэмжээнд мөрдүүлэх, дууны болон дүрс бичлэгийн техник хэрэгслээр бүрэн хангаж тоноглох;

6/ Хоригдлуудад зориулсан нийгэмшүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах тусгай өрөө тасалгаа бий болгох;

7/ Төрийн байгууллагын алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эмэгтэй албан хаагчийн хувьд ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг төрөл бүрийн дарамт учруулахаас урьдчилан сэргийлэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх чиглэлээр анхаарч ажиллах;

8/ Хөнгөвчлөх /хоспис/ тусламж, үйлчилгээ үзүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, монгол хүний бие махбод, сэтгэл зүйн онцлог, гэр бүлийн нийгэм, эдийн засгийн байдалд нийцсэн, хүртээмжтэй, үр нөлөөтэй, чанартай тогтолцоо бүхий хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

9/ Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох;

10/ Сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан асрамжийн газар байгуулах асуудлыг нэн даруй шийдвэрлэх.

2. Энэ тогтоолын биелэлтийн явцын талаар 2013 оны 3 дугаар улиралд багтаан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд мэдээлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Ш.Түвдэндорж/, Хүний эрхийн дэд хороо /Д.Ганбат/ хяналт тавьж ажилласугай.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ш.ТҮВДЭНДОРЖ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



## ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРОМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн тавин долдугаар чуулганы 2002 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн A/Res/57/199 дүгээр тогтоолоор баталж, 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Нью-Йорк хотноо байрлах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төв Байранд 2003 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс (Протоколын эх бичвэрийг үйлдсэн өдөр) эхлэн энэхүү протоколд гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах болон түүнд нэгдэн орох боломжтой.

### ОРШИЛ

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх нь хүний эрхийг ноцтой зөрчдөг бөгөөд ийм үйлдлийг хориглох ёстой гэдгийг дахин нотолж,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц (цаашид “Конвенц” гэнэ)-ийн зорилгод хүрэх болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэхийн тулд өөр олон арга хэмжээ авах шаардлагатай гэдэгт итгэл төгс байж,

Конвенцийн 2, 16 дугаар зүйлүүд нь оролцогч улс бүрт өөрийн харьяа нутаг дэвсгэртээ эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлээс урьдчилан сэргийлэх талаар үр нөлөөтэй арга хэмжээ авах үүрэг болгосныг дахин нотолж,

Тэдгээр зүйлийг хэрэгжүүлэх нь оролцогч улсын үндсэн үүрэг болохыг болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрхийн хамгаалалтыг бэхжүүлэх, тэдгээрийн хүний эрхийг сахих нь бүх нийтийн үүрэг бөгөөд олон улсын байгууллага үндэсний арга хэмжээг бэхжүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрч,

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс үр нөлөөтэй урьдчилан сэргийлэхэд боловсролыг дээшлүүлэх болон хууль тогтоох, захиргааны, шүүхийн болон бусад арга хэмжээг хослуулан авах шаардлагатай эргэн санаж,

Хүний эрхийн Дэлхийн Бага хурлаас эрүү шүүлтийг устгахад чиглэсэн арга хэмжээ нь нэн тэргүүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд чиглэгдэх ёстой гэдгийг шийдвэртэй мэдэгдэн, хорих байрыг тогтмол эргэж байх урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зорилготой Конвенцийн нэмэлт протоколыг батлахыг уриалсныг эргэн санаж,

Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг

эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг хамгаалалтыг тэдгээрийн хоригдож буй газрыг тогтмол эргэх үндсэн дээр шүүхийн бус урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч улам бэхжүүлж болно гэдэгт итгэл төгс байж,

Дараах зүйлийн талаар хэлэлцэн тохиролцов:

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Нийтлэг үндэслэл

#### 1 дүгээр зүйл

Энэхүү протоколын зорилго нь олон улсын болон үндэсний бие даасан байгууллага эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн байгаа газарт нь тогтмол эргэж очих тогтолцоог бий болгоход оршино.

#### 2 дугаар зүйл

1. Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны дэргэд энэхүү протоколд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс Урьдчилан сэргийлэх дэд хороо (цаашид “Урьдчилан сэргийлэх дэд хороо” гэнэ)-г байгуулна.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн үйл ажиллагаагаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн хүрээнд явуулж, түүний зорилго, зарчмыг болон эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон хэм хэмжээг удирдлага болгоно.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороо нь нууцлалыг хадгалах, шударга ёсыг эрхэмлэх, сонгож харьцахгүй байх, нийтлэг болон бодит байдлаар хандах зарчмыг мөн удирдлага болгоно.

4. Урьдчилан сэргийлэх дэд хороо болон оролцогч улсууд энэхүү протоколыг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллана.

#### 3 дугаар зүйл

Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх /цаашид “үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага” гэнэ/ зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

#### 4 дүгээр зүйл

1. Энэхүү протоколд заасны дагуу оролцогч улс бүр төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу, эсхүл түүний санаачилгаар, эсхүл түүний ил далд зөвшөөрснөөр хүнийг хорьсон эсхүл хорьсон байж болзошгүй өөрийн харъяа болон хяналтанд байдаг нутаг дэвсгэрт хамаарах аль ч газарт (цаашид “хорих газар” гэнэ) энэхүү протоколын 2, 3 дугаар зүйлд заасан байгууллагууд очихыг зөвшөөрөх үүрэгтэй. Ийнхүү очих нь дээрх хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах зорилготой байна.

2. Энэхүү протоколын хүрээнд “эрх чөлөөгөө хасуулсан” гэж хувь хүнийг шүүхийн, захиргааны болон эрх бүхий

бусад байгууллагын шийдвэрээр тухайн хүн өөрийн хүслээр орхин явах боломжгүй цагдан хорих, хорих эсхүл харуул хамгаалалт бүхий нийтийн болон хувийн газар байлгахыг хэлнэ.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

#### Урьдчилан сэргийлэх дэд хороо

##### 5 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 10 гишүүнтэй байна. Протоколыг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон 50 дахь бичиг баримтыг хадгалуулсаны дараа Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийн тоог 25 болгоно.

2. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг өндөр ёс суртахуунтай, шүүн таслах ажиллагааны салбарт, тэр дундаа эрүүгийн эрх зүй, хорих болон цагдаагийн байгууллагын удирдах салбарт хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшлийн дадлага туршлагатай, эсхүл эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй ажилладаг салбарт мэргэшсэн хүмүүсээс сонгоно.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороог бүрдүүлэхдээ газар зүйн тэгш хуваарилалт болон оролцогч улсуудын харилцан адилгүй соёл иргэншил, эрх зүйн тогтолцооны тэнцвэртэй төлөөллийг хангах тал дээр онцгой анхаарна.

4. Энэ бүтцэд мөн жендэрийн төлөөллийг эрх тэгш байх, үл ялгаварлан гадуурхах үндсэн дээр аль болох тэнцвэртэй хангах ёстой.

5. Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүрэлдхүүнд нэг оролцогч улсын хоёр иргэн байж болохгүй.

6. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нь өөрийн нэрийн өмнөөс хороонд ажиллах бөгөөд хараат бус, шударга байж, Хороонд үр нөлөөтэй ажиллах боломжийг бүрдүүлнэ.

##### 6 дугаар зүйл

1. Оролцогч улс бүр энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу протоколын 5 дугаар зүйлд заасан шаардлага, болзлыг хангасан, зохих мэргэшлийн хоёроос илүүгүй нэр дэвшигчийг дэвшүүлж, тэдгээрийн мэргэшлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлнэ.

2. (a) Нэр дэвшигчид нь энэхүү протоколд оролцогч улсын иргэн байна;

(b) Хоёр нэр дэвшигчийн нэг нь заавал нэр дэвшүүлж байгаа оролцогч улсын иргэн байна;

(c) Нэг оролцогч улсын хоёроос илүүгүй иргэний нэрийг дэвшүүлж болно;

(d) Оролцогч улс өөр оролцогч улсын иргэнийг нэр дэвшүүлэх тохиолдолд тухайн улсын зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

3. Сонгууль болох оролцогч улсуудын хурал эхлэхээс наад зах нь 5 сарын өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга оролцогч улсуудад захидал илгээж 3 сарын дотор нэр дэвшүүлэхийг санал болгоно. Ерөнхий нарийн бичгийн дарга ийнхүү нэр дэвшсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг үсгийн дарааллаар нэр дэвшүүлсэн оролцогч улсуудын хамт гаргаж оролцогч улсуудад хүргүүлнэ.

##### 7 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг дараах журмаар сонгоно:

(a) Энэхүү протоколын 5 дугаар зүйлд

заасан шаардлага, болзлыг хангасан эсэхийг нэн тэргүүнд авч үзнэ;

(b) Анхны сонгуулийг энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор явуулна;

(c) Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг оролцогч улсууд нууцаар санал хурааж сонгоно;

(d) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга 2 жил тутам зарлан хуралдуулдаг оролцогч улсуудын хурлаас Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүдийг сонгоно. Оролцогч улсуудын гуравны хоёрын оролцоотой санал хураалт явуулах бөгөөд хуралдаанд оролцож санал өгсөн оролцогч улсын төлөөлөгчдийн хамгийн олон бөгөөд дийлэнх олонхийн санал авсан хүмүүсийг Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнээр сонгоно.

2. Сонгуулийн явцад нэг оролцогч улсын хоёр иргэн нэгэн зэрэг Урьдчилан сэргийлэх дэд хороонд сонгогдох боломжтой болвол илүү олон тооны санал авсан нэр дэвшигчийг Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнээр сонгоно. Хоёр нэр дэвшигч нь тэнцүү тооны санал авсан нөхцөлд дараах журам үйлчилнэ:

(a) Хоёр нэр дэвшигчээс зөвхөн нэгийг нь түүнийг харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол тухайн иргэн нь Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнээр сонгогдоно;

(b) Хоёр нэр дэвшигчийг хоёуланг нь тэдгээрийг харьяалах оролцогч улс дэвшүүлсэн бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хурааж аль иргэн нь гишүүн болохыг тодруулна;

(c) Хоёр нэр дэвшигчийн хэнийг нь ч тэдгээрийг харьяалах оролцогч улс дэвшүүлээгүй бол нэр дэвшигч тус бүр дээр нууцаар санал хурааж гишүүн болох нэр дэвшигчийг тодруулна.

### 8 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн нас барах, огцрох буюу бусад шалтгаанаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүний нэрийг дэвшүүлсэн оролцогч улс энэхүү протоколын 5 дугаар зүйлд заасан шаардлага, болзлыг хангасан, зохих мэргэшилтэй, энэ албан тушаалд тохирох өөр хүнийг оролцогч улсуудын олонхи нь баталсан нөхцөлд оролцогч улсуудын дараагийн хурал хуралдах хүртэл ажиллуулахаар эрх мэдлийн зохих тэнцвэрийг хадгалах шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр дэвшүүлнэ. Нэр дэвшүүлсэн тухай мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаас хүлээн авснаас хойш 6 долоо хоногийн дотор оролцогч улсуудын тэн хагас хувь буюу түүнээс дээш хувь нь нэр дэвшигчийг эсэргүүцээгүй тохиолдолд түүнийг батлагдсан гэж үзнэ.

### 9 дүгээр зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүнийг 4 жилийн хугацаагаар сонгоно. Нэрийг нь дахин дэвшүүлбэл тэд улиран сонгогдох эрхтэй. Анхны сонгуулиар сонгогдсон гишүүдийн тал хувийнх нь бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд анхны сонгуулийг явуулж дуусмагц эдгээр гишүүний нэрийг энэхүү протоколын 7 дугаар зүйлийн 1 (d) хэсэгт заасан хуралдааны дарга шодож тогтооно.

### 10 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн ажилчдыг 2 жилийн хугацаагаар сонгоно. Тэд дахин сонгогдож болно.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн үйл ажиллагааны журмыг тогтооно. Энэ журамд дараах зүйлийг заана:

(a) Хуралдааны ирц гишүүдийн олонх ирснээр бүрдэнэ;

(b) Урьдчилан сэргийлэх дэд хорооны шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана;

(c) Урьдчилан сэргийлэх дэд хороо хаалттай хуралдана.

3. Урьдчилан сэргийлэх дэд хорооны анхны хуралдааныг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга зарлан хуралдуулна. Энэхүү хуралдааны дараа Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн үйл ажиллагааныхаа журамд заасан хугацаанд хуралдана. Урьдчилан сэргийлэх дэд хороо болон Эрүүдэн шүүхийн эсрэг хороо жилд нэгээс доошгүй удаа нэгэн зэрэг хуралдана.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### Урьдчилан сэргийлэх дэд хорооны бүрэн эрх

#### 11 дүгээр зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо дараах бүрэн эрхийг эдэлнэ:

(a) 4 дүгээр зүйлд дурдсан газруудад нэвтрэх, оролцогч улсуудад эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалахтай холбоотой зөвлөмж өгөх;

(b) Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын тухайд:

(i) Оролцогч улсуудад зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд ийм байгууллага байгуулахад нь тусалцаа үзүүлэх;

(ii) үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагатай шууд, шаардлагатай тохиолдолд нууц холбоотой байж

гэдгээрийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор сургалт явуулж, техникийн туслалцаа үзүүлэх;

(iii) эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах явдлыг хүчтэй болгох хэрэгцээ болон аргаа тодорхойлоход нь зөвлөгөө өгч, тусламж үзүүлэх;

(iv) эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх үндэсний байгууллагын чадавхийг сайжруулах, бүрэн эрхийг бэхжүүлэх талаар оролцогч улсуудад зөвлөмж, дүгнэлт өгөх;

(c) Эрүүдэн шүүх явдлаас ерөнхийд нь урьдчилан сэргийлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох байгууллага болон хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг хамгаалалтыг бэхжүүлэх чиглэлээр ажилладаг олон улсын, бүс нутгийн болон үндэсний байгууллагуудтай хамтран ажиллах.

#### 12 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хороонд 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж олгохын тулд оролцогч улсууд:

(a) Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн нутаг дэвсгэр дээр хүлээн авах болон энэхүү протоколын 4 дүгээр зүйлд заасан хорих газарт нэвтрэх боломжийг олгоно;

(b) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс

хамгаалах явдлыг хүчтэй болгох зорилгоор авах арга хэмжээ болон хэрэгцээг үнэлэхэд шаардлагатай бүх мэдээллийг Урьдчилан сэргийлэх дэд хороо шаардсан үед нь гаргаж өгнө;

(с) Урьдчилан сэргийлэх дэд хороо болон үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын хоорондын харилцааг бэхжүүлж, түүнд дэмжлэг үзүүлнэ;

(d) Урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмжийг судалж, зөвлөмжтэй холбоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хороотой хэлэлцээ хийнэ.

### 13 дугаар зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улсуудад тогтмол очиж ажиллах хөтөлбөрөө хэрэгжүүлэх дарааллаа эхний удаа шодож тогтооно.

2. Оролцогч улсууд Урьдчилан сэргийлэх дэд хороо ирэхтэй холбогдуулан шаардлагатай практик арга хэмжээ авахад хүрч болзошгүй тул Урьдчилан сэргийлэх дэд хороо оролцогч улсуудтайгаа зөвлөлдсөний дараа гэдэнд өөрийн хөтөлбөрийн талаар нэн даруй мэдээлнэ.

3. Урьдчилан сэргийлэх хорооны хоёроос доошгүй гишүүн үзлэг хийх ажлыг гүйцэтгэнэ. Шаардлагатай тохиолдолд эдгээр гишүүдийг энэ протоколд заасан салбарт мэргэжлийн туршлага, мэдлэгтэйгээ харуулсан шинжээч дагалдаж болно. Шинжээчийг оролцогч улсууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, Олон улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төвөөс санал болгосны дагуу гаргасан шинжээчдийн нэрсийн жагсаалтаас сонгоно. Энэ нэрсийн

жагсаалтыг гаргахад холбогдох оролцогч улсууд 5-аас илүүгүй тооны өөрийн иргэнийг шинжээчээр дэвшүүлж болно. Үзлэг явагдах оролцогч улс айлчлалын бүрэлдхүүнд багтсан тодорхой шинжээчийг нэр заан татгалзаж болно. Энэ тохиолдолд Урьдчилан сэргийлэх дэд хороо өөр шинжээчийг санал болгоно.

4. Шаардлагатай гэж үзвэл Урьдчилан сэргийлэх дэд хороо ээлжит үзлэг хийсний дараа богино хугацааны нэмэлт үзлэг хийж болно.

### 14 дүгээр зүйл

1. Урьдчилан сэргийлэх дэд хороонд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгох зорилгоор оролцогч улсууд түүнд дараах баталгааг олгоно:

(a) 4 дүгээр зүйлд заасан хорих газарт хоригдож байгаа хүмүүсийн тоо, хорих газрын тоо болон байршлын талаарх бүх мэдээллийг чөлөөтэй авах;

(b) Тэдгээр хүмүүстэй харьцаж байгаа байдлын талаар болон тэдгээрийн хоригдож байгаа нөхцлийн талаарх бүх мэдээллийг чөлөөтэй авах;

(c) Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд бүх хорих газар, барилга, байшинд чөлөөтэй нэвтрэх;

(d) Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй ямар ч гэрч байлцуулалгүйгээр ганцаарчилан эсхүл шаардлагатай тохиолдолд орчуулагчийн хамт уулзаж, ярилцлага хийх болон Урьдчилан сэргийлэх дэд хорооны үзэж байгаагаар хэрэгтэй мэдээлэл өгч магадгүй гэсэн аливаа этгээдтэй уулзах боломжтой байх;

(e) Очих хүсэлтэй газар болон ярилцлага хийх хүсэлтэй хүнээ чөлөөтэй сонгох эрхтэй байх.



2. Улсын батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, байгалийн гамшиг эсхүл хорих газарт очиход саад болж буй түр зуурын шинжтэй эмх замбараагүй байдал зэрэг гэнэтийн эсхүл хангалттай үндэслэл бүхий шалтгааны улмаас тодорхой хорих газарт очихыг эсэргүүцэж болно. Ийм төрлийн онцгой байдал зарласан байгаа явдлаа оролцогч улс үзлэгийг эсэргүүцэх үндэслэл болгох ёсгүй.

#### *15 дугаар зүйл*

Урьдчилан сэргийлэх дэд хороо, эсхүл түүний төлөөлөгчид мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан аливаа шийтгэл ногдуулах, үүрэг өгөх, шийтгэл ногдуулах эсхүл эдлүүлэхийг зөвшөөрөх ёсгүй. Тухайн хувь хүн, байгууллагыг ямар нэгэн байдлаар хавчих ёсгүй.

#### *16 дугаар зүйл*

1. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн зөвлөмж, ажиглалт дүгнэлтийг оролцогч улсад, шаардлагатай бол үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад нууцаар илгээнэ.

2. Урьдчилан сэргийлэх дэд хороо оролцогч улс ийм хүсэлт гаргасан тохиолдолд өөрийн илтгэлийг тухайн хүсэлт гаргасан оролцогч улсын тайлбарын хамт нийтэлнэ. Оролцогч улс илтгэлийн зарим хэсгийг ил тод болговол Урьдчилан сэргийлэх дэд хороо илтгэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийтэлж болно. Гэхдээ хувь хүний тухай мэдээллийг түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй.

3. Урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн ажлын жил бүрийн тайланг Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд гаргаж өгнө.

4. Хэрэв оролцогч улс 12, 14 дүгээр зүйлүүдэд заасан ёсоор Урьдчилан сэргийлэх дэд хороотой хамтран ажиллахаас, эсхүл түүнээс өгсөн зөвлөмжид заасны дагуу нөхцөл байдлыг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ авахаас татгалзвал Эрүүдэн шүүхийн эсрэг хороо оролцогч улс татгалзсан үндэслэлийнхээ талаар байр сууриа илэрхийлэх боломжтой хугацаанд илэрхийлээгүй бол Урьдчилан сэргийлэх дэд хорооны хүсэлтээр энэ асуудлаар нийтэд зориулсан мэдэгдэл хийх, эсхүл Урьдчилан сэргийлэх дэд хорооны тайланг нийтлэх шийдвэр гаргаж болно.

### **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ** **Үндэсний урьдчилан сэргийлэх** **байгууллага**

#### *17 дугаар зүйл*

Энэхүү протокол хүчин төгөлдөр болсноос, эсхүл түүнийг соёрхон баталснаас, эсхүл түүнд нэгдэж орсноос хойш нэг жилийн дотор оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэг болон түүнээс дээш байгууллагыг байгуулах, томилох эсхүл түүнд дэмжлэг үзүүлж болно. Төвийн биш байгууллагаас байгуулсан урьдчилан сэргийлэх байгууллага нь энэхүү протоколын шаардлагыг хангаж байвал үндэсний байгууллагаар томилогдон ажиллана.

#### *18 дугаар зүйл*

1. Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага, түүний ажилтан чиг үүргийнхээ хувьд хараат бус байх нөхцлийг хангана.

2. Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын шинжээчид шаардлагатай ур чадвар,

мэдлэг эзэмшсэн байх явдлыг хангах арга хэмжээ авна. Мөн эмэгтэйчүүд, тухайн улсын угсаатны болон цөөнхийн бүлэг энэ байгууллагад тэнцүү төлөөлөлтэй байх явдлыг хангана.

3. Оролцогч улсууд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг хариуцна.

4. Үндэсний урьдчилсан сэргийлэх байгууллагыг үүсгэн байгуулахдаа оролцогч улс хүний эрхийг хамгаалах, дэмжих үндэсний байгууллагын статус болон үйл ажиллагааны зарчмыг харгалзаж үзнэ.

#### *19 дүгээр зүйл*

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад наад заах нь дараах эрхийг олгоно:

(a) 4 дүгээр зүйлд заасан хорих газарт хоригдож байгаа хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах явдлыг бэхжүүлэх зорилгоор эдгээр хүмүүстэй хэрхэн харьцаж байгаа байдлыг тогтмол шалгах;

(b) Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй харьцах, тэдгээрийн байгаа нөхцлийг сайжруулах болон эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох хэм хэмжээг харгалзан холбогдох байгууллагад зөвлөмж явуулах;

(c) Мөрдөж байгаа хууль болон боловсруулж байгаа хуулийн төсөлд санал, дүгнэлт өгөх.

#### *20 дугаар зүйл*

Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг хангах үүднээс энэхүү протоколд оролцогч улсууд эдгээр байгууллагад дараах баталгааг олгоно:

(a) 4 дүгээр зүйлд дурдсан хорих газарт хоригдож байгаа хүмүүсийн тоо, хорих газрын тоо болон байршлын талаарх бүх мэдээллийг чөлөөтэй авах;

(b) Тэдгээр хүмүүстэй харьцаж байгаа байдлын талаар болон тэдгээрийн хоригдож байгаа нөхцлийн талаарх бүх мэдээллийг чөлөөтэй авах;

(c) Бүх хорих газар, барилга, байшинд чөлөөтэй нэвтрэх;

(d) Эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй ямар ч гэрч байлцуулалгүйгээр ганцаарчилан эсхүл шаардлагатай тохиолдолд орчуулагчийн хамт уулзаж, ярилцлага хийх болон Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын үзэж байгаагаар хэрэгтэй мэдээлэл өгч магадгүй гэсэн аливаа этгээдтэй уулзах боломжтой байх;

(e) Очих хүсэлтэй газар болон ярилцлага хийх хүсэлтэй хүнээ чөлөөтэй сонгох эрхтэй байх;

(f) Урьдчилан сэргийлэх дэд хороотой холбоотой байх, түүнд мэдээлэл өгөх болон хорооны хүмүүстэй уулзах эрхтэй байх.

#### *21 дүгээр зүйл*

1. Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагад мэдээлэл өгсөн хувь хүн, байгууллагад тэр мэдээлэл нь үнэн, худлыг эс харгалзан ямар ч эрх бүхий байгууллага, албан тушаалтан аливаа шийтгэл ногдуулах, үүрэг өгөх, шийтгэл ногдуулах эсхүл эдлүүлэхийг зөвшөөрөх ёсгүй. Тухайн хувь хүн, байгууллагыг ямар нэгэн байдлаар хавчих ёсгүй.

2. Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын цуглуулсан нууц мэдээллийг ил тод болгох ёсгүй. Хувь хүний тухай мэдээллийг түүний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр нийтлэх ёсгүй.

#### 22 дугаар зүйл

Оролцогч улсын холбогдох эрх бүхий байгууллага үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын зөвлөмжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар түүнтэй хэлэлцээр хийнэ.

#### 23 дугаар зүйл

Энэхүү протоколд оролцогч улс үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын жил бүрийн тайлан, илтгэлийг хэвлэн нийтлэх, нийтийн хүртээл болгох үүрэг хүлээнэ.

### ТАВДУГААР ХЭСЭГ

#### Мэдэгдэл

#### 24 дүгээр зүйл

1. Оролцогч улс энэхүү протоколыг соёрхон батлахдаа протоколын Гурав, Дөрөвдүгээр хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлэхээ тодорхой хугацаагаар хойшлуулах тухай мэдэгдэл хийж болно.

2. Хойшлуулах энэхүү мэдэгдэл нь хамгийн дээд тал нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байна. Оролцогч улс зохих материалыг бүрдүүлж өгснөөр Эрүүдэн шүүхийн эсрэг хороо Урьдчилан сэргийлэх дэд хороотой зөвшилцөж энэ хугацааг дахин хоёр жилийн хугацаагаар сунгаж болно.

### ЗУРГАДУГААР ХЭСЭГ

#### Санхүүгийн холбогдолтой заалт

#### 25 дугаар зүйл

1. Энэхүү протоколыг хэрэгжүүлэх

явцад Урьдчилан сэргийлэх дэд хорооноос гаргасан зардлыг Нэгдсэн Үндэстний Байгууллага хариуцна.

2. Энэхүү протоколийн дагуу Урьдчилан сэргийлэх дэд хорооны ажил үүргийг үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай ажилтан болон бусад бололцоогоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хангана.

#### 26 дугаар зүйл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн зохих журмын дагуу Тусгай санг байгуулна. Энэ санг Нэгдсэн Үндэстний Байгууллагын санхүүгийн дүрэм, журмын дагуу захиран зарцуулж, Урьдчилан сэргийлэх дэд хороо оролцогч улсад очсоны дараа гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагыг дэмжих, сургалтын хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулна.

2. Тусгай санг Засгийн газар, засгийн газар хоорондын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн болон төрийн байгууллагын сайн дурын хандиваар санхүүжүүлнэ.

### ДОЛДУГААР ХЭСЭГ

#### Төгсгөлийн заалт

#### 27 дугаар зүйл

1. Энэхүү протокол нь Конвенцид гарын үсэг зурсан аливаа улсын хувьд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү протоколыг Конвенцийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон аливаа улс соёрхон батлана. Батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү протокол нь Конвенцийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэж орсон аливаа улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

4. Нэгдэн орох батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар хүчинтэй болно.

5. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколд гарын үсэг зурсан, эсхүл нэгдэн орсон бүх улсад өөрт нь хадгалуулахаар ирүүлсэн протоколыг соёрхон баталсан эсхүл түүнд нэгдэн орсон батламж жуух бичиг бүрийн талаар мэдэгдэнэ.

#### *28 дугаар зүйл*

1. Энэхүү протокол нь хорь дахь соёрхон баталсан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь соёрхон баталсан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш энэхүү протоколыг соёрхон баталсан буюу нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн энэхүү протокол хүчин төгөлдөр болно.

#### *29 дүгээр зүйл*

Энэхүү протоколын заалт нь Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг бүх улсад ямар нэгэн хязгаарлалт, хөнгөлөлтгүйгээр нэгэн адил үйлчилнэ.

#### *30 дугаар зүйл*

Энэхүү протоколд ямар нэгэн тайлбар хийхгүй.

#### *31 дүгээр зүйл*

Энэхүү протоколын заалтууд нь хорих газрыг тогтмол эргэх тогтолцоог бий болгож буй аливаа бүс нутгийн конвенцийн дагуу оролцогч улсын хүлээсэн үүрэгт нөлөөлөхгүй. Урьдчилан сэргийлэх дэд хороо болон бүс нутгийн конвенцийн дагуу байгуулагдсан байгууллага нь үйл ажиллагааны давхардлаас зайлсхийх, энэ протоколын зорилгод хүрэх үүднээс зөвшилцөх, хамтран ажиллах шаардлагатай.

#### *32 дугаар зүйл*

Энэхүү протоколын заалт нь 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн 4 конвенц, тэдгээрийн 1977 оны 6 дугаар сарын 8-ны нэмэлт протоколын дагуу оролцогч улсын хүлээсэн үүрэг болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр зохицуулаагүй тохиолдолд аливаа оролцогч улс хорих газартаа очих зөвшөөрлийг Улаан загалмайн нийгэмлэгийн Олон улсын хороонд өгөхөд нөлөөлөхгүй.

#### *33 дугаар зүйл*

1. Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэн энэхүү протоколыг хэдийд ч цуцалж болно. Цуцлах тухай мэдэгдлийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протокол болон Конвенцийн оролцогч бусад улсуудад мэдэгдэнэ. Цуцлалт нь Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Ийнхүү цуцлах нь цуцлалт хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө үүссэн үйлдэл эсхүл нөхцөл байдалтай холбоотойгоор энэхүү протоколын дагуу хүлээх үүргээс эсхүл Урьдчилан сэргийлэх дэд хорооноос

тухайн оролцогч улсад өгсөн эсхүл өгөх үүргээс тухайн оролцогч улсыг чөлөөлөхгүй. Түүнчлэн цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнө Урьдчилан сэргийлэх дэд хороонд хэлэлцэж байсан асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэхэд цуцлалт саад болохгүй.

3. Оролцогч улсын хувьд цуцлалт хүчин төгөлдөр болсны дараа Урьдчилан сэргийлэх дэд хороо тухайн улсад холбогдох шинэ асуудлыг авч хэлэлцэхгүй.

#### 34 дүгээр зүйл

1. Энэхүү протоколд оролцогч аливаа улс түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болох бөгөөд энэ тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга уг саналыг оролцогч улсуудын сонорт хүргэж, тэдгээрийг хэлэлцэж санал хураах оролцогч улсуудын бага хурал хуралдуулах саналтай эсэхээ мэдэгдэхийг хүснэ. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 4 сарын дотор оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй нь бага хурал хуралдуулах хүсэлт гаргавал хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор зарлан хуралдуулна. Ерөнхий нарийн бичгийн дарга бага хуралд оролцож санал өгсөн оролцогч улсуудын олонхийн саналаар батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрүүлэхээр оролцогч бүх улсад илгээнэ.

2. Энэхүү протоколд оролцогч улсуудын гуравны хоёр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг үндэсний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрснөөр уг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

3. Хүчин төгөлдөр болсон нэмэлт, өөрчлөлтийг түүнийг хүлээн авсан оролцогч

улс заавал дагаж мөрдөнө. Харин бусад оролцогч улс энэхүү протоколын заалт болон өмнө нь хүлээн авсан нэмэлт, өөрчлөлтийг хэвээр дагаж мөрдөнө.

#### 35 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны болон үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагын гишүүд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх ямба, дархан эрх эдлэнэ. Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд 1946 оны 2 дугаар сарын 13-нд батлагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх ямба, дархан эрхийн тухай Конвенцийн 22 дугаар зүйлд заасан дархан эрх, эрх ямбыг уг конвенцийн 23 зүйлд заасан нөхцлийг хангасны үндсэн дээр эдлэнэ.

#### 36 дугаар зүйл

Урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд оролцогч улсад очихдоо энэхүү протоколын заалт, зорилго болон өөрийн эрх ямба, дархан эрхийг хөндөхгүйгээр:

(а) Очсон орны хууль тогтоомжид хүндэтгэлтэй хандана;

(b) Өөрсдийн хүлээсэн үүргийн олон улсын шинж чанар, шударга байх мөн чанарт үл нийцэх аливаа үйлдэл, үйл ажиллагаанд оролцохоос таггалзана.

#### 37 дугаар зүйл

1. Энэхүү протоколын араб, хятад, англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

2. Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү протоколын багалгаат хуулбарыг бүх улсад хүргүүлнэ.